



This project is funded
by the European Union.

Төслийн Санхүүжүүлэгч Европын холбоо

Боловруулж, эмхэтгэсэн:

Д.Адьяасүрэн /Гадаад худалдааны инженер, эдийн засагч/

Н.Отгонсайхан /Эдийн засагч/

Б.Эрдэнэчимэг /Бараа судлаач/

Хэвлэх хэмжээ: В5 /176x250мм/

Хэвлэлийн хуудас: 11 х.х



“Эрдэнэзул” ХХК-д
хэвлэв.

ХУДАЛДААНЫ СТАНДАРТ (Гарын авлага)

АГУУЛГА

Оршил	4
1. Худалдаа, үйлчилгээний хууль, эрх зүйн зохицуулалт	5
1.1. Худалдааны салбарын хууль, эрх зүйн зохицуулалт	5
1.2. Үйлчилгээний салбарын хууль, эрх зүйн зохицуулалт	40
2. Худалдаа, үйлчилгээний нийтлэг журам	100
3. Худалдааны стандарт	106
3.1. Худалдааны газрын нэр, томъёо	106
3.2. Жижиглэн худалдааны газрын стандарт	110
3.3. Үйлчилээний газрын стандарт	128



ОРШИЛ

Монгол Улсын үндэсний худалдааны эх үүсвэр эд хэрэглэгчдийн анхны Ардын харилцан туслалцах хоршоог 1921 оны 12 дугаар сарын 16-нд 116 гишүүнтэйгээр байгуулагдсанаар түүхэн суурь тавигдсан билээ.

Уг хоршоонд тухайн үеийн төр, нийгмийн зүтгэлтнүүд гишүүнээр элсэн улмаар улсаас санхүүгийн туслалцаа үзүүлэн хоршоо, худалдааг алхам алхмаар хөгжүүлж ирсэн түүхтэй. "Ардын харилцан туслалцах хоршоо"-ны гол зорилго нь мал аж ахуй, ангийн гаралтай түүхий эдийг гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх, үндэсний үйлдвэрүүдийг хөгжүүлэх, хүн амыг өргөн хэрэгцээний бараагаар хангах явдалд байсан юм.

Монгол Улсын худалдааны газар нь 1934 оны 4 дүгээр сард Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн худалдааны байгууллагуудын нэгтгэсэн суурь бааз дээр байгуулдсан байна. Мөн 1958 оны 11 дүгээр сард Худалдаа, бэлтгэлийн яамыг байгуулж, худалдаа, бэлтгэлийн асуудлыг бүхэлд нь хамааруулж, дэргэд нь эд хэрэглэгчдийн хоршооны залгамж-Худалдаа бэлтгэлийн ажилд туслах эд хэрэглэгчдийн нийгэмлэгийг сайн дурын үндсэн дээр байгуулжээ.

Худалдаа бэлтгэлийн яамны харъяанд бүх аймаг, хотын худалдаа, бэлтгэлийг удирдах газар, худалдаа, бэлтгэлийн бараа бааз, трест, анги, агент ажиллах болсон юм. Худалдааны байгууллагууд улам төгөлдөржиж 1970-1980 онуудад бөөний худалдааны нэгдэл, хүнсний болон гутлын бөөний худалдааны газрууд, бөөний худалдааны нэгдлийн дэргэд бүртгэлийн машинт станц бий болсон билээ.

Монгол Улсын Худалдааны салбар нь хүн амыг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр тогтвортой хангаж, дотоодын нийт бүтээгдэхүүний 17 хувийг эзэл дэг Монгол улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж буй томоохон салбар юм.

Дэлхий нийтийн хөгжил, хүн амын хэрэглээний чиг хандлагын өөрчлөлттэй уялдан манай улсад сүүлийн жилүүдэд олон улсын стандартад нийцсэн худалдаа, үйлчилгээний газрууд олноор бий болж, шинэ хэлбэр төрөл, дэвшилтэт техник технологи нэвтрүүлж байна. Эдгээрээс худалдааны салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 16.4 хувь, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн 39.6 хувийг бүрдүүлж манай улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг салбарын нэг юм. Түүнчлэн, худалдааны салбар нь хөдөлмөрийн зах зээлд онцгой үүрэг гүйцэтгэдэг салбаруудын нэг бөгөөд 2018 оны байдлаар тус салбарт 211.2 мянган хүн ажиллаж байна.

Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засаг илүү гадаад зах зээл рүү чиглэж, бараа бүтээгдэхүүнээ экспортлоход илүү анхаарах болно. Бараа бүтээгдэхүүнээ экспортлохын тулд нэн тэргүүнд олон улсад нийцсэн худалдааны салбарын стандартуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

1. ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Монгол Улс худалдааны үйл ажиллагааг зохицуулах бие даасан хуульгүй бөгөөд тодорхой хуулиудын зүйл, заалтаар хэсэгчлэн зохицуулж байна.

Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /www.legalinfo.mn/-д байршуулсан 640 хуулиас шүүлт хийхэд гадаад, дотоод худалдааг хэсэгчлэн зохицуулж буй 50 гаруй хууль¹ байгаа бөгөөд тэдгээрийг дараах байдлаар бүлэглэх

боломжтой байна. Үүнд:

- Ерөнхий зохицуулалтын хуулиуд: Иргэний хууль, Компанийн тухай, Хоршооны тухай, Нөхөрлөлийн тухай, Хэрэглэгчийн Эрхийг хамгаалах тухай, Өрсөлдөөний тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай, Зар сурталчилгааны тухай гэхмэт;
- Тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдаа, борлуулалтыг зохицуулсан хуулиуд: Архидан согтуурахтай тэмцэх тухай, Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Галт зэвсгийн тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Органик хүнсний тухай, Ховорсдон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн гадаад худалдааг зохицуулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай гэхмэт;
- Тодорхой салбарын худалдах, худалдан авах ажиллагааг зохицуулсан хуулиуд: Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай гэхмэт;
- Худалдааны бүс, тусгай дэглэмийн худалдааг зохицуулсан хуулиуд: Чөлөөт бүсийн тухай, Хилийн боомтын тухай;
- Бусад зохицуулалт: Өрийн удирдлагын тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай гэх мэт.

Худалдааны үйл ажиллагааг хэсэгчлэн зохицуулж буй дээрх хуулиудаас зөвхөн Иргэний хууль болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд худалдагч, худалдан авагч хоорондын харилцаа, хүлээх үүрэг хариуцлагын талаарх зохицуулалт тусгагдсан байна.


Гадаадын зарим улсын (Япон, БНХАУ) туршлагаас харахад бизнесийн байгууллагууд хоорондын худалдах, худалдан авах харилцааг зохицуулах, зах зээл дээр шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой “Жижиглэн худалдаачин, нийлүүлэгч хоорондын шударга хэлцлийн журам”, “Томоохон

¹ Монгол Улсын хуулиудад тусгагдсан дотоод худалдааг зохицуулсан зүйл, заалтуудыг Хавсралт 1-д нэгтгэн харуулав.

жижиглэн худалдаачид давамгай байр сууриа хортойгоор ашиглахаас сэргийлэх зохицуулалт”, “Туслан гүйцэтгэгчдийг дэмжих арга хэмжээ” зэрэг эрх зүйн зохицуулалтыг боловсруулан мөрдөж байна.

Монгол Улсын худалдааны салбарын төрийн бодлого

Монгол Улсад дотоод худалдааны салбарын бие даасан бодлого, төлөвлөлт, хөгжлийн баримт бичиггүй байна. Иймд улс орны хөгжлийн урт, дунд хугацааны дараах баримт бичгүүдэд худалдааны салбарын талаар баримтлах бодлого, зорилтыг хэрхэн тодорхойлсныг судалласан байна. Үүнд:



- A. Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг болох **Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал – 2030**;
- B. Дунд хугацааны буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бодлогын бичиг баримт болох **Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага**;
- C. Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бодлогын бичиг баримт болох **Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр**.

Эдгээр баримт бичигт худалдааны салбар хамааралтай дараах бодлого, зорилтууд тусгагджээ.

A. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030

Тус бодлогын баримт бичгийн Эдийн засгийн тогтвортой хөгжил хэсэгт эдийн засгийн салбарын хөгжлийн зорилтыг хангахдаа дараах зарчмыг баримтлахаар тусгажээ. Үүнд:

- Өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулах;
- Үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг эдийн засаг, нийгмийн бүх салбарт чанд баримтлах.

Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр баримтлах бодлогын зорилт 4-т “Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх”-ээр тусгасан ба I үе шат буюу 2016-2020 онд “Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, аймаг болон томоохон сумдын нисэх буудлыг хөгжүүлэх, ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх, Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлыг барьж дуусгах”-аар заажээ.

Бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр баримтлах бодлогын зорилт 1-д “Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлэх”-р тусгасан ба I үе шат

буюу 2016-2020 онд “Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 25 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах” зорилт дэвшүүлсэн байна.

В. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага

Энэхүү баримт бичигт тусгаснаар “Худалдаа, тээвэр логистикийн салбарт дэвшилтэт арга технологийг хэрэглэснээр бараан дах тээвэр логистикийн зардлыг дор хаяж 2 дахин бууруулна” гэсэн зорилт дэвшүүлж, энэ зорилтын хүрээнд төмөр зам дагасан дагуул хот сууринг түшиглэн шинэ ложистикийн төвийг Улаанбаатар хотын баруун /Эмээлт-Аргалант/, зүүн /Налайхын орчим/, урд /Аэросити/, хэсэгт тус тус байгуулахаар заажээ. Эдгээр ложистикийн төв буюу терминалиудыг байгуулснаар дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй цөөн тооны хүчин чадал багатай, өргөтгөх боломж хязгаарлагдмал, үйлчилгээний хүрээ явцуу, барилга байгууламж, тоног төхөөрөмж хуучирсан терминалиудыг хотоос гарган, оронд нь нийслэл хотыг олон улсын тээвэр ложистикийн үйлчилгээнд холбосон иж бүрэн үйлчилгээтэй нэгдсэн терминаль, тээвэр агуулахын цогцолбор бий болгох;
- Аюултай, хортой, тээвэрлэлт, хадгалалтын онцгой горим шаардах, бараа бүтээгдэхүүнийг хүн амын төвлөрлөөс зайдуу, аюулгүй ажиллагааны шаардлага, технологийн дагуу хадгалах, тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Тээвэрлэлтийн зохион байгуулалт, технологи ажиллагааны үр ашгийг сайжруулах, тээвэр агуулахын цогцолборын техник тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулна.

С1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт худалдаа, үйлчилгээний салбартай хамааралтай дараах зорилтууд тусгагдсан байна.

- 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ.
- “Үндэсний үйлдвэрлэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.
- Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.

Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах, шинэ хуулийн төсөл боловсруулахад эрх зүйн цахим мэдээллийн нэгдсэн санг ашиглах замаар хууль, эрх зүйн баримт бичгийн агуулга, уялдаа холбоог дээшлүүлнэ



Монгол Улсын хуулиудад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан зүйл, заалтууд

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
1	<p>АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ</p> <p>/шинэчилсэн найруулга/</p> <p>2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр</p>	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p><u>5 дугаар зүйл. Албан татвар төлөгч</u></p> <p>5.1.Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлогогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгж нь албан татвар төлөгч байна</p> <p>5.4.1.төлөөний газраараа дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж;</p> <p>5.5.Энэ хуулийн 5.4.1-т заасан аж ахуйн нэгжийн аж ахуйн үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчлэн явуулж байгаа дараахь нэгжийг төлөөний газарт хамааруулна:</p> <ul style="list-style-type: none"> • 5.5.1.салбар/цех, тасаг/; • 5.5.2.үйлдвэр; • 5.5.3.худалдаа, үйлчилгээний газар; <p>19.13.Доор дурдсан чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчид энэ хуулийн 19.12-т заасан хөнгөлөлт үзүүлэхгүй:</p> <p>19.13.2.согтууруулах ундаа худалдах, импортлох</p> <p>19.13.4.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх, автобензин, дизель түлшний худалдаа эрхлэх, импортлох;</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
2	<p>АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ</p> <p>2001 оны 2 дугаар сарын 01-ний өдөр</p>	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл</p> <p>15.5.2.галт зэвсэг, сум импортлох, нийгэд худалдах;</p> <p>15.5.5.галт зэвсгийн сум импортлох, нийгэд худалдах;</p> <p>15.6.1.озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах;</p> <p>15.6.3.тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх, ашиглах, худалдах, устгах;</p> <p>15.6.7.байгаль орчинд онцгой хор хөнөөл учруулж болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах, үйлчилгээ эрхлэх</p> <p>15.10.Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр:</p> <p>15.10.4.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, худалдах үйлдвэрлэх, тэсэлгээний ажил явуулах;</p> <p>15.10.17.бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх;</p> <p>15.11.6.ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах;</p> <p>15.12.2.хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, худалдах, импортлох;</p> <p>15.12.4.мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн утгвар бодис болон эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, импортлох, экспортлох;</p> <p>15.12.6.өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх;</p> <p>15.17.1.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах.</p> <p>15.18.8.цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх, импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.</p> <p>16 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл</p> <p>16.2.5.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;</p> <p>16.3.4.тамхи худалдах</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
3	<p>Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай</p>	<p>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрийг аюултай хог хаягдлаас хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>3 дугаар зүйл. Аюултай хог хаягдлын үндэсний тодорхойлолт</p> <p>3.1. Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцид тодорхойлсны дагуу хүн, амьтны эрүүл мэнд, үр удамд сөргөөр нөлөөлж, тэдгээрт өвчин эмгэг үүсгэдэг буюу байгаль орчны тэнцлийг алдагдуулдаг шинж чанар бүхий хог хаягдлыг аюултай гэж үзнэ.</p> <p>3.2. Тэсрэмтгий, шатамхай шингэн буюу хатуу, өөрөө шатдаг, цацраг идэвхт, хөрс, агаар, устай харилцан үйлчилснээс хортой, эсхүл галын аюултай хий ялгаруулдаг, исэлдүүлэгч, идэмхий, органик хэт ислийн хаягдал нь аюултай хог хаягдалд хамаарна.</p> <p>4 дүгээр зүйл. Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох</p> <p>4.1. Аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.</p> <p>4.2. Аюултай хог хаягдлыг Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэхийг хориглоно.</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
4	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай	1.1. Энэ хуулийн зорилт нь амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	4 дүгээр зүйл. Хорио цээрийн хяналт, шалгалтад хамаарах зүйл 4.1. Энэ хуулийн хүрээнд дор дурдсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтад хамруулна: 4.1.1. бүх төрлийн сүүн тэжээлтэн тэжээвэр болон зэрлэг амьтан, хэвлээр явагч усны амьтан, шувуу, зөгий, тэдгээрийн үр, хөврөл үр, үржлийн өндөг; 4.1.2. мах, сүү, дайвар бүтээгдэхүүн, өөх, хүнсний өндөг, арьс, шир, яс, ноос, ноолуур, үс, өлөн, эвэр, туурай, шувууны өд, сөд, сарвуу, чив, засаа, залаа, цөс, булчирхай зэрэг амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн; 4.1.3. байгалийн болон таримал дээд, доод ургамал, мод, тэдгээрийн үр, суулгац, хэсэг; 4.1.4. үр тариа, төмс, хүнсний ногоо, өвс, тэжээл, үрлэн кофе, хөнгөн болон хүнсний үйлдвэрт хэрэглэгдэх ургамлын гаралтай бусад түүхий эд, ургамлын хатаадас, цуглуулга, тасалбар, зүсмэл мод, түүний хэсэг, бүх төрлийн жимс, жимсгэнэ, гурил, будаа, элсэн чихэр, амтлагч зэрэг ургамлын гаралтай аливаа зүйлс; 4.1.5. цус болон цусны ийлдэс, сийвэн; 4.1.6. ангийн олзвор; 4.1.7. төрөл бүрийн эмгэг төрүүлэгч хорхой, шавьж, бичил биетний өсгөвөр, биотехнологийн аргаар гарган авсан хувиргасан амьд организм; 4.1.8. амьтны хүүр, сэг, ялгадас, эмгэгт материал; 4.1.9. хөрс, хүлэр, чулуу; 4.1.10. тээврийн хэрэгсэл, чингэлэг, сав, баглаа боодол, чигжээс, зөөлөвч, дэвсгэр, хашлага, хөвөнгийн “хөөвөр”, амьтны тоног хэрэгсэл, уяа татлага.
5	Арбитрын тухай	1.1. Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаанд арбитрын ажиллагаа явуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
6	<p>Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай</p>	<p>1982 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Женев хотноо гарын үсэг зурсан “Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенци”-д Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.</p>	
7	<p>АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ</p> <p>2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр</p>		<p>4 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл</p> <p>4.3. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсэд тухайн чөлөөт бүсийн захирагч олгоно.</p> <p>6.2. Энэ хуулийн 5.1; 5.2; 5.3; 5.8; 5.9; 5.10-т заасан журмыг зөрчиж үйлдвэрлэсэн буюу импортолсон, эсхүл хяналтын шинжилгээ хийлгээгүй согтууруулах ундааг худалдаа, үйлчилгээнд гаргахыг хориглоно.</p> <p>6.3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, мөн зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэлгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулах байршлаа өөрчлөхийг хориглоно.</p> <p>6.4. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.</p> <p>6.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно.</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
8	Авто тээврийн тухай	Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, автотээвэрлэлт болон автотээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино	Ерөнхий зохицуулалт
9	Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хууль	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрийг аюултай хог хаягдлаас хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	4 дүгээр зүйл. Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох 4.1. Аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно. 4.2. Аюултай хог хаягдлыг Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэхийг хориглоно. 5 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг экспортлох зөвшөөрөл 5.1. Иргэн /Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамаарна/, хуулийн этгээд аюултай хог хаягдлыг экспортлож болно.
10	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай	Энэ хуулийн зорилт нь бараа, үйлчилгээний тэмдэг /цаашид “барааны тэмдэг” гэх/, газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, барааны тэмдэг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, газар зүйн заалтыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт
11	Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
12	Валютын зохицуулалтын тухай хууль	Энэ хуулийн зорилт нь валютын зохицуулалтын талаарх төрийн зохих байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд валютын гүйлгээ хийх, валютын гүйлгээнд хяналт тавих, Монгол Улсын үндэсний валютыг үнэгүйдлээс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт
13	Гаалийн тухай хууль	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэдээс гомдол гаргах, түүнийг нь гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт
14	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль	Энэ хуулийн зорилт нь гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
15	<p>Газрын тосны бүтээгдэхүүний тухай</p>	<p>Энэ хуулийн зорилт нь газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах болон эдгээр үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаарх төрийн зохицуулалт 5 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаархи Засгийн газар болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>5.1.3 газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн нөөцийн хэмжээ, нөөц бүрдүүлэх журмыг батлах;</p> <p>5.1.4. газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэвийн бус өсөлт, хангамжийн тасалдал, хомсдол үүсэх нөхцөлд зохицуулалт хийх;</p> <p>5.1.5. импортлож байгаа газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтыг хилийн боомтуудад хийх бодлогыг хэрэгжүүлэх, нөхцөлийг бүрдүүлэх.</p> <p>5.2. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын тосны бүтээгдэхүүний талаар дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.2.1. газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>5.2.2. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;</p> <p>5.2.3. газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын асуудалтай холбогдсон дүрэм, журам, нормыг баталж, мөрдүүлэх;</p> <p>5.2.4. газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөөцийн талаар санал боловсруулан Засгийн газраар шийдвэрлүүлж хэрэгжүүлэх.</p>
16	<p>ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ</p> <p>/Шинэчилсэн найруулга/ 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдөр</p>	<p>1.1. Энэ хуулийн зорилт нь галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>19 дүгээр зүйл. Галын аюулгүй байдлыг хангах талаар тавих нийтлэг шаардлага</p> <p>19.9. Гал түймрээс хамгаалах техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх, угсрах, ашиглах, худалдах, тээвэрлэх, засвар үйлчилгээ хийхэд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмыг баримтална.</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
17	<p>ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ</p> <p>2007 оны 7 дугаар сарын 27-ны өдөр</p>	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжлийг хангахад оршино.</p>	<p>5 дугаар зүйл.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч 5.1.2.контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 149-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн; 5.1.3.контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн; 5.1.5.контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 19-өөс дээшгүй бөгөөд үйлдвэрлэл эрхэлдэг, эсхүл контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 9-өөс дээшгүй бөгөөд худалдаа, үйлчилгээ эрхэлдэг, 50-250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн 11 дүгээр зүйл.Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 11.1.5.жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах; 11.1.6.жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим, төрийн бус бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох; 14.2.Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч дараахь үүрэг хүлээнэ: 14.2.3.зохих стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх; 17 дугаар зүйл.Жижиг, дунд үйлдвэрийн менежментийн үндэс суурийг бэхжүүлэх 17.3.Аж үйлдвэрийн болон худалдааны төвлөрлийг бий болгох талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ: 17.3.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн хот төлөвлөлтийн дагуу жижиглэнгийн худалдаа болон үйлчилгээ эрхлэгчдэд зориулан худалдаа, үйлчилгээний төв, гудамж байгуулах, тухайн нутаг дэвсгэрт оршин суудаг иргэд болон үйлчлүүлэгчдийн эрх, ашиг сонирхолд нийцсэн барилга байгууламж, дэлгүүр барихад дэмжлэг үзүүлэх. 18 дугаар зүйл.Эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд зохицох чадварыг нэмэгдүүлэх, эрсдэлээс хамгаалах 18.1.Жижиг, дунд үйлдвэрийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд зохицох чадварыг нэмэгдүүлэх талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ: 18.1.1. Худалдааны бүтэц, түүхий эдийн нийлүүдэлтэд гарсан өөрчлөлт нь жижиг, дунд үйлдвэрийн үйл ажиллагаанд саад учруулсан буюу учруулж болзошгүй тохиолдолд бизнесийн тогтвортой байдлыг хангах, өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлэх;</p>
18	<p>ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ</p> <p>/Шинэчилсэн найруулга/ 2015 оны 7 дугаар сарын 8-ны өдөр</p>	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдох харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>9.3.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь эрхтэй байна:</p> <p>9.3.2.зам, түүний ойролцоо худалдаа, үйлчилгээ явуулах, уралдаан, тэмцээн, жагсаал, цуглаан, бусад арга хэмжээ зохион байгуулахад зөвшөөрөл олгох;</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
19	ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгааг бүтээх, байрлуулах, түгээх, түүнд хяналт тавих болон шударга өрсөлдөөнд харшлах, хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хуурч мэхлэх, тэдний ашиг сонирхолд хохирол учруулахуйц зар сурталчилгааг хориглохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.	24.6.Зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийн биелэлтэд эм, био бэлдмэл, эрүүл ахуй, байгаль орчин, чанар, стандартчилал, барилга, тээвэр, гааль, татвар, худалдаа, үйлчилгээ зэрэг мэргэжлийн хяналтын алба, нутгийн захиргааны байгууллага, түүнчлэн энэ хуулийн 6.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага тус тусын чиг үүргийн дагуу хяналт тавих, бүрэн эрхийнхээ хүрээнд арга хэмжээ авах үүрэгтэй.
20	Зарим нийлэг хальсан уутны хэрэглээг хориглох тухай	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт 0.025 мм болон түүнээс бага зузаантай нийлэг хальсан уутыг хүнсний бүтээгдэхүүнд баглаа боодлын зориулалтаар импортлох, хэрэглэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	4 дүгээр зүйл.Нийлэг хальсан уутны хэрэглээг хориглох 4.1.Бүх төрлийн 0.025 мм болон түүнээс бага зузаантай нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд баглаа боодлын зориулалтаар хэрэглэхийг хориглоно. 4.2.Энэ хуулийн 4.1-д заасан зориулалтаар нийлэг хальсан уутыг импортлохыг хориглоно.



№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
21	<p>ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ</p> <p>2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр</p>	<p>1.Энэ хуулийн зорилт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, зөрчлийг шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.</p>	<p>1.8 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал</p> <p>6.Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ:</p> <p>6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.2, 5.3 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.5, 5.6, 5.7 дугаар зүйл, 5.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 5.9 дүгээр зүйл, 5.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 4, 6 дахь хэсэг, 5.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 5.16, 5.18 дугаар зүйл, 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 4, 5, 11, 12, 13 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 4, 7 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 4, 5, 7, 9 дэх хэсэг, 6.21, 6.22 дугаар зүйл, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8.8 дугаар зүйл, 10.4, 10.8, 10.26, 10.28 дугаар зүйл, 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 13.5, 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.18 дугаар зүйл, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.21 дүгээр зүйл, 15.22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;</p> <p>6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11, 5.12 дугаар зүйл, 5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.15, 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.9, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.14, 6.15, 6.16, 6.17 дугаар зүйл, 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 6.19, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10, 7.11, 7.12, 7.13, 7.14, 7.15 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 8.1, 8.2, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 9.5, 9.6, 9.7, 9.9, 10.2, 10.3, 10.4, 10.12, 10.13, 10.14, 10.15, 10.16, 10.17, 10.19, 10.22, 10.24, 10.25, 10.27, 11.2, 11.22 дугаар зүйл, 11.25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.7, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.7, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16.4 дүгээр зүйлд заасан зөрчил;</p> <p>6.12.тагварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10.6 дугаар зүйл, 11.7 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 11.19, 11.24 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйлд заасан зөрчил;</p> <p>6.16.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.10, 10.1, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.5 дахь заалт, 10.7, 10.8 дугаар зүйл, 10.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 10.27 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
22	ЗӨРЧЛИЙН ТУХАЙ / шинэчилсэн найруулга/ 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр	1.Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.	Зөрчлийн тухай хуульд тусгагдсан заалтуудыг тусад нь түүвэрлэсэн.
23	ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТУХАЙ 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт
24	ИННОВАЦИЙН ТУХАЙ 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь инновацийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, төрийн дэмжлэг, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулан эзэмших, ашиглах, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	17 дугаар зүйл.Инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих 17.1.Инновацийн үйл ажиллагааг төрөөс дараах хэлбэрээр дэмжинэ: 17.1.1.инновацийн төсөл хэрэгжүүлэхээр авсан зээлийн хүүний тодорхой хувийг санхүүжүүлэх; 17.1.5.төслийн нийт өртгийн 60 болон түүнээс дээш хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тохиолдолд үлдэх хэсгийг инновацийн санхүүжүүлэгч байгууллага болон орон нутгийн төсвөөс буцалтгүй нөхцөлөөр санхүүжүүлэх; 17.1.9.үзэсгэлэн худалдаа, хурал семинар зохион байгуулах, инновацийн мэдлэг, соёлыг сурталчлах арга хэмжээг олон нийтийн байгууллагатай хамтран зохион байгуулах, санхүүжүүлэх;

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
25	<p>ИРГЭНИЙ ХУУЛЬ</p> <p>2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр</p>	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.</p> <p>1.2.Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ.</p>	<p>Тавдугаар бүлэг – Хэлцэл</p> <p>Арван тавдугаар бүлэг – Гэрээний эрх зүй</p> <p>Хорин хоёрдугаар бүлэг – Худалдах, худалдан авах болон арилжаа</p> <p>Хорин дөрөвдүгээр бүлэг – Зээл</p> <p>Хорин зургадугаар бүлэг – Санхүүгийн түрээс</p> <p>Хорин есдүгээр бүлэг – Франчайз, Мерчандайз</p> <p>Гучин тавдугаар бүлэг - Тээвэрлэлт</p>
26	<p>Компанийн тухай</p>	<p>Энэ хуулийн зорилт нь компани үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувь нийлүүлэгчдийн эрх, үүргийг тогтоох болон компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>Ерөнхий зохицуулалт</p>
27	<p>Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай</p>	<p>Энэ хуулийн зорилт нь мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>Мал, махны үйлвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>8.1.1. мал, мах бэлтгэх ажлыг бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;</p> <p>8.1.2. мал, мах бэлтгэх, худалдах-худалдан авах гэрээ болон түүний хавсралт, эрүүл ахуй, ариун цэврийн сертификатыг 6 сар хүртэл хугацаагаар хадгалж байх;</p> <p>8.1.3. амьдын жингээр авч нядалж, бэлтгэж байгаа малын толгой, арьс, ширийг анхан шатны боловсруулалт хийж, нядалгаа хийснээс хойш 3 хоног хадгалж, эрх бүхий албан тушаалтанд саадгүй үзүүлж байх;</p> <p>8.1.4. мал, мах бэлтгэх ажлыг энэ хуулийн 5.1.5-д заасан цэгт хийх.</p> <p>8.2. Тээврийн хэрэгслийн жолооч нь мах бэлтгэлийн зориулалттай мал, махыг тээвэрлэхдээ гарал үүслийн гэрчилгээтэй эсэхийг нь шалгасны үндсэн дээр тээвэрлэнэ</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
28	Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай / шинэчилсэн найруулга/	Энэ хуулийн зорилт нь мал, тэжээвэр амьтны /цаашид “мал” гэх/ удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	14 дүгээр зүйл. Иргэн, хуулийн этгээдийн үүрэг 14.1. Иргэн, хуулийн этгээд дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: 14.1.1. малыг нядлах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, боловсруулах ажлыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байр, агуулах, орчинд хийж гүйцэтгэх; 14.1.2. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг аймаг, нийслэл, сумын нутаг дэвсгэрээс нөгөөд шилжүүлэх, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, тээвэрлэх, хүлээн авах, улсын хилээр нэвтрүүлэхэд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэж гэрчилгээ авах;
29	Монгол улсын тэмдэгтийн хураамжийн хууль	Энэ хуулийн зорилт нь улсын тэмдэгтийн хураамжийг тогтоох, төлөх, хураахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт
30	МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр	1.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна	29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын нийтлэг бүрэн эрх д/нутаг дэвсгэртээ эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, худалдаа, ахуйн үйлчилгээ, хот тосгоны орон сууц, нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. ж/худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг баталж, мөрдүүлэх;
31	НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь нийслэл хотын албан татвар ногдуулах, уг татварыг төсөвт төвлөрүүлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	7.1.Татвар төлөгчийн худалдан авсан дараах бараанд нийслэл хотын албан татвар ногдуулна: 7.1.1.энэ хуулийн 4.1.3-т заасан бүх төрлийн согтууруулах ундаа; 7.1.2.энэ хуулийн 4.1.3-т заасан бүх төрлийн тамхи.
32	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай	Энэ хуулийн зорилт нь нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, төсвөөс буцаан олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
33	Нөхөрлөлийн тухай хууль	Энэ хуулийн зорилт нь нөхөрлөлийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, тэдгээрийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, бүртгэл, тайлан гаргах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино	Ерөнхий зохицуулалт
34	НЯЛХ, БАЛЧИР ХҮҮХДИЙН ХҮНСНИЙ ТУХАЙ 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих бодлогыг тодорхойлох, эрүүл, аюулгүй хүнсээр хангах, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	<p>5.6.Энэ хуулийн 3.1.6, 3.1.9-г заасан зориулалтын бүтээгдэхүүнээс бусад зургаан сар хүртэлх насны хүүхдэд зориулсан хүнсийг импортлох, худалдахыг хориглоно.</p> <p>9 дүгээр зүйл. Хооллох хэрэгслийн сав, баглаа боодол, шошгод тавих тусгай шаардлага, хориглох зүйл</p> <p>9.4.Хуулийн этгээд нь хүнсний бус зориулалтын хуванцраар үйлдвэрлэсэн хооллох хэрэгслийг импортлох, худалдахыг хориглоно.</p> <p>9.6.Энэ хуульд заасан хүнсний стандарт, ерөнхий болон тусгай шаардлагыг хангаагүй зориулалтын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдахыг хориглоно.</p> <p>10 дугаар зүйл. Нялх, балчир хүүхдийн хүнс, хооллох хэрэгслийн зар сурталчилгаа</p> <p>10.3.Хуулийн этгээд нь зориулалтын бүтээгдэхүүнийг худалдах зорилгоор эрүүл мэндийн байгууллага, ажилтан, хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, түүний дээжийг дангаар нь, эсхүл бусад бүтээгдэхүүнтэй багц байдлаар бэлэглэх, хямд үнээр өгөхийг хориглоно.</p> <p>10.4.Энэ хуулийн 3.1.5, 3.1.6, 3.1.7-д заасан зориулалтын бүтээгдэхүүнийг эх, хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын орчинд худалдахыг хориглоно</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
35	ОРГАНИК ХҮНСНИЙ ТУХАЙ 2016 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	9 дүгээр зүйл. Органик хүнсний импортлох, экспортлох, худалдах 9.1.Органик хүнснийг импортлох, экспортлохтой холбогдсон харилцааг Хүнсний тухай хуулийн 11 дүгээр зүйл, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйл, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 16.14.2-т заасны дагуу тус тус зохицуулна. 9.2.Экспорт болон импортын органик хүнснийг Хүнсний тухай хуулийн 16.1-д заасны дагуу хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэж, мэдээллийн сан үүсгэнэ. 9.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдах импортын органик хүнс нь энэ хуулийн 9.1-д зааснаас гадна доор дурдсан шаардлага хангасан байна:
36	Онцгой албан татварын тухай	Энэ хуулийн зорилт нь эх орны үйлдвэрийн болон импортоор авсан зарим бараа, түүнчлэн төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдэд онцгой албан татвар ногдуулах, түүнийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	4 дүгээр зүйл. Онцгой албан татвар ногдох бараа, үйл ажиллагаа 4.1. Дараахь бараанд онцгой албан татвар ногдуулна: 4.1.1. бүх төрлийн согтууруулах ундаа; 4.1.2. бүх төрлийн тамхи; 4.1.3. автобензин, дизелийн түлш; 4.1.4. суудлын автомашин.
37	ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
38	<p>САДАР САМУУН ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ</p> <p>1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр</p>	<p>1.1. Энэ хуулийн зорилт нь садар самууныг сурталчлах, биеэ үнэлж явалдахтай тэмцэх болон эротик сурталчилгаа, үйлчилгээг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>7.2. Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдахад дараахь зүйлийг хориглоно:</p> <p>7.2.1. албан байгууллага, гудамж, талбай, хүүхдийн байгууллага, цэцэрлэг, сургууль, оюутан, сурагчдын дотуур байр, хүнс, барааны зах, худалдаа, үзвэр үйлчилгээний газар худалдах;</p> <p>7.2.2. гар дээрээс худалдах;</p> <p>7.2.3. 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, 18 насанд хүрээгүй хүнд худалдах.</p>
39	<p>СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ</p> <p>2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр</p>	<p>1.1. Энэ хуулийн зорилт нь стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>4 дүгээр зүйл.Стандартчиллын зорилго, зарчим</p> <p>4.2.Стандартчилалд дараахь зарчмыг баримтална:</p> <p>4.2.1.төр, үйлдвэрлэгч, хэрэглэгч тэгш эрхтэйгээр оролцох;</p> <p>4.2.4.стандарт нь шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн түвшин, практикийн ололтод тулгуурласан, товч тодорхой агуулгатай байх;</p> <p>4.2.5.олон улсын стандартыг үндэсний стандарт боловсруулахад үндэс суурь болгох;</p> <p>4.2.6.стандарт нь үйлдвэрлэл, худалдаанд үндэслэлгүйгээр саад учруулахгүй байх;</p> <p>4.2.8.хууль тогтоомжид харшилсан үзүүлэлт, шаардлагыг стандартад тусгахгүй байх.</p>
40	<p>СТАТИСТИКИЙН ТУХАЙ</p> <p>/Шинэчилсэн найруулга/</p> <p>1997 оны 6 дугаар сарын 5-ны өдөр</p>	<p>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, статистикийн байгууллага, мэдээлэгчийн бүрэн эрхийг тогтоож, тэдгээрийн хооронд болон хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр хангах явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>20 дугаар зүйл.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын статистикийн мэдээллийн талаархи бүрэн эрх</p> <p>Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/нутаг дэвсгэртэй байгаа статистикийн мэдээлэгчдээс статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргуулан авч нэгтгэх, судалгаа, дүгнэлт хийж ашиглах, албан ёсны статистикийн мэдээллийг хугацаанд нь зохих дээд шатны байгууллагад өгөх</p> <p>2/Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу статистикийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах;</p> <p>3/засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийнхээ удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор, захиргааны статистикийн мэдээллийг бусад мэдээлэлтэй давхардуулахгүйгээр статистикийн байгууллагын зөвшөөрснөөр авах, мэдээллийн санг бий болгох.</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
41	<p>ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ</p> <p>/Шинэчилсэн найруулга/ 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдөр</p>	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах зорилго бүхий тамхины хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>ТАМХИНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ХЭРЭГЛЭЭ, СУРТАЛЧИЛГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ</p> <p>6 дугаар зүйл. Тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд тавих шаардлага</p> <p>6.1. Тамхи үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн талаархи эрүүл мэндийн дүгнэлтийг улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тамхины төрөл тус бүрээр олгоно.</p> <p>6.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэх, худалдах, импортлох, экспортлох тамхинд агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгт тавих стандартыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Стандартчиллын Үндэсний зөвлөл батална.</p> <p>6.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд дараахь зүйлийг хориглоно:</p> <p>6.7.1. тамхины найрлагад агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын хэмжээ болон дуусгавар болох хугацааг заагаагүй;</p> <p>6.7.2. янжуурыг нэг хайрцагт 20 ширхгээс цөөнөөр, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах;</p> <p>6.7.7. 21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах;</p> <p>6.7.8. тамхийг ширхэглэн худалдах, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдах;</p> <p>6.7.9. тамхи худалдах автомат машин ажиллуулах;</p> <p>6.7.10. тамхины борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа зохион байгуулах, сугалаа гаргах;</p> <p>6.7.11. хайрцаг, сав, баглаа боодол дээр онцгой албан татварын тэмдэг, үйлдвэрлэсэн улс, он, сар, үйлдвэр, импортлогчийн нэр, Монгол Улсад худалдахыг зөвшөөрсөн тухай тэмдэглэлгүй;</p> <p>6.7.12. зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах.</p> <p>6.7.13. интернэтээр тамхи худалдах;</p> <p>6.7.14. ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах;</p> <p>6.8. Тамхи, тамхин бүтээгдэхүүний худалдаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:</p> <p>6.8.1. худалдан авагчийн насыг тодорхойлох зорилгоор иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтаа үзүүлэхийг шаардах;</p> <p>6.8.2. энэ хуулийн 6.8.1-д заасан бичиг баримт үзүүлэхээс татгалзсан бол түүнд тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдахгүй байх.</p> <p>6.9. Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
42	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино	Ерөнхий зохицуулалт
43	ТӨЛБӨР ТООЦООГ ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТЭЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ 2009 оны 7 дугаар сарын 9-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт
44	ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2013 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах, хууль бус хэрэглээг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 6.1.2.тэсэлгээний ажил гүйцэтгэх, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тэсэлгээний ажил, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг Мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн олгох; 13 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл худалдахад тавих шаардлага 13.1.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөлтэй этгээд тэдгээрийг зөвхөн энэ хуулийн 15.1-д заасан хуулийн этгээдэд худалдана. 13.2.Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хураагдсан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг мэргэжлийн байгууллагын хяналтын дор тэсэлгээний ажил явуулах эрх бүхий байгууллагад худалдах буюу шинэчлэн сэлгэн сольж байршуулж болох ба энэ тухайгаа энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан нэгдсэн мэдээллийн санд тухай бүр мэдэгдэнэ. 22.3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд нь үйлдвэрлэсэн, импортолсон, экспортолсон, худалдсан, ашигласан тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн орлого, зарлагын мэдээг тухай бүр энэ хуулийн 22.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
45	ХАЯГЖУУЛАЛТЫН ТУХАЙ 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт
46	ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	5.1. Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, устгах зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу олгоно. 6.1.1. химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журмыг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах; 6.1.13.байгаль орчинд онцгой хор хөнөөл учруулж болзошгүй нөлөө бүхий химийн хорт болон аюултай бодис импортлох, худалдах эрх олгох. 11.1. Тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хорт болон аюултай бодис худалдахдаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр, төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж, нэг хувийг худалдан авагчид , үлдсэн хувийг өөртөө хадгална.
47	ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Ерөнхий зохицуулалт

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
48	<p>ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ</p> <p>2008 оны 5 дугаар сарын 29-ний өдөр</p>	<p>.1.Энэ хуулийн зорилт нь Монгол улсын хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшил болон харьцангуй бие даан хөгжих бүс нутгийн хөгжлийн зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоныг хот төлөвлөлтийн дагуу барьж байгуулахад төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>12.3.Чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө нь хот байгуулалтад тавигдах үндсэн шаардлагыг бүрэн хангасан худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал эрхлэх, дэд бүтцийн хангамж нөхцлийг тооцож төлөвлөсөн байна.</p> <p>14 дүгээр зүйл. Нутаг дэвсгэрийн бүсчлэлд тавигдах шаардлага</p> <p>14.1.Орон сууц, олон нийтийн бүсэд эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангаж, байгалийн гэрэлтүүлгийн холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу төлөвлөгдсөн орон сууц, сургалт, соёл, үзвэр, шинжлэх ухаан, эмнэлэг, амралт, сувилал, спорт, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, тээвэр, холбооны чиглэлийн үйл ажиллагаа явуулах зориулалттай барилга байгууламж төлөвлөх бөгөөд амьдрах, аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж болохуйц бусад барилга байгууламж төлөвлөхийг хориглоно.</p>
49	<p>ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ</p> <p>1993 оны 12 дугаар сарын 20-ны өдөр</p>	<p>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгон, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн үндэс, удирдлагын үйл ажиллагааны зарчим, тогтолцоо, бүрэн эрхийг тодорхойлж, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>20 дугаар зүйл. Орон сууц нийтийн аж ахуй ба худалдаа үйлчилгээний талаархи хот, тосгоны захирагчийн бүрэн эрх</p> <p>1.Хот, тосгоны өөрийн мэдлийн орон сууцыг тогтоосон журмын дагуу хуваарилна.</p> <p>2.Хот, тосгоны тохижилтын ажилд аж ахуйн нэгж, байгууллагыг гэрээний үндсэн дээр, түүнчлэн оршин суугчдыг зохион байгуулж оролцуулна.</p> <p>3.Хот, тосгоны өөрийн мэдлийн аж ахуй, худалдаа, үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтооно.</p> <p>4.Худалдаа, үйлчилгээний газарт эрүүл ахуйн шаардлагыг хангуулна.</p> <p>5.Худалдаа, яармаг болон үйлчилгээний бусад арга хэмжээг зохион байгуулна.</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
50	ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ 1994 оны 12 дугаар сарын 22-ны өдөр	Энэ хуулийн зорилт нь хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, түүнд хяналт тавих эрх зүйн үндсийг тогтоож, хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах, ашиглахад төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.	2. Дараахь үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлалыг хэмжил зүйн төрийн хяналт шалгалтад хамруулна: 1/ худалдаа, үйлчилгээний тооцоо; 6. Баталгаагүй хэмжих хэрэгслийг худалдах, ашиглахыг хориглоно. 7. Ахуйн зориулалттай хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулахгүй бөгөөд түүнийг худалдаа, үйлчилгээний тооцоонд хэрэглэхийг хориглоно. 2. Хэмжилзүйн төв байгууллага нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 6/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, суурилуулалт, засвар, худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох; 11 дүгээр зүйл. Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хяналт 2. Савласан, боосон, түүнчлэн ширхэгээр худалдах бүтээгдэхүүний тоон хэмжээний дундаж утга нь түүний холбогдох стандарт болон сав, боодол дээр буюу дагалдах баримт бичигт тэмдэглэсэн тоон хэмжээний хэвийн утгатай, тодорхой нэг савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний утга нь хэвийн утгын зөвшөөрөгдөх хэлбэлзлийн хязгаартай тус тус тохирч байна.
51	ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр	1.1. Энэ хуулийн зорилт нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	3.1. Энэ хууль хүнсний түүхий эдийн анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон тэдгээрийг хадгалах, тээвэрлэх, худалдах, үйлчлэх, импортлох, экспортлох, хүнсийг савлах, шошголох зэрэг хүнсний сүлжээний бүх үе шатанд үйлчилнэ. 12.8. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний багцалсан болон жижиглэн савласан сав, баглаа боодол дээрх шошгыг тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон худалдаа эрхлэгч хариуцна.
52	ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ 2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр	1.1. Энэ хуулийн зорилт нь бараа, бүтээгдэхүүн /цаашид “бараа” гэх/ худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	11 дүгээр зүйл. Хэрэглэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байх 11.1. Хэрэглэгч, үйлдвэрлэгч, гүйцэтгэгч бараа худалдах, худалдан авах, нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх тухай гэрээг бичгээр болон амаар хийж болно. 12.9. Бараа, ажил, үйлчилгээг хууран мэхлэх, төөрөгдүүлэх, хүч хэрэглэх замаар худалдах, гүйцэтгэх, хэрэглэгчийн эрхийг хохироосон гэрээ байгуулахыг хориглоно

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
53	<p>ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ</p> <p>2011 оны 5 дугаар сарын 5-ны өдөр</p>	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>19.3.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь чиглэлээр олгоно: 19.3.5.эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм худалдах; 19.3.8.ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх 7.5.Худалдаа, үйлчилгээний байгууллага нь эрүүл ахуйн нөхцөл, шаардлага хангасан, үйлчлүүлэгч чөлөөтэй ашиглах боломжтой ариун цэврийн өрөө, гар угаах хэрэгсэлтэй байна. 7.6.Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 20 дугаар зүйл. Эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангуулахтай холбогдуулан хориглох зүйл 20.1.4.эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэг болон нийтийн эзэмшлийн зам, талбайд хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх; 20.1.7.зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт автотехникийн засвар, машин техник, бохир зүйл угаах, эд анги, тос, тосолгооны материалыг ил задгай хаях, асгах, түүгээр худалдаа, үйлчилгээ эрхлэх;</p>



№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
54	<p>ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ</p> <p>2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр</p>	<p>1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>7 дугаар зүйл. Үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих эрүүл ахуйн шаардлага</p> <p>7.1.Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж нь эрх бүхий байгууллагаас хянаж баталгаажуулсан зураг төслийн дагуу баригдсан, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна.</p> <p>7.2.Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрмийг холбогдох хяналтын байгууллага батална.</p> <p>7.3.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь энэ хуулийн 7.2-г заасан эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэмд нийцүүлсэн дотоод хяналтын журмыг боловсруулан баталж, мөрдөнө.</p> <p>7.4.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь түүхий эд, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүсэх сөрөг үр дагавар, илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах арга хэмжээг бүрэн хариуцна.</p> <p>7.5.Худалдаа, үйлчилгээний байгууллага нь эрүүл ахуйн нөхцөл, шаардлага хангасан, үйлчлүүлэгч чөлөөтэй ашиглах боломжтой ариун цэврийн өрөө, гар угаах хэрэгсэлтэй байна.</p> <p>7.6.Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>20 дугаар зүйл. Эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангуулахтай холбогдуулан хориглох зүйл</p> <p>20.1.4.эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэг болон нийтийн эзэмшлийн зам, талбайд хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай худалдаалах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;</p> <p>20.1.7.зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт автотехникийн засвар, машин техник, бохир зүйл угаах, эд анги, тос, тосолгооны материалыг ил задгай хаях, асгах, түүгээр худалдаа, үйлчилгээ эрхлэх;</p>
55	<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай</p>	<p>Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн үндсийг тодорхойлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, түүний удирдлага, үйл ажиллагаа, хяналтын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино</p>	<p>Ерөнхий зохицуулалт</p>

№	Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
56	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль	Энэ хуулийн зорилт нь хүний болон мал эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур /цаашид “эм” гэх/, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино	<p>6.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналттай холбоотой үйл ажиллагааг төрийн зүгээс нэгдсэн зохицуулалтаар хангана.</p> <p>6.2.Энэ хуулийн 6.1-д заасан төрийн зохицуулалтыг дараахь үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:</p> <p>6.2.1.эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа;</p> <p>6.2.2.үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл</p> <p>6.2.3.импорт, экспортын лиценз, хяналт, зохицуулалт;</p> <p>6.2.8.эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналт;</p> <p>6.2.9.зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт, хяналт;</p> <p>6.2.10.эмнэлгийн мэргэжилтэн болон олон нийтэд зориулсан эмийн талаархи хараат бус, бодит мэдээлэл.</p> <p>6.3.Энэ хуулийн 6.2-т заасан зохицуулалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.</p>
57	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	Энэ хуулийн зорилт нь төрийн хяналт шалгалтын тогтолцоо, төрийн захиргааны хяналт шалгалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.	Ерөнхий зохицуулалт



Худалдаа эрхлэгчдээс авсан судалгаа, тэдэнтэй хийсэн ярилцлагын явцад Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн нь тэдэнд ихээхэн дарамт үүсгэж байгаа талаар дурдаж байсан юм. Иймд Зөрчлийн тухай хуульд худалдааны үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг хэрхэн шийдвэрлэх талаар тусгагдсан заалтуудыг түүвэрлэв.

Зөрчлийн тухай хуульд /2017.5.11/ Худалдааны талаар заасан зохицуулалтууд

5.11 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих

1. Химийн хорт, аюултай бодис:

1.1. экспортлох;

1.2. импортлох;

1.3. хилээр дамжуулан тээвэрлэх;

1.4. үйлдвэрлэх;

1.5. тээвэрлэх;

1.6. хадгалах;

1.7. худалдах; үндсэн шаардлага, журам, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг зөрчсөн бол зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.12 дугаар зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих

2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг эзэмших эрх бүхий этгээд:

2.1. түүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага; зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.14 дүгээр зүйл. Галын аюулгүй байдлын тухай хууль зөрчих

4.2. галын аюултай материал хадгалах, ашиглах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахдаа эрх бүхий байгууллагын мэргэжлийн дүгнэлт гаргуулах, эсхүл зөвшөөрөл авах журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй үйлчлэх, хорт бодисыг:

2.2. хадгалах;

2.3. ашиглах;

2.4. тээвэрлэх;

2.5. илгээх;

2.6. борлуулах; журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.18 дугаар зүйл. Онц байдлын тухай хууль зөрчих

3. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тогтоосон хяналтын журам зөрчсөн, эсхүл үйл ажиллагааг нь түр зогсоосон тогтмол хэвлэлийг хэвлэлд бэлтгэсэн, үйлдвэрлэсэн, тараасан, худалдсан, борлуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

НИЙТИЙН ЁС СУРТАХУУН, ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭРҮҮЛ АХУЙН ЖУРМЫН ЭСРЭГ ЗӨРЧИЛ

6.1 дүгээр зүйл. Хог хаягдлын тухай хууль зөрчих

4. Хууль, дүрэм, журам, стандартад заасан хэмжээ, шаардлагад нийцээгүй сав, баглаа боодлыг:

4.1. үйлдвэрлэсэн;

4.2. импортолсон;

4.3. худалдаа, үйлчилгээнд хэрэглэсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.3 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хууль зөрчих

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт утаат тамхи:

2.1. импортлох;

2.2. экспортлох;

2.3. үйлдвэрлэх;

2.4. худалдах;

2.5. хэрэглэхэд тавигдах шаардлагыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.4 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих

3. Мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодисыг:

3.1. зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн худалдаалсан;

3.2. зохих зөвшөөрөлгүйгээр худалдаалсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.5 дугаар зүйл. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих

11. Согтууруулах ундаа:

- 11.1.үйлдвэрлэх;
- 11.2.тээвэрлэх;
- 11.3.хадгалах;
- 11.4.борлуулах;

11.5.худалдах, түүгээр үйлчлэх ажилд арван найман насанд хүрээгүй хүн ажиллуулсан, эсхүл хорин нэгэн насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд зааснаас бусад газарт, эсхүл гар дээрээс согтууруулах ундаа худалдсан, эсхүл түүгээр үйлчилсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.7 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хууль зөрчих

9.Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез:

- 9.1.үйлдвэрлэх;
- 9.2.худалдах;
- 9.3.импортлох,

9.4.ханган нийлүүлэх талаар тогтоосон журам зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.12 дугаар зүйл.Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль зөрчих

1.Найрлага, сав баглаа боодол, шошгод тавих ерөнхий болон тусгай шаардлагыг хангаагүй, стандартыг мөрдөөгүй, эсхүл битүүмжлэл алдагдсан, импортлох, худалдахыг хориглосон, зориулалтын бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнд оруулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа, сурталчилгаа явуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.15 дугаар зүйл.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих

3.Хуульд заасныг зөрчиж:

3.1.хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, эсхүл хэрэглэж дуусах хугацаа нь хэтэрсэн, эсхүл хуурамч хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, үйлчилсэн;

3.2.хүний эрүүл мэндэд хортой сав, баглаа боодол ашиглан хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журам зөрчиж хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.17 дугаар зүйл. Эрүүл ахуйн тухай хууль зөрчих

3.Үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж нь эрх бүхий байгууллагаас хянаж баталгаажуулсан зураг төслийн дагуу баригдаагүй, эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй, эсхүл үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь түүхий эд, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүсэх сөрөг үр дагавар, илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах арга хэмжээг аваагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Түүхий эд, бараа, бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлд тавих эрүүл ахуйн шаардлагыг хангаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Бараа, бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг эрүүл ахуйн шаардлагын дагуу хадгалж, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Хүний ажиллах, суралцах байр нь эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангаагүй бол үйл ажиллагааг зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.18 дугаар зүйл.Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих

5.Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам зөрчсөн, эсхүл хуульд заасан эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйлийг зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.8 дугаар зүйл.Ургамал хамгааллын тухай хууль зөрчих

3.Ургамал хамгаалах бодис:

- 3.1. үйлдвэрлэх;
- 3.2. хадгалах;
- 3.3. тээвэрлэх;
- 3.4. борлуулах;

3.5. хэрэглэх технологи, стандартыг зөрчсөн, эсхүл зориулалтын бусаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.2 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль зөрчих

1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль зөрчиж:

1.1. үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч барааны талаар үнэн зөв, бодит мэдээллээр хэрэглэгчийг хангах;

1.2. бараа, ажил, үйлчилгээний доголдлыг арилгах хугацаа тогтоох;

1.3. бараанд засвар хийх, техникийн үйлчилгээ үзүүлэх, чанарын доголдлыг арилгах үүргээ биелүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүргээ хэрэгжүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Бараа, ажил, үйлчилгээг хууран мэхлэх, төөрөгдүүлэх, хүч хэрэглэх замаар худалдах, гүйцэтгэх, эсхүл хэрэглэгчийн эрхийг хохироосон гэрээ байгуулсан, эсхүл хууль, гэрээнд заасан чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан бараа хэрэглэх, ажил, үйлчилгээгээр хангуулах эрхийг зөрчсөн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Үйлдвэрлэгч, худалдагч барааны баталгаат хугацааны шаардлагыг хангаагүй бараа борлуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн зах зээлд нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээ нь хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулсан, эсхүл заавал мөрдөх стандартын болон техникийн зохицуулалтын шаардлагыг хангаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг есөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг есөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс хэрэглэгчид бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой худал мэдээлэл өгсний улмаас хэрэглэгчийн эрх ашигт хохирол учирсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.3 дугаар зүйл.Хуурамч бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах

1.Хуурамчаар үйлдэхээс хамгаалсан тохирлын тэмдэг заавал байх бараа, бүтээгдэхүүнийг ашиг олох зорилгоор:

1.1.улсын хилээр нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан;

1.2.үйлдвэрлэсэн;

1.3.хадгалсан;

1.4.тээвэрлэсэн;

1.5.борлуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.4 дүгээр зүйл. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих

1.Зөвшөөрөлтэйгөөр эрхлэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэгт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.24 дүгээр зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль зөрчих

2.Савласанбүтээгдэхүүнд тавигдах шаардлага, холбогдох дүрэм, журам, стандартыг зөрчиж савласан бүтээгдэхүүн худалдсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, эсхүл баталгаажуулалтад хамрагдаагүй, эсхүл ашиглалт, суурилуулалтын шаардлага хангаагүй хэмжих хэрэгслийг ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл улсын бүртгэлд бүртгэгдээгүй, баталгаажуулалтад хамрагдаагүй хэмжих хэрэгслийг үйлдвэрлэсэн, худалдсан, эсхүл суурилуулсан, эсхүл засварласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.30 дугаар зүйл.Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль зөрчих

1.1.бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэх, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх

1.2. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Ардын хувьсгалаас өмнө үндэсний үйлчилгээний салбар бараг байсангүй, анхандаа сургууль, цэцэрлэг, армид хоол хүнс бэлтгэх, тээврийн замын дагуу зорчигчдод үйлчлэхэд чиглүүлж байжээ.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв хорооны 1952 оны 463/46 тоот тогтоолоор нийтийн хоолны газруудыг хөдөөд Хоршоодын холбоонд, хотод Худалдааны яаманд шилжүүлжээ. Түүнчилэн 1957 оноос хувийн гуанзууд үйлдвэрлэлийн хоршоололд, хөдөө аж ахуйн нэгдэлүүд нийтийн хоолны өөрсдийн газруудтай болж үйлчилгээний хүрээ улам нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын харилцааг олон хуулиар хэсэгчлэн зохицуулж байна. Тухайлбал, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Зарим бараанд экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Онцгой албан татварын тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Патентын тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль зэрэг 57 хуулийн 100 гаруй зүйл, заалтаар үйлдвэрлэл үйлчилгээтэй холбоотой зохицуулалтууд туссан байна.





Монгол Улсын хуулиудад үйлчилгээний үйл ажиллагааг зохицуулсан зүйл, заалтууд

№	Хуулийн нэр	Үйлдвэрлэл үйлчилгээг зохицуулсан заалт
1	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь бараа, бүтээгдэхүүн /цаашид “бараа” гэх/ худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо</p> <p>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1. “Хэрэглэгч” гэж бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч, үйлчлүүлж байгаа, эсхүл хэрэглэж байгаа хувь хүнийг;</p> <p>3.1.2. “Худалдагч” гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчид бараагаа борлуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг;</p> <p>3.1.3. “Үйлдвэрлэгч” гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчид борлуулах зорилгоор бараа үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг;</p> <p>3.1.4. “Гүйцэтгэгч” гэж зохион байгуулалтын хэлбэрээсээ үл хамааран хэрэглэгчид төлбөртэй болон төлбөргүй ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа аж ахуй эрхлэгч болон хувь хүнийг;</p> <p>4 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад баримтлах зарчим</p> <p>4.1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар дараахь зарчмыг баримтална:</p> <p>4.1.1. Зах зээлд нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээ нь хэрэглэгчийн аюулгүй байдал, тоо, хэмжээ, чанар, хугацаа, зориулалтын зохих шаардлагыг хангасан байх;</p> <p>4.1.2. Хэрэглэгч нь бараа, ажил, үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл олж авах, хэрэглээний соёл эзэмших боломжоор хангагдсан байх;</p> <p>4.1.3. Хэрэглэгчийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, эд хөрөнгийн бус ашиг сонирхол, хүрээлэн байгаа орчинд учирсан гэм хорыг арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлөх.</p> <p>5 дугаар зүйл. Чанар, аюулгүй байдлыг хангасан бараа хэрэглэх ажил, үйлчилгээгээр хангуулах хэрэглэгчийн эрх</p> <p>5.1. Хэрэглэгч эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, техникийн нөхцөл, барилгын болон эрүүл ахуй, ариун цэврийн норм, фармакопей, жор, түүнчлэн хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлсон зохих чанар, тоо хэмжээ, аюулгүйн шаардлагыг хангасан бараа хэрэглэх, ажил, үйлчилгээгээр хангуулах эрхтэй.</p> <p>5.5. Хэрэглэгч чанаргүй бараа, ажил, үйлчилгээний улмаас зөрчигдсөн эрхээ хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар дамжуулан хамгаалуулах эрхтэй.</p> <p>7 дугаар зүйл. Барааны талаар мэдээлэл авах хэрэглэгчийн эрх</p> <p>7.1. Хэрэглэгч барааны талаар үнэн зөв сонголт хийхэд туслах бодит мэдээллээр хангагдах эрхтэй.</p> <p>7.2. Үйлдвэрлэгч барааныхаа талаар хэрэглэгчид дор дурдсан мэдээлэл өгнө:</p> <p>7.2.1. үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны болон бусад таних тэмдэг, таницын тухай код;</p> <p>7.2.2. барааны зориулалт, хэрэглээний шинж чанар;</p> <p>7.2.3. барааны орц, найрлага, хадгалах, хэрэглэх арга зүй;</p> <p>7.2.4. барааны нэр төрөл, үнэ;</p>

<p>1</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль</p>	<p>7.2.5. барааны хэмжээ, хэмжих нэгж;</p> <p>7.2.6. барааны баталгаат болон эдэлгээний хугацаа;</p> <p>7.2.7. барааг зөв хэрэглэх тухай заавар.</p> <p>8 дугаар зүйл. Шүүхээр хамгаалуулах хэрэглэгчийн эрх</p> <p>8.1. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас хэрэглэгчид учирсан гэм хорыг арилгах, хохирлыг нөхөн төлөх талаар гаргасан хэрэглэгчийн шаардлагыг үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч биелүүлэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.</p> <p>10 дугаар зүйл. Бараа, ажил, үйлчилгээний доголдлын талаар гомдлын шаардлага гаргах хугацаа</p> <p>10.1. Бараа, ажил, үйлчилгээнд доголдол илэрсэн тохиолдолд хэрэглэгч Иргэний хуулийн 254, 349 дүгээр зүйлд заасан хугацааны дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.</p> <p>10.2. Улирлын чанартай барааны хувьд баталгаат хугацаа нь тухайн улирал эхлэх үеэс тооцогдоно.</p> <p>10.3. Барааг шуудангаар хүргэсэн тохиолдолд гомдлын шаардлагыг хэрэглэгчид хүргэсэн өдрөөс эхлэн тооцно.</p> <p>10.4. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч бараа, ажил, үйлчилгээний доголдлыг боломжтой хугацаанд арилгах үүрэг хүлээнэ. Боломжит хугацаа, анзын хэмжээг гэрээнд зааж хоёр тал гарын үсэг зуран баталгаажуулсан байна.</p> <p>10.5. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч бараа, ажил, үйлчилгээний доголдлыг арилгах үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол Иргэний хуулийн 232 дугаар зүйлд заасны дагуу анз төлөх үүрэг хүлээнэ.</p> <p>11 дүгээр зүйл. Хэрэглэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байх</p> <p>11.1. Хэрэглэгч, үйлдвэрлэгч, гүйцэтгэгч бараа худалдах, худалдан авах, нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх тухай гэрээг бичгээр болон амаар хийж болно.</p> <p>11.2. Хэрэглэгчтэй байгуулсан гэрээний нөхцөл нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай энэ хууль болон бусад хууль тогтоомжоор тогтоосон нөхцлөөс дордуулсан бол хүчин төгөлдөр бус байна.</p> <p>12 дугаар зүйл. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг</p> <p>12.1. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн зах зээлд нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээ нь хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулахгүй байх, заавал мөрдөх стандартын болон техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан байна.</p> <p>12.2. Худалдагч барааг худалдаанд гаргахдаа үйлдвэрлэгч /нийлүүлэгч/-ээс энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан бараа нийлүүлэх талаар зохих гэрээг байгуулсан байна.</p> <p>12.3. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч хэрэглэгчээс бараа, ажил, үйлчилгээний чанарын доголдлын талаар тавьсан шаардлагыг хуульд заасны дагуу барагдуулах үүрэг хүлээнэ.</p> <p>12.4. Зах зээлд гаргасан бараа, ажил, үйлчилгээнд хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулж болзошгүй байдал илэрвэл үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч энэ тухай олон нийтэд нэн даруй мэдээлнэ.</p> <p>12.5. Үйлдвэрлэгч, худалдагч барааны баталгаат хугацааны шаардлагыг хангасан бараа борлуулах үүрэгтэй. Чанарын шаардлага хангаагүй бараа борлуулсан тохиолдолд хэрэглэгчийн шаардлагаар түүнийг буцаан авч үнийг хэрэглэгчид олгоно.</p> <p>12.6. Үйлдвэрлэгч худалдагч, гүйцэтгэгч барааны аюулгүй байдлын шаардлагыг хангаагүйгээс хэрэглэгчийн эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирсан гэм хорыг хуульд заасны дагуу арилгана.</p> <p>12.7. Хэрэглэгч барааны тээвэрлэх, хадгалах, ашиглах журмыг баримталсан боловч бараа нь хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулсан нь тогтоогдвол үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч түүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, борлуулалтыг нэн даруй зогсоож, гүйлгээнээс татаж авна.</p> <p>12.8. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс хэрэглэгчид бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой худал мэдээлэл өгөхийг хориглоно.</p> <p>12.9. Бараа, ажил, үйлчилгээг хууран мэхлэх, төөрөгдүүлэх, хүч хэрэглэх замаар худалдах, гүйцэтгэх, хэрэглэгчийн эрхийг хохироосон гэрээ байгуулахыг хориглоно.</p>
---	--

2	Тамхины хяналтын тухай /шинэчилсэн найруулга/	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь тамхины хэрэглээ, дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах зорилто бүхий тамхины хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>Б дугаар зүйл. Тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдахад тавих шаардлага</p> <p>6.1. Тамхи үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах эрүүл ахуйн нөхцөл, тамхин дахь хорт бодисын агууламжийн талаархи эрүүл мэндийн дүгнэлтийг улсын мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тамхины төрөл тус бүрээр олгоно.</p> <p>6.2. Улсын хилээр иргэдийн оруулж ирэх хувийн хэрэглээний тамхины тоо хэмжээг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.</p> <p>6.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэх, худалдах, импортлох, экспортлох тамхинд агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээний стандартыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн Стандартчиллын Үндэсний зөвлөл батална.</p> <p>6.4. Тамхи нь эрүүл мэндийн хор нөлөөний тухай анхааруулгатай байх бөгөөд анхааруулга нь дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>6.4.1. зурагт анхааруулга нь янжуур тамхины хайрцагны нүүр болон ар талын талбайн хэсгийн, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины сав, баглаа боодлын нүүрэн талын гадаргууны талбайн 50-аас багагүй хувийг эзэлсэн байх;</p> <p>6.4.2. тамхин бүтээгдэхүүнээс хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөний талаар том хэмжээтэй, тод харагдахуйц, гаргацтай бичих, зураг буюу дүрсээр харуулах.</p> <p>6.5. Анхааруулгын загварыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. Нэг удаад зургаан төрлийн анхааруулгын загвар гаргах бөгөөд анхааруулгын загварыг гурван жилд нэг удаа солино.</p> <p>6.6. Анхааруулга болон бусад шаардлагатай тэмдэглэл нь монгол хэл дээр бичигдсэн байна.</p> <p>6.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт тамхи импортлох, экспортлох, үйлдвэрлэх, худалдахад дараахь зүйлийг хориглоно:</p> <p>6.7.1. тамхины найрлагад агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын хэмжээ болон дуусгавар болох хугацааг заагаагүй;</p> <p>6.7.2. янжуурыг нэг хайрцагт 20 ширхгээс цөөнөөр, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхийг 200 граммаас багаар савлах;</p> <p>6.7.3. энэ хуулийн 6.4-д заасан анхааруулгагүй буюу түүнд тавигдах шаардлагыг хангаагүй;</p> <p>6.7.4. энэ хуулийн 6.1-д заасан эрүүл мэндийн дүгнэлт олгогдоогүй;</p> <p>6.7.5. “Монгол Улсад үйлдвэрлэв” гэсэн шошготойгоор бусад улсад үйлдвэрлэсэн;</p> <p>6.7.6. тамхины хайрцаг, сав, баглаа боодол дээр тухайн тамхийг бусад тамхинаас илүү хор нөлөө багатай гэсэн утгатай үг бичих буюу түүнтэй адилтгах лого, өнгө, брэндийн дүрс, тэдгээрийн хослол хэрэглэх;</p> <p>6.7.7. 21 нас хүрээгүй хүнд тамхи худалдах, түүгээр тамхи худалдуулах;</p> <p>6.7.8. тамхийг ширхэглэн худалдах, дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхины үйлдвэрлэсэн боодлыг задалж буюу ороож худалдах;</p> <p>6.7.9. тамхи худалдах автомат машин ажиллуулах;</p> <p>6.7.10. тамхины борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа зохион байгуулах, сугалаа гаргах;</p> <p>6.7.11. хайрцаг, сав, баглаа боодол дээр онцгой албан татварын тэмдэг, үйлдвэрлэсэн улс, он, сар, үйлдвэр, импортлогчийн нэр, Монгол Улсад худалдахыг зөвшөөрсөн тухай тэмдэглэлгүй;</p> <p>6.7.12. зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи худалдах;</p> <p>6.7.13. интернэтээр тамхи худалдах;</p> <p>6.7.14. ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байраас 500 метрийн дотор тамхи худалдах;</p> <p>6.7.15. баар, цэнгээний газарт тамхи худалдах.</p> <p>6.8. Тамхи, тамхин бүтээгдэхүүний худалдаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:</p> <p>6.8.1. худалдан авагчийн насыг тодорхойлох зорилгоор иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтаа үзүүлэхийг шаардах;</p> <p>6.8.2. энэ хуулийн 6.8.1-д заасан бичиг баримт үзүүлэхээс тагталзсан бол түүнд тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдахгүй байх.</p> <p>6.9. Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.</p>
---	---	---

2	Тамхины хяналтын тухай / шинэчилсэн найруулга/	<p>7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл</p> <p>7.1. Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүнс, хөдөө аж ахуйн, тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Засгийн газар олгоно. Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно. Сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батална.</p> <p>7.3. Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгоно.</p> <p>7.4. Тамхи үйлдвэрлэх, худалдах, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.</p> <p>8 дугаар зүйл. Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох</p> <p>8.1. Дараахь хэлбэрээр тамхи сурталчлахыг хориглоно:</p> <p>8.1.1. тамхи, тамхи ороодог цаас, тамхины шүүр, тамхи орооход хэрэглэгддэг төхөөрөмж, тамхины бусад дагалдах хэрэгсэл, тамхи үйлдвэрлэгчийн нэр, лого, тамхин бүтээгдэхүүн, түүний брэндийн нэр, барааны тэмдэг, тамхи үйлдвэрлэгчтэй холбоотой өнгө, өнгөний хослол, үг хэлтэг, дизайн, зураг, дүрс, үнэр, дуу авиаг ашиглах, алдартай жүжигчин, тамирчин, урлаг, соёлын ажилтан зэрэг олон нийтийн дунд нэр хүнд бүхий хүнийг оролцуулах замаар тамхийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, хувцасны загвар өмсөх үзүүлбэр, урлаг, спортын тоглолт, уралдаан, тэмцээн, гар утас, бусад шинэ технологи, ханын болон гудамжны самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз ашиглах болон бусад биет байдлаар сурталчлах;</p> <p>8.1.2. хүүхдэд тамхи татахыг зааж сургах, өөтгүүлэх;</p> <p>8.1.3. хуулийн этгээдийг тамхи болон тамхины үйлдвэрийн нэрээр нэрлэх;</p> <p>8.1.4. тамхи үйлдвэрлэгчээс эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, биеийн тамир, спортын болон бусад олон нийтийн арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх;</p> <p>8.1.5. эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд тамхи болон тамхины үйлдвэрийн зураг, нэр, тэмдэг хэрэглэх;</p> <p>8.1.6. гадна хэлбэрээрээ тамхин бүтээгдэхүүнтэй ижил төстэй чихэр, тоглоом болон тамхин бус бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, үнэгүй бэлэг, бүтээгдэхүүний дээж тараах, аливаа хэлбэрийн сугалаа, уралдаан, тэмцээн, хямрал, урамшуулал, хөнгөлөлт, тэтгэлэг үзүүлэх зэрэг бусад хэлбэрээр тамхи сурталчлах;</p> <p>8.1.7. тамхи борлуулах аливаа цэгт тамхины нэр, үнэ, тамхин бүтээгдэхүүнийг биетээр дэлгэн тавихаас бусад хэлбэрээр мэдээлэл өгөх;</p> <p>8.1.8. тамхины хайрцаг, сав, баглаа боодлын гадна болон дотор талд үндэсний стандартад зааснаас бусад, хэрэглэгчийн анхаарал татах аливаа нэмэлт дүрс, үг хэлтэг зэрэг мэдээллийг агуулсан байх;</p> <p>8.1.9. тамхи үйлдвэрлэгчийн брэнд өргөтгөх болон брэнд хуваалцах үйл ажиллагааг;</p> <p>8.1.10. тамхи үйлдвэрлэгч өөрөө, эсхүл өөр байгууллага, этгээдээр дамжуулан бусад санхүүгийн болон эд материалын хандив, тусламж үзүүлэх замаар тамхийг шууд, шууд бус хэлбэрээр сурталчлах;</p> <p>8.1.11. тамхины брэндийн дүрс, логог үзвэр, үйлчилгээний газрын орчинд байршуулах;</p> <p>8.1.12. тамхины талаар худал ташаа, төөрөгдүүлсэн, эсхүл буруу сэтгэгдэл төрүүлж болох бүх төрлийн сурталчилгаа.</p> <p>8.2. Тамхины бүх төрлийн зар сурталчилгааны материалыг улсын хилтээр нэвтрүүлэхийг хориглоно.</p> <p>8.3. Тамхины хил дамнанас зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглоно.</p> <p>8.4. Тамхи үйлдвэрлэгч шууд, эсхүл өөр байгууллагаар дамжуулан нийгмийн хариуцлага нэрийн дор нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, байгаль орчныг хамгаалах байгууллагад санхүүгийн болон эд материалын хандив, тусламж үзүүлэхийг хориглоно.</p>
3	Өрсөлдөөний тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>4.1.1. “бараа бүтээгдэхүүн” гэж зах зээлд худалдах, солилцох, эргэлтийн өөр нэг хэлбэрт оруулах зориулалттай бүх төрлийн эд юмс, төлбөрийн хэрэгсэл, ажил, үйлчилгээ, шилжүүлж болох эрх зэргийг;</p> <p>4.1.2. “зах зээл” гэж тодорхой бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалт явагдаж байгаа нутаг дэвсгэрийг;</p> <p>4.1.3. “аж ахуй эрхлэгч” гэж Монгол Улсад бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүнийг;</p> <p>4.1.4. “өрсөлдөгч” гэж тухайн төрлийн бараа бүтээгдэхүүний зах зээлд нийлүүлэлт, борлуулалт хийж байгаа аж ахуй эрхлэгчийг;</p>

3	Өрсөлдөөний тухай	<p>4.1.5.“ноёлох үйл ажиллагаа” гэж давамгайл байдлаа хууль бусаар ашиглаж бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах зорилгоор зах зээлд борлуулж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээ, үнэ зэргийг хязгаарлан өрсөлдөөнийг бодитоор хязгаарлах, хэрэглэгчийг хясан боогдуулахыг; 4.1.6.“харилцан хамаарал бүхий этгээд” гэж тухайн аж ахуй эрхлэгчтэй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 6.1.1-6.1.3-т заасан харилцаа бүхий аж ахуй эрхлэгчийг;</p> <p>4.1.7.“бараа бүтээгдэхүүний хүрээ” гэж харилцан орлох бараа бүтээгдэхүүний бүлгийг;</p> <p>4.1.8.“зах зээлийн газар зүйн хил хязгаар” гэж тухайн бараа бүтээгдэхүүнийг өөр зах зээлээс худалдан авах боломж нь эдийн засгийн хувьд хязгаарлагдмал нутаг дэвсгэрийг;</p> <p>4.1.9.“зах зээлийн төвлөрөл” гэж зах зээлд аж ахуй эрхлэгчийн дангаараа буюу бусад этгээдтэй хамтран, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдийн борлуулж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний эзлэх хувийг;</p> <p>4.1.10.“зах зээлийн хүч” гэж аж ахуй эрхлэгчийн тухайн бараа бүтээгдэхүүний зах зээлд нөлөө үзүүлэх чадварыг.</p> <p>5 дугаар зүйл. Зүй ёсны монополь болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч</p> <p>5.1.Тухайн бараа бүтээгдэхүүний зах зээлд нийлүүлэлт хийж байгаа нэг этгээд байхад л нийгмийн дундаж зардал хамгийн бага байх боломжтой зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаагаар аж ахуй эрхлэгчийг зүй ёсны монополь байдалтай гэж үзнэ.</p> <p>5.2.Тодорхой бараа бүтээгдэхүүний зах зээлд дангаараа буюу бусад этгээдтэй хамтран, эсхүл харилцан хамаарал бүхий этгээд үйлдвэрлэл, борлуулалтын, эсхүл худалдан авалтын гуравны нэг буюу түүнээс дээш хувийг эзэлж байвал давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч гэж үзнэ.</p> <p>5.3.Энэ хуулийн 5.2-т заасан хувьд хүрээгүй ч бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах чадвартай аж ахуй эрхлэгчийг бараа бүтээгдэхүүний хүрээ, зах зээлийн газар зүйн хил хязгаар, зах зээлийн төвлөрөл, зах зээлийн хүч зэргийг үндэслэн давамгайл байдалтай гэж үзэж болно.</p> <p>6 дугаар зүйл. Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах</p> <p>6.1.Энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаанд дараахь зохицуулалт хийнэ:</p> <p>6.1.1.зах зээлд нийлүүлж байгаа тухайн бараа бүтээгдэхүүний тоо, хэмжээний өөрчлөлтийн талаар хүчин чадалтай нь уялдуулан хянан зохицуулах;</p> <p>6.1.2.бодит зардлыг нь харгалзан тухайн бараа бүтээгдэхүүнийг борлуулах үнийн өөрчлөлтийг хянан зөвшөөрөл олгох.</p> <p>6.2.Зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч энэ хуулийн 7.1-д заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.</p> <p>7 дугаар зүйл. Давамгайл байдлаа хууль бусаар ашиглах</p> <p>7.1.Давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч дараахь ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>7.1.1.зохиомлоор тухайн бараа бүтээгдэхүүний хомсдол бий болгох, бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг зогсоох, хэмжээг хязгаарлах;</p> <p>7.1.2.бараа бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох;</p> <p>7.1.3.аж ахуй эрхлэгчээс борлуулалтын нэмэлт нөхцөлийг шаардах, зах зээлд ижил төрлийнбараа бүтээгдэхүүнийгялгавартай үнээр борлуулах, үндэслэлгүйгээр борлуулалт хийхээс татгалзах. Энэ нь бүс нутгийн байршлаас хамаарсан тээврийн бодит зардлыг тооцсон бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт,үйлдвэрлэгч, нийлүүлэгчээс бөөний болон жижиглэнгийн худалдан авагчид өгч байгаа урамшуулалд хамаарахгүй;</p> <p>7.1.4.бусад аж ахуй эрхлэгч зах зээлд гарч ирэхэд саад учруулах, тэдгээрийг зах зээлээс шахан гаргах зорилгоор бараа бүтээгдэхүүнээ бодит зарлаас доогуурүнээрборлуулах;</p> <p>7.1.5.эдийн засгийн болон техникийн бодит үндэслэлгүйгээр аж ахуйн бусад харилцаа тогтоохоос татгалзах, үндэслэлгүйгээр шалгуур үзүүлэлт тогтоох;</p> <p>7.1.6.тухайн бараа бүтээгдэхүүнийг дахин борлуулах үнэ, нутаг дэвсгэрийг тогтоож өгөх;</p> <p>7.1.7.өөрийн бараа бүтээгдэхүүнийг борлуулахдаа өрсөлдөгчийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахуулахгүй байх болзол тулгах;</p> <p>7.1.8.тухайн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг бууруулахад хүргэж болох нөхцөлөөр уг бараа бүтээгдэхүүнийг өөртөө худалдахыг бусдаас шаардах;</p> <p>7.1.9.аж ахуйэрхлэгчээссанхүүгийн хэрэгсэл, эд хөрөнгө, тэдгээрийн эрх, ажиллах хүч зэргийг өөртөө шилжүүлэхийг үндэслэлгүйгээр шаардах;</p> <p>7.1.10.өрсөлдөгчөө өөртөө нэгтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулахыг шаардах;</p> <p>7.1.11.тодорхой төрлийн бараа бүтээгдэхүүний талаар хийж байгаа гэрээ, хэлэлцээрт гэрээний зүйлд хамаарахгүй нөхцөлийг гэрээнд тусгахыг тулган шаардах, бусад оролцогчид ялгавартай нөхцөл тавих;</p> <p>7.1.12.бараа бүтээгдэхүүн борлуулахдаа иж бүрдэлд ороогүй бараа дагалдуулах.</p> <p>7.2.Давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний хэт өндөр үнийг тогтоохтой холбогдсон журмыг олон улсын тэргүүн туршлагыг үндэслэн Засгийн газар батална.</p> <p>9 дүгээр зүйл.Өрсөлдөгч хуулийн этгээдийн удирдлагын албан тушаалд ажиллахыг хориглох</p> <p>9.1.Давамгайл байдалтай хуулийн этгээдийн удирдлага өрсөлдөгч хуулийн этгээдийн удирдлагын албан тушаал хавсран ажиллахыг хориглоно.</p> <p>10 дугаар зүйл. Давамгайл байдалтай хуулийн этгээдийг хуваах, тусгаарлах</p> <p>10.1.Ноёлох үйл ажиллагааг нэг жилдхөөр ба түүнээс дээш удаа явуулж хуулийн хариуцлага хүлээж байсан ч дахин ийм үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол тухайн давамгайл байдалтай хуулийн этгээдийг хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас</p>
---	-------------------	--

<p>3</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Өрсөлдөөний тухай</p>	<p>гаргасан нэхэмжлэлийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.</p> <p>11 дүгээр зүйл. Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл (картель) байгуулахыг хориглох</p> <p>11.1. Аж ахуй эрхлэгчид өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн дараахь гэрээ, хэлцэл (картель) байгуулахыг хориглоно: 11.1.1. бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох;</p> <p>11.1.2. зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, барааны нэр, төрөл, худалдан авагчаар хуваарилах;</p> <p>11.1.3. бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, борлуулалт, ачилт болон тээвэрлэлт, зах зээлд нэвтрэн орох боломж, хөрөнгө оруулалт, техник, технологийн шинэчлэлийг хязгаарлах;</p> <p>11.1.4. уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцоходоо бараа бүтээгдэхүүний үнэ болон бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцох.</p> <p>11.2. Аж ахуй эрхлэгчдийн хооронд байгуулсан дараахь гэрээ, хэлцэл (картель) нь нийтийн ашиг сонирхолд харшлах, эсхүл өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлэхээр бол хориглоно:</p> <p>11.2.1. эдийн засгийн болон технологийн үндэслэлгүйгээр аж ахуйн харилцаа тогтоохоос татгалзах;</p> <p>11.2.2. барааг гуравдагч этгээдэд худалдах, худалдан авахыг хязгаарлах;</p> <p>11.2.3. өрсөлдөөнд чухал ач холбогдол бүхий хэлцэл, тохиролцооноос хамсан татгалзах;</p> <p>11.2.4. аж ахуйг ашигтай эрхлэх зорилгоор аль нэг байгууллагад гишүүнээр элсэхэд нь өрсөлдөгчид саад учруулах.</p> <p>11.3. Аж ахуй эрхлэгч энэ хуулийн 11.1, 11.2-т заасан гэрээ, хэлцэл (картель) -ийг дэмжиж оролцохыг хориглоно.</p> <p>11.4. Энэ хуулийн 11.1, 11.2-т заасан гэрээ, хэлцэл (картель) байгуулсан, шийдвэр гаргасан этгээдийн талаархи бодит мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт ирүүлсэн этгээдэд тухайн зөрчилд ногдуулсан торгуулийн мөнгөн дүнгийн таван хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.</p> <p>12 дугаар зүйл. Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа</p> <p>12.1. Аж ахуй эрхлэгч өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>12.1.1. өрсөлдөгчийн болон түүний бараа бүтээгдэхүүний нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;</p> <p>12.1.2. өөрийн бараа бүтээгдэхүүний талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх;</p> <p>12.1.3. өрсөлдөөнд харш үр дагавар үзүүлэх зар сурталчилгаа явуулах;</p> <p>12.1.4. бусдын барааны гэмдэг, шошго, аж ахуй эрхлэгчийн нэр, барааны чанарын баталгааг дур мэдэн хэрэглэх, барааны оноосон нэр, баглаа боодлыг хуулбарлах;</p> <p>12.1.5. патент эзэмшигч, зохиогчийн зөвшөөрөлгүйгээр шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэл, худалдааны мэдээлэл, нууцыг худалдах, нийтлэх, бусдад тараах;</p> <p>12.1.6. барааны чанарын доголдол, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчиндаоултай шинж чанарыг нуун дарагдуулах;</p> <p>12.1.7. өөрийн бараа бүтээгдэхүүнийг борлуулахдаа өрсөлдөгчийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахуулахгүй байх болзол тулгах;</p> <p>12.1.8. тухайн бараа бүтээгдэхүүний борлуулалтад урамшуулал, хямдрал байгаа гэсэн хуурамч мэдээлэл түгээх, эсхүл уг урамшууллыг аль нэг этгээдэд өгөхөөр урьдаас тохиролцож зориуд хуурамчаар зохион байгуулах;</p> <p>12.1.9. уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцоходоо өрсөлдөгчөө тухайн үйл ажиллагааны бодит нөхцөлөөс төөрөгдүүлэх, тэдэнд дарамт, шахалт үзүүлэх;</p> <p>12.1.10. хууль ёсны ашиг сонирхолд харшлах болон хэрэглэгчийг хууль бусаар хохироох худалдааны арга хэрэглэх.</p> <p>13 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглох</p> <p>13.1. Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, эрх олгох, бүртгэл явуулах, төлбөр, хураамж авахыг хориглоно.</p> <p>13.2. Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хуульд зааснаас бусад тохиолдолд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>13.2.1. аж ахуй эрхлэгчийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон буюу хязгаарласан;</p> <p>13.2.2. аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнээ нэг зах зээлээс нөгөөд борлуулахыг хориглосон буюу хязгаарласан;</p> <p>13.2.3. тухайн зах зээлд өрсөлдөгч гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан гаргахад чиглэсэн;</p> <p>13.2.4. бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахад, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн;</p> <p>13.2.5. зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр, төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилахад чиглэсэн;</p>
---	--

	<p>13.2.6.аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнийг бусад байгууллага, аж ахуй эрхлэгчид зээлээр олгоход чиглэсэн; 13.2.7.аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн.</p> <p>13.3.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас учирсан хохирлыг нөхөх, эдийн засгийн хямралыг даван туулах, стратегийн гол бараа бүтээгдэхүүн тухайлбал, Улсын нөөцийн тухай хуульд¹ заасны дагуу Улсын Их Хурлаас тогтоосон бараа материалын эрэлт, нийлүүлэлтийн зохистой байдлыг бүрдүүлэн хэрэглэгчийн амьжиргааны түвшний тогтвортой байдлыг хангахад зориулж Засгийн газар, түүний эрх олгосон байгууллагаас зохицуулалт хийх, зээл олгох, тусламж үзүүлэхийг өрсөлдөөнийг хязгаарласанд тооцохгүй.</p> <p>13.4.Засгийн газраас нийтийн ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлыг хангах, үр ашигтай өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх үүднээс зарим төрлийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлд тодорхой хугацаагаар хязгаарлалт хийж болно.</p>
<p>4</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Архидан согтуурахтай гэмцэх тухай</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах / үйлчлэх/, хэрэглэх, архидан согтуурахтай тэмцэх, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл</p> <p>4.3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг даргын санал, мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга олгоно.</p> <p>4.4. Худалдаа үйлчилгээнд улсын техникийн зохицуулалт, стандартын шаардлага хангасан, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулсан, тохирлын гэрчилгээ авсан согтууруулах ундааг нийлүүлнэ.</p> <p>4.7. Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар, согтууруулах ундаа импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар тус тус сунгана.</p> <p>4.8. Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.3, 6.4-т заасан журмыг баримтална.</p> <p>5 дугаар зүйл. Үйлдвэрлэх, импортлох журам</p> <p>5.6. Гадаад улсаас импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг тогтоосон техникийн зохицуулалтын баримт бичгийг худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>5.7. Импортлож болох согтууруулах ундааны жагсаалтыг батлахдаа согтууруулах ундааны нэр, төрөл, олон улсын стандарт, дээд ангиллын зэрэг, хатуулгийг тодорхой заана.</p> <p>5.8. Импортлож болох согтууруулах ундааны жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг импортлохдоо дээжийг нь стандартчилал, эрүүл ахуйн мэргэжлийн хяналтын байгууллагаар урьдчилан шинжлүүлж, хилийн болон гаалийн эрүүл ахуйн хяналт шалгалт хийлгүүлэн баталгаажуулсан байна.</p> <p>5.9. Импортлож болох согтууруулах ундааны жагсаалтад ороогүй согтууруулах ундааг улсын хилээр оруулах, худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.</p> <p>5.10. Согтууруулах ундааг импортлох, экспортлох, реэкспортлохдоо зөвхөн гаалийн төв байгууллагаас нэр заан тогтоосон боомтоор улсын хилээр нэвтрүүлнэ.</p> <p>6 дугаар зүйл. Худалдах, үйлчлэх журам</p> <p>6.1. Аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд зааснаас бусад газарт болон гар дээрээс согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.</p> <p>6.2. Энэ хуулийн 5.1; 5.2; 5.3; 5.8; 5.9; 5.10-т заасан журмыг зөрчиж үйлдвэрлэсэн буюу импортолсон, эсхүл хяналтын шинжилгээ хийлгээгүй согтууруулах ундааг худалдаа, үйлчилгээнд гаргахыг хориглоно.</p> <p>6.3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэх, мөн зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэлгүйгээр худалдаа, үйлчилгээ явуулах байршлаа өөрчлөхийг хориглоно.</p> <p>6.4. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, үйлчилгээний хүрээ, эрүүл мэнд, соёлын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байрны байршлыг харгалзан худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.</p> <p>7 дугаар зүйл. Согтууруулах ундаа хэрэглэх, худалдах, түүгээр үйлчлэхэд хориглох зүйл</p> <p>7.1. Дараахь газарт согтууруулах ундаа хэрэглэх, худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно:</p>

4	<p style="text-align: center;">Архидан согтуурахтай тэмцэх тухай</p> <p>7.1.1. төрийн болон төрийн бус байгууллагын албан байр;</p> <p>7.1.2. согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгжийн албан болон үйлдвэрлэлийн байр;</p> <p>7.1.3. хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, сувиллын газар;</p> <p>7.1.4. оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байр;</p> <p>7.1.5. орон сууцны орц, хонгил;</p> <p>7.1.6. гудамж, талбай, цэцэрлэг;</p> <p>7.1.7. галт тэрэг, авто тээвэр, усан болон нисэх онгоцны буудлын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар;</p> <p>7.1.8. нийтийн тээвэр, хүнсний болон барааны зах, худалдаа, үйлчилгээний газар зэрэг олон нийтийн газрын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт.</p> <p>7.2. Согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй газарт дараахь зүйлийг хориглоно:</p> <p>7.2.1. согтууруулах ундаа үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, борлуулах, худалдах, түүгээр үйлчлэх ажилд 18 нас хүрээгүй хүн авч ажиллуулах;</p> <p>7.2.2. 21 нас хүрээгүй, эсхүл согтуу хүнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх. 7.3. Дараахь хүмүүст согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно:</p> <p>7.3.1. тээврийн хэрэгсэл жолоодож яваа хүн;</p> <p>7.3.2. 21 нас хүрээгүй хүн.</p> <p>7.4. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, бусдыг шахаж согтоох, түүнчлэн 21 нас хүрээгүй хүнийг уруу татаж согтууруулах ундаа уулгахыг хориглоно.</p> <p>7.5. Согтууруулах ундаагаар шагнаж урамшуулах, цалин хөлс орлуулахыг хориглоно.</p> <p>7.6. Согтууруулах ундааны шошгыг дуурайлган үйлдэх, хууль бусаар хэрэглэх, худалдахыг хориглоно.</p> <p>7.7. Согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй зоогийн болон шөнийн цэнгээний газрыг хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, эмнэлэг, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон нийтийн байр, орон сууц, түүний суурийн давхар / зориудаар тохижуулснаас бусад/-т ажиллуулахыг хориглоно.</p> <p>7.8. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газарт 00-06 цагт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглоно.</p> <p>9 дүгээр зүйл. Архидан согтуурахын эсрэг сурталчилгаа</p> <p>9.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.</p> <p>9.2. Дараахь хэлбэрээр согтууруулах ундаа сурталчлахыг хориглоно:</p> <p>9.2.1. согтууруулах ундаа болон согтууруулах ундааны үйлдвэрийн нэр, тэмдэг, зураг ашиглах замаар согтууруулах ундааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, интернэт, ханын самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз болон бусад биет байдлаар гаргах;</p> <p>9.2.2. энэ хуулийн 7.3.2-т заасан этгээдэд согтууруулах ундаа хэрэглэхийг зааж сургах;</p> <p>9.2.3. согтууруулах ундаа үйлдвэрлэгч нь өөрийн аж ахуйн нэгжийн нэртэй ижил нэрээр нэрлэсэн согтууруулах ундаа үйлдвэрлэх;</p> <p>9.2.4. согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, экспорт эрхэлдэг, согтууруулах ундаа борлуулдаг хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүнийг сурталчлах, нэрийг нь олонд таниулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор соёл, урлаг, спортын болон бусад олон нийтийн арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцох, төрөл бүрийн хандив, тусламж, тэтгэлэг үзүүлэх;</p> <p>9.2.5. эд бараа, хувцас, хэрэглээний зүйлд согтууруулах ундаа болон согтууруулах ундааны зураг, нэр, тэмдэг хэрэглэх;</p> <p>9.2.6. согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээний талаар төрөл бүрийн сугалаа, хонжвор, аливаа хэлбэрийн урамшуулалт худалдаа явуулах.</p> <p>9.2.7. Зар сурталчилгааны тухай хуулийн 14¹ дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгааг явуулах.</p>
---	--

4	Архиван согтуурахтай тэмцэх тухай	<p>9.3. Согтууруулах ундааны зар сурталчилгааны материалыг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.</p> <p>9.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага согтууруулах ундааны хор уршиг, хэрэглээний эсрэг сурталчилгааг ивээн тэтгэж болно.</p> <p>14 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ, хэрэглээнд тавих хяналт</p> <p>14.2. Согтууруулах ундааны импортод тавих хяналтыг гаалийн байгууллага болон хилийн эрүүл ахуйн хяналтын алба хэрэгжүүлнэ.</p> <p>14.3. Согтууруулах ундаа худалдах, хэрэглэх, түүгээр үйлчлэх талаар тогтоосон журмын биелэлтэд дараахь байгууллага, албан тушаалтан энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаар олгосон эрх хэмжээний дотор хяналт тавина:</p> <p>14.3.1. бүх шагны Засаг дарга;</p> <p>14.3.2. цагдаагийн байгууллага;</p> <p>14.3.3. аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага;</p> <p>14.3.4. эрх бүхий мэргэжлийн хяналтын байгууллага;</p> <p>14.3.5. хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага.</p> <p>14.4. Согтууруулах ундааны үйлдвэрлэлт, борлуулалт, импортод хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтан нэн даруй биелүүлэх үүрэгтэй.</p>
5	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь бараа, үйлчилгээний тэмдэг /цаашид “барааны тэмдэг” гэх/, газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, барааны тэмдэг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, газар зүйн заалтыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>5 дугаар зүйл. Барааны тэмдэгт тавих шаардлага</p> <p>5.1. Ялгагдах шинж чанар агуулаагүй дараахь зүйлийг барааны тэмдэгт тооцохгүй:</p> <p>5.1.1. үсэг, тоо, геометрийн энгийн дүрс, нийтээр хэрэглэдэг тэмдэглэгээ, нэр томъёо дангаараа байвал;</p> <p>5.1.2. тухайн бараа, үйлчилгээг тодорхойлсон нэр, барааны тоо, хэмжээ, жин, чанар, зориулалт, үнэ, үйлдвэрлэсэн газрын нэр, арга, хугацаа зэргийг тайлбарласан үг, дүрс;</p> <p>5.1.3. тухайн бараа, түүний сав, баглаа боодлын үл ялгагдах хэлбэр, дүрс;</p> <p>5.1.4. Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн нэр, дүрс дангаараа байвал;</p> <p>5.1.5. Монгол Улсын түүхэн хүмүүсийн бүтэн нэр, зохиомол нэр, хөрөг, зураг, тэдгээрт шууд хамаарах төсөөллийн нэр дангаараа байвал.</p> <p>5.2. Дараахь барааны тэмдгийг бүртгэхгүй:</p> <p>5.2.1. Монгол Улсын болон Парисын конвенци, Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улсын сүлд, далбаа, төрийн бэлгэдэл, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын бүтэн ба товчилсон нэр, албан ёсны тэмдгээс бүрдсэн, эсхүл тэдгээртэй ижил, төсөөтэй бөгөөд тухайн улс, байгууллага, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй;</p> <p>5.2.2. Монгол Улсын нэрд гарсан хүний бүтэн нэр, эсхүл зохиомол нэр, хөрөг, зургаас бүрдсэн бөгөөд тухайн хүний буюу түүний өв залгамжлагчийн зөвшөөрөлгүй;</p> <p>5.2.3. Монгол Улсын төрийн одон, медаль болон бусад шагнал, баталгаа, хяналтын албан ёсны тэмдэг, дардастай ижил, төсөөтэй;</p> <p>5.2.4. агуулга нь нийгмийн дэг журам, зан суртахуунд харш;</p> <p>5.2.5. бараа, үйлчилгээний чанар, гарал үүсэл болон бусад шинж чанарын хувьд хэрэглэгчийг төөрөгдөлд оруулж болзошгүй;</p> <p>5.2.6. Монгол Улсад бүртгэгдсэн, эсхүл бүртгүүлэхээр мэдүүлсэн ижил бараа, үйлчилгээнд хэрэглэх барааны тэмдэгтэй ижил;</p> <p>5.2.7. Монгол Улсад бүртгэгдсэн, эсхүл бүртгүүлэхээр мэдүүлсэн төсөөтэй бараа, үйлчилгээнд хэрэглэх барааны тэмдэгтэй ижил, төсөөтэйгээс хэрэглэгчийг төөрөгдөлд оруулж болзошгүй;</p> <p>5.2.8. бараа, үйлчилгээний төрлөөс үл хамаарч нийтэд түгээмэл болсон барааны тэмдэгтэй ижил, эсхүл төсөөтэйгээс хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, шударга бус давуу эрх эдлэх, ашиг олох, хохирол учруулах, нэр хүндийг гутаахаар;</p> <p>5.2.9. Монгол Улсад нийтэд түгээмэл болсон бүтээлийн зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхтэй илэрхий зөрчилдөхөөр.</p>

5	Барааны гэмдэг, газар зүйн заалтын тухай	<p>13 дугаар зүйл. Барааны тэмдгийг ашиглах</p> <p>13.1. Дараахь тохиолдолд барааны тэмдгийг ашигласанд тооцно:</p> <p>13.1.1. барааны тэмдгийг бараа, түүний сав, баглаа боодол, үйлчилгээнд хэрэглэсэн бол;</p> <p>13.1.2. барааны тэмдэг бүхий барааг нийлүүлсэн, худалдаанд гаргасан буюу энэ зорилгоор хадгалсан, үйлчилгээ үзүүлсэн бол;</p> <p>13.1.3. барааны тэмдэг бүхий барааг хилээр нэвтрүүлсэн бол;</p> <p>13.1.4. барааны тэмдгийг албан бичиг, танилцуулга, бусад баримт, интернэт, сурталчилгаанд ашигласан бол.</p> <p>13.2. Барааны тэмдэг эзэмшигч нь барааны тэмдэг бүртгэгдсэнийг илэрхийлэх дугуй хүрээтэй “R” гэсэн латин үсэг бүхий таних тэмдгийг барааны тэмдгийн хамт хэрэглэж болно.</p> <p>13.3. Барааны тэмдгийн оюуны бүтээлийн өртгийг тооцсон үнэлгээг хөрөнгийн баталгаа, барьцаа, хөрөнгө оруулалт болгох, хувьцаа гаргах, хувьчлал болон дуудлага худалдаанд оруулах, дүрмийн сан бүрдүүлэх, даатгалд хамруулах зэрэгт хэрэглэж болно.</p> <p>13.4. Энэ хуулийн 13.3-т заасан зорилгоор гэрээ байгуулсан бол уг гэрээг төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.</p> <p>19 дүгээр зүйл. Газар зүйн заалтын илэрхийлэгдэх хэлбэр</p> <p>19.1. Газар зүйн заалт нь тухайн бараа, бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлсон газар нутгийн газар зүйн нэр дангаараа, эсхүл тухайн бараа, бүтээгдэхүүний нэртэй хосолсон хэлбэрээр илэрхийлэгдэж болно.</p> <p>22 дугаар зүйл. Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүний тодорхойлолт</p> <p>22.1. Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүн болохыг дараахь шинжээр тодорхойлно:</p> <p>22.1.1. бараа, бүтээгдэхүүний нэр нь газар зүйн заалтаас бүрдсэн байх;</p> <p>22.1.2. газар зүйн заалтад хамаарах бараа, бүтээгдэхүүний тодорхойлолт нь хими, физик, микробиологи, бүтцийн шинж чанарыг агуулсан байх;</p> <p>22.1.3. газар зүйн заалтад хамаарах газар зүйн бүс тодорхой байх;</p> <p>22.1.4. газар зүйн заалтад хамаарах бараа, бүтээгдэхүүн нь тухайн газар нутгаас гарал үүсэлтэй болох нь нотлогдсон байх;</p> <p>22.1.5. гарал үүсэл, хүний болон байгалийн хүчин зүйл, нутаг дэвсгэрийн онцлогтой холбогдож тухайн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг болох нь нотлогдсон байх;</p> <p>22.1.6. тухайн бараа, бүтээгдэхүүнийг гаргаж авах, олж авдаг нутгийн үл өөрчлөгдөх, тогтвортой аргын талаархи тайлбар</p>
6	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>4.1.1. “хүнсний бүтээгдэхүүн” гэж Хүнсний тухай хуулийн 3.1.1-д зааснаас гадна савласан ус, бүх төрлийн ундаа, бохь, хүнсний нэмэлтийг;</p> <p>4.1.2. “хүнсний түүхий эд” гэж мал, амьтан, ургамал, эрдсийн болон бусад гаралтай түүхий эд, түүнчлэн хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулахад хэрэглэдэг усыг;</p> <p>4.1.5. “хүнсний эрүүл ахуй” гэж хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний аюулгүй байдлыг хангахад шаардагдах бүхий л нөхцөл, шаардлагыг;</p> <p>4.1.6. “хүнсний сүлжээ” гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортолох, импортолох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг;</p> <p>4.1.7. “анхан шатны үйлдвэрлэл эрхлэх” гэж ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийг тариалах, хураах, бэлтгэх, мал, амьтан, загас өсгөх, үржүүлэх, мал бэлтгэх, төхөөрөх, түүхий сүү бэлтгэх, боловсруулах, байгалийн гаралтай жимс жимсгэнэ, ургамлыг түүх, тэдгээрийг зах зээлд нийлүүлэхийг;</p> <p>4.1.15. “хуурамч хүнсний бүтээгдэхүүн” гэж хүнсний бүтээгдэхүүний орц найрлагад зайлшгүй орох зүйлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хийгээгүй, хассан, эсхүл өөр зүйлээр орлуулсан, түүнчлэн муудсан, чанараа алдсан бүтээгдэхүүний өнгө үзэмжийг засах, жин хэмжээг нэмэх, хасах зэргээр бодит байдлыг нь нуун далдалсан, өөрчилсөн хүнсний бүтээгдэхүүнийг;</p>

6	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	<p>4.1.16. “хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч” гэж Хүнсний тухай хуулийн 3.1.12-т заасныг; 13 дугаар зүйл. Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн</p> <p>13.1. Импортын болон экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлсэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийнэ.</p> <p>13.2. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт Монгол Улсын болон олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шаардлага хангасан байна.</p> <p>13.3. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг шошгон дээр нь заасан нөхцөлийн дагуу хадгална.</p> <p>13.4. Хүнсний аюулгүй байдалд хяналт тавих эрх бүхий улсын байцаагч нь Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай суульд заасны дагуу импортлох болон экспортлох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлсэд холбогдох хяналт шалгалт хийнэ.</p> <p>13.5. Мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлогч эхний удаа импортлох тохиолдолд түүний нэр, төрөл, бүс нутаг, улс, үйлдвэрлэгчийн нэрийг ачилт хийхээс 30-аас доошгүй хоногийн өмнө хяналтын байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.</p> <p>13.6. Хяналтын байгууллага энэ хуулийн 13.5-д заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд импортын өмнөх эрсдэлийн үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд ачилтын өмнөх хяналт шалгалт хийнэ.</p> <p>13.7. Хяналтын байгууллага гадаадын зээл, тусламжаар авах болон энэ хуулийн 6.5-д заасан өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх хяналт шалгалтыг хийж болно.</p> <p>13.8. Энэ хуулийн 13.6, 13.7-д заасан ачилтын өмнөх хяналт шалгалтын журмыг Засгийн газар батална.</p> <p>14 дүгээр зүйл. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн</p> <p>14.1. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг эрүүл мэнд, хүнсний болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.</p> <p>14.2. Эхний удаа импортолсон болон дотооддоо үйлдвэрлэсэн хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд хяналтын байгууллага хяналт шалгалт хийнэ.</p> <p>14.3. Энэ хуулийн 14.1-д заасан журмын дагуу эрсдэлийн үнэлгээ хийлгээгүй, бүртгүүлээгүй хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглоно.</p>
6	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь хүн амын хүнсний хэрэгцээг чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>6 дугаар зүйл. Хүнсний нөөц</p> <p>6.1. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах зорилгоор стратегийн хүнсний улирлын нөөцийг бүрдүүлнэ.</p> <p>6.2. Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.</p> <p>6.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ хуулийн 6.2-т заасан журмын дагуу стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</p> <p>6.4. Засгийн газар хүнсний эрэлт, нийлүүлэлтийн нөхцөл байдлаас хамааран энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тогтоож болно.</p> <p>6.5. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ.</p> <p>6.6. Хүн амын эмзэг бүлгийг тодорхойлох аргачлал гаргаж, судалгаа хийх, тэдний хүнсний хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх асуудлыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.</p> <p>6.7. Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хүнсний эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг энэ хуулийн 18.1-д заасан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, гаргасан зөвлөмжийг үндэслэн тогтооно.</p>

<p>6</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай</p>	<p>6.8.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.7-д заасны дагуу тогтоосон хэмжээнд багтаан Засгийн газраас баталсан журмын дагуу стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгоно.</p> <p>6.9.Энэ хуулийн 6.8-д заасан зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар зохицуулна.</p> <p>6.10.Хүнсний улсын нөөцийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.</p> <p>6.11.Гадаадын зээл, тусламжаар хүнс авахтай холбогдсон харилцааг Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулиар зохицуулна.</p> <p>8 дугаар зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд үзүүлэх дэмжлэг, урамшуулал</p> <p>8.1.Төрөөс дор дурдсан хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд дэмжлэг, урамшуулал үзүүлж болно:</p> <p>8.1.2.дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй өргөн хэрэглээний хүнсний импорт;</p> <p>8.1.5.үйл ажиллагаандаа зохистой дадал, энэ хуулийн 10.2.1-д заасан хяналтыг нэвтрүүлсэн;</p> <p>8.1.6.Монгол Улсын нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалсан;</p> <p>8.1.7.дотоодын түүхий эд ашиглан шинэ технологиор импортыг орлох хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.</p> <p>8.3.Мал төхөөрөх болон сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгож болно.</p> <p>8.4.Энэ хуулийн 8.1.2-т заасан өргөн хэрэглээний хүнсний жагсаалтыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>10 дугаар зүйл.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага</p> <p>10.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах нийтлэг шаардлага тавина:</p> <p>10.1.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах;</p> <p>10.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх;</p> <p>10.1.3.хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах ажлыг эрх бүхий байгууллагын хянан баталгаажуулсан зураг төслийн дагуу гүйцэтгэх;</p> <p>10.1.4.үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлэх;</p> <p>10.1.5.боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл эрхлэх тохиолдолд мэргэжлийн, эсхүл мэргэшсэн хүний нөөцтэй байх;</p> <p>10.1.6.үйл ажиллагаагаа эхлэхийн өмнө хуульд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн байх;</p> <p>10.1.7.хуульд заасан бол тусгай зөвшөөрөл авсан байх.</p> <p>10.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд дараах хяналт, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж болно:</p> <p>10.2.1.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.3-т заасан аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт;</p> <p>10.2.2.хүнсний чанарын удирдлага;</p> <p>10.2.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын удирдлага.</p> <p>10.3.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу баталсан жагсаалтад орсноос бусад пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглоно.</p>
<p>7</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Хүнсний тухай</p>	<p>11 дүгээр зүйл.Хүнс экспортлох, импортлоход тавих шаардлага</p> <p>11.1.Хүнснийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд экспортлож, импортлоно.</p> <p>11.2.Энэ хуулийн 11.1-д заасан хуулийн этгээд Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>11.2.1.экспортлогч улсын үйлдвэртэй шууд, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай худалдааны гэрээ байгуулсан байх;</p> <p>11.2.2.импортлох хүнс нь зохистой дадал, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулсан үйлдвэрийнх байх;</p> <p>11.2.3.импортлох хүнсний хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй хугацаа байх;</p>

7	Хүнсний тухай	<p>11.2.4.стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх, эсхүл энэ шаардлагыг хангасан хуулийн этгээд, байгууллагатай гэрээтэй байх.</p> <p>11.3.Импортлогч энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлээгүй, олон улсад хэрэглэдэг таних тэмдэг, тэмдэглэгээгүй баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө /цаашид “өсгөврийн хөрөнгө” гэх/, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс, энэ хуулийн 7.2-т заасны дагуу бүртгүүлээгүй хувиргасан амьд организмаас гаралтай хүнсийг импортлохыг хориглоно.</p>
8	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1 Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.</p> <p>7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох журам</p> <p>7.1. Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно.</p> <p>7.2. Хуульд заасан бол хүнсний чиглэлийн үйл ажиллагааг зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.</p> <p>7.3. Тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна.</p> <p>7.4. Эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгоно.</p> <p>15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл</p> <p>15.10. Үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр:</p> <p>15.10.12. согтууруулах ундаа импортлох;</p> <p>15.10.14. тамхи импортлох.</p> <p>16 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгох аж ахуйн үйл ажиллагааны төрөл</p> <p>16.2.5. согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх;</p> <p>16.3.4. тамхи худалдах.</p>

9	<p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай</p> <p>1.2. дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Хорио цээрийн хяналт, шалгалтад хамаарах зүйл</p> <p>4.1. Энэ хуулийн хүрээнд дор дурдсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтад хамруулна:</p> <p>4.1.1. бүх төрлийн сүүн тэжээлтэн тэжээвэр болон зэрлэг амьтан, хэвлээр явагч усны амьтан, шувуу, зөгий, тэдгээрийн үр, хөврөл үр, үржлийн өндөг;</p> <p>4.1.2. мах, сүү, дайвар бүтээгдэхүүн, өөх, хүнсний өндөг, арьс, шир, яс, ноос, ноолуур, үс, олон, эвэр, туурай, шувууны өд, сөд, сарвуу, чив, засаа, залаа, цөс, булчирхай зэрэг амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн;</p> <p>4.1.3. байгалийн болон таримал дээд, доод ургамал, мод, тэдгээрийн үр, суулгац, хэсэг;</p> <p>4.1.4. үр тариа, төмс, хүнсний ногоо, өвс, тэжээл, үрлэн кофе, хөнгөн болон хүнсний үйлдвэрт хэрэглэгдэх ургамлын гаралтай бусад түүхий эд, ургамлын хатаадас, цуглуулга, тасалбар, зүсмэл мод, түүний хэсэг, бүх төрлийн жимс, жимсгэнэ, гурил, будаа, элсэн чихэр, амтлагч зэрэг ургамлын гаралтай аливаа зүйлс;</p> <p>4.1.5. цус болон цусны ийлдэс, сийвэн;</p> <p>4.1.6. ангийн олзвор;</p> <p>4.1.7. төрөл бүрийн эмгэг төрүүлэгч хорхой, шавьж, бичил биетний өсгөвөр, биотехнологийн аргаар гарган авсан хувиргасан амьд организм;</p> <p>4.1.8. амьтны хүүр, сэг, ялгадас, эмгэгт материал;</p> <p>4.1.9. хөрс, хүлэр, чулуу;</p> <p>4.1.10. тээврийн хэрэгсэл, чингэлэг, сав, баглаа боодол, чигжээс, зөөлөвч, дэвсгэр, хашлага, хөвөнгийн “хөөвөр”, амьтны тоног хэрэгсэл, уяа татлага.</p> <p>9 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих нийтлэг шаардлага</p> <p>9.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд иргэн, хуулийн этгээд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:</p> <p>9.1.1. Монгол Улсаас гадаад улстай амьтан, ургамлын хорио цээрийн талаар байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцид заасан стандарт, удирдамж, зөвлөмжийн нөхцөлийг мөрдөх;</p> <p>9.1.2. экспортлогч улсын хорио цээрийн хяналт, баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр гэрчилгээтэй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг хорио цээрийн үзлэг, шалгалтанд оруулах;</p> <p>9.1.3. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн, тэдгээрийн хашлага, дэвсгэр, сав, баглаа боодол, тээврийн хэрэгсэлд хорио цээрийн үзлэг, шалгалтыг хилийн боомт, гүний гаалийн хяналтын талбай дээр хийлгэх;</p> <p>9.1.4. биологийн эмгэгт материал, бичил биетний омог, өсгөврийн дээж, хөрс, хөрстэй ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар хил нэвтрүүлэх ба хүлээн авагч улсын холбогдох этгээдэд хүргэх хүртэл сав, баглаа боодол, битүүмжлэлийг задлахгүй байх.</p> <p>10 дугаар зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлоход тавих шаардлага</p> <p>10.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлоход энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>10.1.1. тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн нь амьтны гоц халдварт өвчин гараагүй, ургамлын хорио цээртэй зүйл тархаагүй тайван улс, бүсээс гаралтай байх;</p> <p>10.1.2. тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний зөвшөөрөгдөх эрсдэлийг тогтоолгосон байх.</p> <p>11 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн экспортлоход тавих шаардлага</p> <p>11.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлоход энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>11.1.1. импортлогч улстай тохиролцсон хорио цээрийн нөхцөл, эсхүл хорио цээрийн талаархи Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, олон улсын байгууллагаас гаргасан стандарт, удирдамж, зөвлөмжид нийцсэн байх;</p> <p>11.1.2. экспортын шаардлага хангаж буйг нотолж эрх бүхий байгууллагаас гэрчилгээ олгосон байх.</p>
---	---

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай	<p>12 дугаар зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг дамжуулан өнгөрүүлэхэд тавих шаардлага</p> <p>12.1. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжуулан өнгөрүүлэхэд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан нийтлэг шаардлагаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>12.1.1. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжуулан өнгөрүүлэх тухай хүсэлтээ энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд улсын мэргэжлийн хяналтын байгууллагад урьдчилан мэдэгдэж, зохих мэдэгдэл авсан байх;</p> <p>12.1.2. амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлийн дэгдэлт гараагүй тайван улс, бүсээс гаралтай амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн байх;</p> <p>12.1.3. тухайн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чингэлэгийн лац, ломбо бүрэн бүтэн байх.</p> <p>12.2. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг дамжуулан өнгөрүүлэх үед улсын мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслээс буулгахыг хориглоно.</p> <p>12.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас болон амраах, услах, тэжээх зорилгоор амьтныг маршрутын дагуу урьдчилан тогтоосон цэгт улсын байцаагчийн хяналтын дор тээврийн хэрэгслээс буулгах үйл ажиллагаанд энэ хуулийн 12.2 дахь хэсэг хамаарахгүй.</p> <p>12.4. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх замд амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн тохиолдолд улсын мэргэжлийн хяналтын байгууллага энэ тухай импортлогч, экспортлогч улсын хяналтын эрх бүхий байгууллагад яаралтай мэдэгдэж, энэ хуулийн 13, 14, 15, 16 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.</p> <p>13 дугаар зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэхийг хориглох</p> <p>13.1. Дараахь тохиолдолд амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно:</p> <p>13.1.1. энэ хуулийн 10.1, 11.1-д заасан шаардлагыг хангаагүй;</p> <p>13.1.2. хорио цээрийн хяналт, шалгалтанд ороогүй, эсхүл гэрчилгээнд бичигдсэн мэдээлэл зөрүүтэй буюу дагалдах бичиг баримт нь хуурамч болох нь хяналт, шалгалтын явцад тогтоогдсон.</p> <p>13.2. Энэ хуулийн 12.1.2, 12.1.3-т заасан шаардлагыг хангаагүй амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглож, энэ тухай улсын мэргэжлийн хяналтын байгууллага нь экспортлогч улсын хилийн боомтын хяналтын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.</p> <p>13.3. Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан үндэслэлээр амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон тухай мэдэгдлийг улсын байцаагч хариуцагч иргэн, хуулийн этгээдэд гардуулан өгнө.</p> <p>13.4. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон тухай мэдэгдэл хүлээн авсан иргэн, хуулийн этгээд амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлогч улсад буцаах үүрэгтэй.</p> <p>14 дүгээр зүйл. Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх, дамжуулан өнгөрүүлэх үед түр саатуулах</p> <p>14.1. Улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтаар өвчний шинж тэмдэг илэрсэн амьтан, шавьж илэрсэн ургамал, гэмтэж муудсан нь тогтоогдсон түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын байцаагч 21 хүртэл хоногийн хугацаагаар түр саатуулж, энэ тухай мэдэгдлийг хариуцагч иргэн, хуулийн этгээдэд гардуулан өгнө.</p> <p>14.2. Түр саатуулах тухай мэдэгдэл хүлээн авсан иргэн, хуулийн этгээд хилийн боомт, гүний гаалийн хяналтын талбайд тусгайлан бэлтгэсэн хашаа, байр, агуулах, талбайд улсын байцаагчийн шийдвэрээр, түүний хяналтын дор амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээврийн хэрэгслээс буулгаж нарийвчилсан үзлэг хийлгэнэ.</p> <p>14.3. Улсын байцаагч хорио цээрийн нарийвчилсан үзлэг хийж, шинжилгээний дээж аван холбогдох лабораторид хүргүүлнэ. Дээж хүлээн авсан лаборатори нь 14 хоногийн хугацаанд багтаан шинжилгээний хариуг гаргана.</p> <p>14.4. Лабораторийн шинжилгээний хариу болон хорио цээрийн хугацаанд хийсэн ажиглалт, үзлэгийн дүнг үндэслэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх эсэхийг хилийн боомт, гүний гаалийн мэргэжлийн хяналтын байгууллага шийдвэрлэнэ.</p> <p>14.5. Лабораторийн шинжилгээнд орсон зүйлээс амьтны гоц халдварт өвчин оношлогдсон, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн бол амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн, тэдгээрийг тээвэрлэхэд хэрэглэсэн хашлага, тоног хэрэгсэл, өвс, тэжээлийн үлдэгдэл, дэвсгэр, сав, баглаа, боодол, чигжээсийг энэ хуулийн 15.2-т заасны дагуу устгана.</p> <p>14.6. Энэ хуулийн 12.1.1-д заасан шаардлагыг хангаагүй амьтан ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тодорхой хугацаагаар түр саатуулж, экспортлогч улсын хорио цээрийн хяналтын байгууллагад мэдэгдэн, зөрчлийг арилгуулсаны үндсэн дээр дамжуулан өнгөрүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.</p>
---	--

	<p>19 дүгээр зүйл. Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тавих шаардлага</p> <p>19.1. Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>19.1.1. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал, таатай нөхцөлийг хангасан, халуун, хүйтний хэмийг тохируулах боломжтой байхаар тоноглогдсон байх;</p> <p>19.1.2. тээвэрлэлтийн өмнө технологийн дагуу цэвэрлэж, ариутгаж халдваргүйжүүлсэн байх;</p> <p>19.1.3. чингэлэг, хашлагыг нээх үед амьтны хэвтэр, ялгадас, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн асгарахааргүй ачигдсан байх.</p> <p>25 дугаар зүйл. Импорт, экспортын гэрчилгээ</p> <p>25.1. Импортын гэрчилгээг экспортлогч улсын мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн эрх бүхий байгууллагаас олгосон экспортын гэрчилгээ, улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон импортын мэдэгдэл, шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагч олгоно.</p> <p>25.2 Экспортын гэрчилгээг хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан тусгайлан эрх олгосон мэргэжлийн байгууллага олгоно.</p> <p>25.3. Экспорт, импортын гэрчилгээ нь олон улсын амьтны халдварт өвчний болон ургамал хамгааллын байгууллагын баталсан загварын дагуу хийгдэж, экспортлогч, импортлогч улсын харилцан тохиролцсон хэлээр бичигдсэн байна.</p> <p>25.4. Экспортын гэрчилгээг тухайн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг ачуулахын өмнө 24 цагийн дотор олгосон байна.</p>
<p>10</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ</p> <p>3.1.Энэ хууль хүнсний түүхий эдийн анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон тэдгээрийг хадгалах, тээвэрлэх, худалдах, үйлчлэх, импортлох, экспортлох, хүнсийг савлах, шошголох зэрэг хүнсний сүлжээний бүх үе шатанд үйлчилнэ.</p> <p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>4.1.1.“хүнсний бүтээгдэхүүн” гэж Хүнсний тухай хуулийн 3.1.1-д зааснаас гадна савласан ус, бүх төрлийн ундаа, бохь, хүнсний нэмэлтийг;</p> <p>4.1.6.“хүнсний сүлжээ” гэж хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэх, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг</p> <p>4.1.20.“эрүүл ахуйн зохистой дадал” гэж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад шаардагдах ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, үйл ажиллагааг;</p> <p>4.1.21.“үйлдвэрлэлийн зохистой дадал” гэж үйлдвэрлэлийн бүх үе шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад шаардагдах нөхцөл, хяналт, үйл ажиллагааг.</p> <p>7 дугаар зүйл.Хүнсний сүлжээнд аюулгүй байдлыг хангах арга, хэлбэр</p> <p>7.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ:</p> <p>7.1.2.хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал;</p> <p>17.1.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаар хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>17.1.1.хүнсний сүлжээнд зохистой дадлыг нэвтрүүлэх талаар сургалт зохион байгуулах;</p>
	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ</p> <p>3.1.Энэ хууль нь дор дурдсан аж ахуйн нэгжийн орлогод албан татвар ногдуулах харилцааг зохицуулна:</p> <p>3.1.1.Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар;</p> <p>3.1.2.удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгж;</p>

11	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай	<p>3.1.3.Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олсон гадаадын аж ахуйн нэгж, тэдгээрийн төлөөний газар.</p> <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>4.1.5.“аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани,нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээдийг;</p> <p>5 дугаар зүйл. Албан татвар төлөгч</p> <p>5.1.Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлогогүй ч хуульд заасны дагуу албантатвар төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгж нь албан татвар төлөгч байна.</p> <p>5.2.Энэ хуулийн 5.1-г заасан албан татвар төлөгчийг Монгол Улсад байнгабайрладаг, байрладаггүй албан татвар төлөгч гэж ангилна.</p> <p>5.3.Монгол Улсад байнга байрладагалбан татвар төлөгчид дараахь аж ахуйн нэгж хамаарна:</p> <p>5.3.1.Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж;</p> <p>5.3.2.удирдах байгууллага нь Монгол Улсад байрладаг гадаадын аж ахуйн нэгж.</p> <p>5.4.Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчид дараахь аж ахуйн нэгж хамаарна:</p> <p>5.4.1.төлөөний газраараа дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж;</p> <p>5.4.2.энэ хуулийн 5.4.1-д зааснаас бусад хэлбэрээр Монгол Улсын нутаг дэвсгэрт болон Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олсон гадаадын аж ахуйн нэгж.</p> <p>5.5.Энэ хуулийн 5.4.1-г заасан аж ахуйн нэгжийн аж ахуйн үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчлэн явуулж байгаа дараахь нэгжийг төлөөний газарт хамааруулна:</p> <p>5.5.1.салбар/цех, тасаг/;</p> <p>5.5.2.үйлдвэр;</p> <p>5.5.3.худалдаа, үйлчилгээний газар;</p>
12	Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүс (цаашид “Алтанбулаг” бүс гэх)-ийн эрх зүйн байдлыг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. “Алтанбулаг” бүсийн нутаг дэвсгэр</p> <p>3.1.”Алтанбулаг” бүс нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Их Хурлаас тогтоосон хилийн зааг бүхий газар нутагтай байна.</p> <p>4 дүгээр зүйл. Орлогын албан татварын хөнгөлөлтгүүлэх, албан татвараас чөлөөлөх</p> <p>4.1. “Алтанбулаг” бүсэд цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, цэвэр усан хангамж, авто, төмөр зам, телекоммуникацийн үндсэн сүлжээний салбарт хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно.</p> <p>4.2. ”Алтанбулаг” бүсэд агуулахын аж ахуй, ачиж буулгах байгууламж, зочид буудал барьж байгуулахад хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс орлогын албан татвараас 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.</p> <p>4.3.”Алтанбулаг” бүсэд бараа, бүтээгдэхүүнийг хадгалах, хамгаалах, сав, баглаа боодлыг сайжруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа, 10 болон түүнээс дээш жил ажиллахаар чөлөөт бүсийн захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тооцон орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.</p> <p>4.4.”Алтанбулаг” бүсийн захирагчийн ажлын албанд бүртгүүлэн чөлөөт бүсэд байнга оршин сууж байгаа иргэн, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагыг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас чөлөөлнө.</p> <p>4.5. “Алтанбулаг” бүсийн захирагчийн ажлын албанд бүртгүүлэн бүсэд байнга оршин сууж байгаа иргэн, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын өмчид байгаа үл хөдлөх эд хөрөнгийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд худалдан борлуулсан тохиолдолд ногдох орлогын албан татвараас чөлөөлнө.</p>
13	Арбитрын тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаанд арбитрын ажиллагаа явуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.</p>

14	Авто тээврийн тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, автотээвэрлэлт болон автотээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо</p> <p>3.1.14. “хүнсний технологийн тээвэрлэлт” гэж хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор түргэн муудах болон хадгалалтын тусгай горимд тухайн бүтээгдэхүүний шинж чанарыг алдагдуулахгүйгээр тээвэрлэх тээвэрлэлтийг; /Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар нэмсэн/</p> <p>10 дугаар зүйл. Тээвэрлэгчийн эрх, үүрэг</p> <p>10.2. Тээвэрлэгч дараах үүрэг хүлээнэ:</p> <p>10.2.2. ачаа, зорчигчийг тээвэрлэлтийн нөхцөл, техникийн шаардлага хангасан зориулалтын тээврийн хэрэгслээр тав тухтай, аюул, осолгүй тээвэрлэх.</p> <p>11 дүгээр зүйл. Тээвэрлүүлэгч, зорчигчийн эрх, үүрэг</p> <p>11.2. Тээвэрлүүлэгч, зорчигч нь дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>11.2.1. ачааны савлалт, баглаа, боодол, бэхэлгээг стандартын дагуу хийж, нэр төрөл, илгээх чиглэлээр нь ялган тээвэрлэхэд бэлтгэх.</p>
15	Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>5 дугаар зүйл. Эдийн засгийг бүсчлэн зохицуулах үйл ажиллагааны шалгуур</p> <p>5.1. Энэ хуульд заасны дагуу бүс нутгийг зохион байгуулахдаа дор дурдсан шаардлагыг үндэс болгоно:</p> <p>5.1.1. байгаль орчиндоо зохицсон эдийн засгийн оновчтой бүтэцтэй байх;</p> <p>5.1.2. үйлдвэрлэл, үйлчилгээний тодорхой салбарыг тэргүүлэх чиглэлээр хөгжүүлсэн байх;</p> <p>5.1.3. бүс нутаг хоорондоо болон дотоод, гадаад зах зээлтэй дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэгээр холбогдсон байх;</p> <p>17 дугаар зүйл. Бүсийн хэлэлцээр</p> <p>17.1. Улсын болон бүс нутгийн хөгжлийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд Засгийн газар, түүнийг төлөөлж төрийн захиргааны холбогдох төв байгууллага, бүсийн хэмжээнд Зөвлөл нь бүсийн хэлэлцээрийг байгуулан ажиллаж болно.</p> <p>17.2. Бүсийн хэлэлцээрээр дор дурдсан асуудлыг зохицуулна:</p> <p>17.2.1. улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр тухайн бүсэд дэд бүтцийг байгуулах;</p> <p>17.2.2. тухайн бүсийн байгалийн баялгийг зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах;</p> <p>17.2.3. тухайн бүсийн хэмжээнд хүн амын суурьшил, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах;</p> <p>17.2.4. бүсийн хөгжлийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв, хотуудыг тохижуулж хөгжүүлэх;</p> <p>17.2.5. гадаад улс, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;</p> <p>17.2.6. тухайн бүсээс экспортод нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээ, зах зээлийг зохицуулах.</p>
16	Валютын зохицуулалтын тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь валютын зохицуулалтын талаарх төрийн зохих байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд валютын гүйлгээ хийх, валютын гүйлгээнд хяналт тавих, Монгол Улсын үндэсний валютыг үнэгүйдлээс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>9 дүгээр зүйл. Валютын гүйлгээ</p> <p>1. Валют худалдах, худалдан авах, хадгалах, зээлдэх, шилжүүлэх, байршуулах, барьцаалах, улсын хилээр оруулах, гаргахтай холбоотой үйл ажиллагааг валютын гүйлгээ гэнэ.</p> <p>2. Банк нь гадаад валютын гүйлгээг түүнтэй тэнцэх хэмжээний үндэсний валютын гүйлгээтэй нэгэн зэрэг гүйцэтгэнэ.</p> <p>3. Монгол Улсын үндэсний валют, чөлөөтэй хөрвөдөггүй гадаад валютыг Монгол Улсын хилээр оруулах, гаргах, валютын гүйлгээнд ашиглах журмыг Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд хамтран батална.</p>

	<p>10 дугаар зүйл. Монголбанкны эрхлэх валютын гүйлгээ</p> <p>1. Монголбанк нь Монгол Улсын валютын гадаад нөөцийг нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор тус улсын болон гадаад орны банк, бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс валют, цэвэршүүлсэн алт худалдан авч болно.</p> <p>2. Монголбанк нь төгрөгийн ханшийг тогтвортой байлгах зорилгоор өөрийн эзэмшилд байгаа валютын гадаад нөөцөөс гадаад валютыг худалдана.</p>
<p>17</p> <p>Гаалийн тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн байгууллагын тогтолцоо, гаалийн байгууллага, албан тушаалтны эрх, үүргийг тодорхойлох, тэдгээрийн шийдвэрт иргэдээс гомдол гаргах, түүнийг нь гаалийн байгууллага, албан тушаалтнаас шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1.“бараа” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх ачаа, тээш, эд юмс, валют, валютын үнэт зүйл, улс хоорондын шуудангийн илгээмж, бүх төрлийн эрчим хүч, мал, амьтан, ургамал зэрэг хөдлөх эд хөрөнгө болон энэ хуулийн 3.1.5-д зааснаас бусад тээврийн хэрэгслийг;</p> <p>3.1.2.“монголын бараа” гэж энэ хуулийн 99.1-д заасан горимын дагуу боловсруулалт хийснээс бусад Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээр чөлөөт эргэлтэд байгаа гадаадын барааг;</p> <p>3.1.3.“гадаадын бараа” гэж энэ хуулийн 3.1.2-т зааснаас бусад барааг;</p> <p>3.1.4.“чөлөөт эргэлтэд байгаа бараа” гэж гаалийн хууль тогтоомжоор тогтоосон хязгаарлалтгүйгээр Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт захиран зарцуулах барааг;</p> <p>3.1.5.“тээврийн хэрэгсэл” гэж бараа болон зорчигчийг улс хооронд тээвэрлэж гаалийн хилээр 6 сараас дээшгүй хугацаагаар нэвтрэх бүх төрлийн тээврийн хэрэгсэл, түүний дотор чингэлэг, ердийн хөсөг, тухайн аяллын хугацаанд тээврийн хэрэгсэлд шаардагдах шатахуун, тосолгооны материал, сэлбэгийг;</p> <p>3.1.6.“тээвэрлэгч” гэж гаалийн хилээр бараа, зорчигч нэвтрүүлэх, эсхүл гаалийн нутаг дэвсгэрт гаалийн хяналт дор тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийг;</p> <p>3.1.14.“тарифын бус хязгаарлалт” гэж Монгол Улсын хилээр бараа нэвтрүүлэхийг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тоон хязгаарлалт тогтоох болон бусад арга хэмжээг;</p> <p>5 дугаар зүйл. Гаалийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээлэл, бичиг баримтыг ашиглах</p> <p>5.1.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг холбогдох этгээд гаалийн хууль тогтоомжид заасны дагуу гаалийн байгууллагад гаргаж өгнө.</p>
<p>18</p> <p>Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь гаалийн тариф, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.1.“гаалийн тариф” гэж гаалийн татварын хувь, хэмжээг;</p> <p>3.1.2.“гаалийн татвар” гэж гаалийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл түүнээс гаргах бараанд гаалийн тарифын дагуу ногдуулах, хураах, төлөх албан татварыг;</p> <p>3.1.3.“бусад татвар” гэж гаалийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл түүнээс гаргах бараанд бусад хуулийн дагуу ногдуулах, хураах, төлөх албан татварыг;</p> <p>3.1.4.“гаалийн үнэ” гэж гаалийн татвар ногдуулах, гаалийн статистикийн мэдээлэл гаргах зорилгоор энэ хуулийн дагуу тодорхойлох үнийг;</p> <p>3.1.6.“татвар төлөгч” гэж Монгол Улсын гаалийн хилээр бараа нэвтрүүлэхээр мэдүүлсэн этгээдийг;</p> <p>3.1.7.“ойролцоо хугацаа” гэж үнэлж буй импортын барааны гаалийн үнийг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдрөөс өмнөх 90 хоногийг;</p> <p>26 дугаар зүйл.Барааны гарал үүслийн дүрэм</p> <p>26.1.Бараанд нэн тааламжтай тариф хэрэглэх болон эдийн засаг, худалдааны бодлого хэрэгжүүлэх зорилгоор Барааны гарал үүслийн дүрмийг Засгийн газар батална.</p>

18	Гаалийн гариф, гаалийн татварын тухай хууль	<p>27 дугаар зүйл.Импортын барааны гарал үүслийн улсыг тодорхойлох</p> <p>27.1.Импортын барааны гарал үүслийн улсыг энэ хууль болон Барааны гарал үүслийн дүрэмд зааснаар тодорхойлно.</p> <p>27.2.Импортын барааны гарал үүслийн улс нь улсуудын холбоо, гаалийн болон эдийн засгийн олон улсын холбоо, барааны гарал үүслийг тодорхойлох зорилгоор тусгайлан заасан нэг улсын тодорхой хэсэг, бүс нутаг байж болно.</p> <p>27.3.Мэдүүлэгчийн хүсэлтээр барааны гарал үүслийн улсыг гаалийн байгууллага урьдчилан тодорхойлж болно.</p> <p>28 дугаар зүйл.Барааг бүрэн үйлдвэрлэсэн улс</p> <p>28.1.Барааг бүрэн үйлдвэрлэсэн улсыг тухайн импортын барааны гарал үүслийн улс гэж үзнэ.</p> <p>28.2.Дараахь нөхцөлийг хангасан тохиолдолд барааг тухайн улсад бүрэн үйлдвэрлэсэн гэж үзнэ:</p> <p>28.2.1.тухайн улсын газрын гадаргуу, түүний хэвлий, нутаг дэвсгэрийн ус, түүний ёроолоос олборлосон эрдэс бүтээгдэхүүн;</p> <p>28.2.2.тухайн улсад хураан авсан хүнсний ногоо;</p> <p>28.2.3.тухайн улсад төрсөн, бойжсон амьд амьтан;</p> <p>28.2.4.тухайн улсын мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн;</p> <p>28.2.5.тухайн улсын нутаг дэвсгэрт агнасан ан, загас агнуурын бүтээгдэхүүн;</p> <p>28.2.6.тэнгисийн загас агнуурын бүтээгдэхүүн, тухайн улсын хөлөг онгоцоор тэнгисийн уснаас гаргаж авсан бусад бүтээгдэхүүн;</p> <p>28.2.7.энэ хуулийн 28.2.6-д заасан бүтээгдэхүүнээр тухайн орны хөлөг онгоцон дээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн;</p> <p>28.2.8.тухайн улсын нутаг дэвсгэрийн усанд үл хамаарах далай, тэнгисийн ёроолоос олборлосон эрдэс бүтээгдэхүүн;</p> <p>28.2.9.тухайн улсад гагцхүү түүхий эдийн зориулалтаар цуглуулсан хуучин эд зүйлс, үйлдвэрийн хог, хаягдал;</p> <p>28.2.10.энэ хуулийн 28.2.1-28.2.9-д заасан бүтээгдэхүүнээр тухайн улсад үйлдвэрлэсэн бараа.</p> <p>29 дүгээр зүйл.Бараанд үлэмж хэмжээний боловсруулалт хийх</p> <p>29.1.Барааг үйлдвэрлэхэд хоёр, түүнээс дээш улс орон оролцсон тохиолдолд барааны гарал үүслийн улсыг түүнд үлэмж хэмжээний боловсруулалт хийсэн улсаар тодорхойлно.</p> <p>29.2.Бараанд үлэмж хэмжээний боловсруулалт хийгдсэн болохыг дараахь шалгуураар тогтооно:</p> <p>29.2.1.барааг боловсруулах, үйлдвэрлэх үйл ажиллагааны улмаас барааны ангиллын код нь Уялдуулсан системийн зүйлийн түвшинд өөрчлөгдсөн байвал;</p> <p>29.2.2.барааны үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа нь тухайн улсыг барааны гарал үүслийн улсаар тооцоход хангалттай бол;</p> <p>29.2.3.тухайн бараанд ашигласан материалын эсхүл нэмэгдсэн өртөг нь эцсийн бүтээгдэхүүний өртгийн 50 болон түүнээс дээш хувийг эзэлж байвал.</p> <p>29.3.Бараанд үлэмж хэмжээний боловсруулалт хийгдсэн шалгуурт дараахь үйл ажиллагаа хамаарахгүй:</p> <p>29.3.1.барааг хадгалах, тээвэрлэх явцад түүний бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа;</p> <p>29.3.2.барааг худалдах, тээвэрлэхэд бэлтгэх үйл ажиллагаа;</p> <p>29.3.3.энгийн угсрах үйл ажиллагаа;</p> <p>29.3.4.өөр өөр улсаас гарал үүсэлтэй барааг хооронд нь холих үйл ажиллагаа.</p> <p>29.4.Энэ хуулийн 29.3.4-т заасан тохиолдолд эцсийн бүтээгдэхүүний шинж чанар нь хольж байгаа бараа бүрийн шинж чанартай адил байна.</p> <p>30 дугаар зүйл.Барааны гарал үүслийн улсыг тодорхойлох онцлог тохиолдол</p> <p>30.1.Үйлдвэрлэл, тээвэрлэлтийн нөхцөлийн улмаас нэг ачилтаар илгээх боломжгүйгээс хэд хэдэн ачилтаар илгээгдсэн, эсхүл угсраагүй буюу задалж салгасан бараа, түүнчлэн тээвэрлэлтийн алдаанаас хэд хэдэн ачилтаар салангид ирсэн барааг гарал үүслийн хувьд нэг бараа гэж үзнэ.</p> <p>30.2.Дараахь нөхцөлийг хангасан бол барааг гарал үүслийн хувьд нэг бараа гэж тооцно:</p>
----	---	---

18	Гаалийн тариф, гаалийн тагварын тухай хууль	<p>30.2.1.барааг угсраагүй, эсхүл задалж салган хэд хэдэн ачилтаар илгээх болсон шалтгааныг зааж, барааны ангиллын код, үнэ, гарал үүслийн улсыг ачилт тус бүрээр заасан жагсаалтыг гарган гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдсэн байх, эсхүл алдааны улмаас барааг салгаж тээвэрлэснийг багтах бичиг баримтыг гаргаж өгсөн байх;</p> <p>30.2.2.ачилт бүрт хамрагдах барааг нэг улсаас, нэг илгээгчээс нийлүүлсэн байх;</p> <p>30.2.3.ачилт бүрт хамрагдах барааг гаалийн нэг байгууллагад мэдүүлсэн байх;</p> <p>30.2.4.ачилт бүрт хамрагдах барааг гаалийн байгууллага гаалийн мэдүүлгийг хүлээн авсанаас хойш 3 сарын дотор гаалийн нутаг дэвсгэрт оруулсан байх.</p> <p>30.3.Мэдүүлэгчийн хүсэлтээр энэ хуулийн 30.2.4.-г заасан хугацааг нэг хүртэл сараар 1 удаа сунгаж болно.</p> <p>30.4.Машин, тоног төхөөрөмж, аппарат, тээврийн хэрэгслийг тэдгээрийг ашиглахад шаардагдах сэлбэг, эд анги, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хамт нийлүүлсэн тохиолдолд тэдгээрийн гарал үүслийн улс нь ижил байна.</p> <p>30.5.Гаалийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааны сав, баглаа боодол нь түүнийг тусад нь мэдүүлснээс бусад тохиолдолд тухайн бараатай ижил гарал үүсэлтэй байна.</p> <p>30.6.Барааны гарал үүслийг тодорхойлоход түүний үйлдвэрлэл, боловсруулалтад ашигласан цахилгаан эрчим хүч, машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн гарал үүслийн улсыг тооцохгүй.</p> <p>31 дүгээр зүйл.Барааны гарал үүслийн улсыг нотлох баримт</p> <p>31.3. Импортлогч улсад татварын хөнгөлөлт эдлэх зорилгоор мэдүүлэгч нь барааны гарал үүслийн улсыг нотлох баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгч болно.</p> <p>31.4.Гаалийн байгууллага нь барааны гарал үүслийн улсыг нотлох баримтыг нягтлан шалгаж болно.</p> <p>31.5.Импортын барааны гарал үүслийн улсыг нягтлан шалгах хугацаа 30 хоногоос хэтрэхээргүй байх бөгөөд гаалийн удирдах төв байгууллага уг хугацааг нэг удаа 30 хоногоор сунгаж болно.</p>
19	Газрын тосны бүтээгдэхүүний тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1 Энэ хуулийн зорилт нь газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах болон эдгээр үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ</p> <p>3.1 Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд энэ хууль үйлчилнэ.</p> <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо</p> <p>4.1.1. “газрын тосны бүтээгдэхүүн” гэж газрын тос болон химийн нэгдлүүдийг боловсруулах замаар гарган авсан бүх төрлийн шатахуун, тусгай шингэн, шатдаг хий, тос тосолгооны материал, битум, мазут болон бусад бүтээгдэхүүнийг;</p> <p>4.1.3. ”агуулах” гэж газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, савлах, бөөний худалдаа эрхлэхэд зориулсан байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн цогцолборыг;</p> <p>4.1.4. “түгээх станц” гэж газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, тээврийн хэрэгслийг цэнэглэх, савласан бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэхэд зориулсан барилга, байгууламжийн цогцолборыг;</p> <p>4.1.5. “компанийн нөөц” гэж газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хангамж, худалдааны хэвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардагдах хэмжээний тухайн этгээдийн эзэмшлийн агуулах, саванд хадгалагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг;</p> <p>4.1.6 “газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа” гэж газрын тосны бүтээгдэхүүнийг нэг удаад тээврийн хэрэгслийн нэг торхны хэмжээнээс багагүй хэмжээгээр борлуулалт хийхийг.</p> <p>5 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаархи Засгийн газар болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</p> <p>5.1.3газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийннөөцийн хэмжээ, нөөц бүрдүүлэх журмыг багтах;</p> <p>5.1.4. газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэвийн бус өсөлт, хангамжийн тасалдал, хомсдол үүсэх нөхцөлд зохицуулалт хийх;</p> <p>5.1.5. импортлож байгаа газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтыг хилийн боомтуудад хийх бодлогыг хэрэгжүүлэх, нөхцөлийг бүрдүүлэх.</p>

19	Газрын тосны бүтээгдэхүүний тухай	<p>5.2. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын тосны бүтээгдэхүүний талаар дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.2.1. газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>5.2.2. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;</p> <p>5.2.3. газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын асуудалтай холбогдсон дүрэм, журам, нормыг баталж, мөрдүүлэх;</p> <p>5.2.4. газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийннөөцийн талаар санал боловсруулан Засгийн газраар шийдвэрлүүлж хэрэгжүүлэх.</p> <p>6 дугаар зүйл. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх</p> <p>6.1. Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>6.1.1. газрын тосны бүтээгдэхүүний талаархи бодлогыг хэрэгжүүлэх;</p> <p>6.1.2. газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалахтай холбоотой стандарт, дүрэм, журам, нормын төслийг боловсруулах;</p> <p>6.1.3. газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр, агуулах, түгээх станц барьж байгуулах, шинэчлэх зураг төсөлд техник, технологийн талаар дүгнэлт гаргах;</p> <p>6.1.6. газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаар мэдээллийн сан бүрдүүлэх, бодлого зохицуулалтад шаардлагатай нэмэлт судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;</p> <p>6.1.7. газрын тосны бүтээгдэхүүний зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 14.1.5-д заасны дагуу холбогдох байгууллага болон төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгөх, энэ талаар санал гаргах;</p> <p>6.1.8. газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах талаар сургалт явуулах, мэдээлэл арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх;</p> <p>6.1.9. газрын тосны бүтээгдэхүүний олон улсын биржийн үнийг судлах, импортлогчийн нийлүүлэгчээс худалдан авах үнийг хянах.</p> <p>7 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох</p> <p>7.1. Бүх төрлийн шатахууныг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр импортлох бөгөөд импортлогч дор дурдсан үүрэг хүлээнэ:</p> <p>7.1.1. чанарын хувьд олон улсын стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох;</p> <p>7.1.2. импортолсон бүтээгдэхүүн олон улсын стандартад нийцсэн эсэх талаар итгэмжлэгдсэн сорилтын лабораториор дүгнэлт гаргуулах;</p> <p>7.1.3. бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эзэмшилдээ стандартын шаардлага хангасан агуулахтай байх;</p> <p>7.1.4. газрын тосны бүтээгдэхүүнийг нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр импортлох.</p> <p>9 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүнийг худалдах</p> <p>9.1. Бүх төрлийн шатахууны бөөний болон жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.</p> <p>9.2. Энэ хуулийн 9.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргагч нь энэ хуулийн 5.2.5-д заасан журам болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлнэ:</p> <p>9.2.1. хэмжих хэрэгсэл, шингэний тоолуурыг Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн дагуу загварын туршилтад хамруулсан бичиг баримт;</p> <p>9.2.2. стандартын шаардлага хангасан агуулах, түгээх станцын үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл эдгээрийн түрээсийн гэрээ.</p> <p>9.3. Газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгч дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>9.3.1. газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэгч бүтээгдэхүүн борлуулах тухай бүрдээ худалдан авагчид чанарын гэрчилгээ олгох;</p> <p>9.3.2. чанарын баталгаатай газрын тосны бүтээгдэхүүн худалдах;</p> <p>9.3.3. газрын тосны бүтээгдэхүүнийг улсын баталгаатай түгээгүүрээр худалдах;</p> <p>9.3.4. газрын тосны бүтээгдэхүүнийг баталгагүй түгээгүүр, авто болон вагонцистернээс шууд худалдахгүй байх;</p>
----	-----------------------------------	---

		<p>9.3.5. газрын тосны бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан саванд хадгалж, зөвшөөрөгдсөн талбай, орчинд худалдах;</p> <p>9.3.6. тос, тосолгооны материал, тусгай шингэнийг зөвхөн зориулалтын саванд үйлдвэрийн аргаар технологийн дагуу савлаж худалдах;</p> <p>9.3.7. бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч газрын тосны бүтээгдэхүүний чанарын шинжилгээний лабораторитой байх.</p>
20	Дампуурлын тухай хууль	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь дампуурлын хэрэг үүсгэх, хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо</p> <p>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1. “нэхэмжлэгч” гэж хариуцагчаас үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийг;</p> <p>3.1.2. “хариуцагч” гэж тусгай зориулалтын компани, орон сууцны санхүүжилтын компаниас бусад төлбөрийн чадваргүй болсон нөхөрлөл, хоршоо, компани, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хуулийн этгээдийн эрх бүхий төрийн бус байгууллагыг.</p>
21	Жижиг дунд үйлдвэрийн тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь төрөөс жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжлийг хангахад оршино</p> <p>Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч</p> <p>5.1.2. контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 149-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;</p> <p>5.2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж нь компани, хоршоо, нөхөрлөл гэсэн хэлбэртэй байх бөгөөд энэ хуулийн 5.1-д заасан шаардлагыг хангаж буй эсэхийг тогтоохдоо тухайн хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар, хараат болон охин компанийн холбогдох үзүүлэлтийг оруулж тооцно.</p> <p>8 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарахгүй этгээд</p> <p>8.1. Дараахь төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарахгүй:</p> <p>8.1.1. тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл;</p> <p>8.1.2. төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаа;</p> <p>8.1.3. банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгалын үйлчилгээ;</p> <p>8.1.4. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах.</p> <p>11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх</p> <p>11.1. Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>
21	Жижиг дунд үйлдвэрийн тухай	<p>11.1.1. жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;</p> <p>14.2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>14.2.3. зохих стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх;</p> <p>14.2.4. байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;</p> <p>14.2.5. импортыг орлох, экспортод чиглэсэн бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэл баримтлах.</p>

<p>22</p>	<p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Замын-Үүд үдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байгуулсан тухай</p> <p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс /цаашид “Замын-Үүд” бүс гэх/-ийн эрх зүйн байдлыг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл.”Замын-Үүд” бүсийн нутаг дэвсгэр, хэлбэр 3.1.”Замын-Үүд” бүс нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Их Хурлаас тогтоосон хилийн зааг бүхий газар нутагтай байна. 3.2.”Замын-Үүд” бүс үйлдвэрлэлийн, худалдааны, аялал жуулчлал-үйлчилгээний хэлбэрээс бүрдэнэ. 3.3. “Замын-Үүд” бүсэд казино байгуулж болно.</p>
<p>23</p>	<p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Зар сурталчилгааны тухай</p> <p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгааг бүтээх, байрлуулах, түгээх, түүнд хяналт тавих болон шударга өрсөлдөөнд харшлах, хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хуурч мэхлэх, тэдний ашиг сонирхолд хохирол учруулахуйц зар сурталчилгааг хориглохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо 3.1.1.”зар сурталчилгаа” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид “бүтээгдэхүүн” гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн</p> <p>6 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд тавих ерөнхий шаардлага 6.1.Зар сурталчилгаа нь үнэн, хэрэглэгчдэд хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна. 6.2.Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаатай холбоотой бичмэл зар сурталчилгаанд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын нэр, зөвшөөрлийн дугаарыг тусгасан байна. 6.3.Зар сурталчилгаанд статистик мэдээ, судалгааны дүн, баримтыг ашиглахдаа тухайн эх сурвалжийг нь заавал тусгасан байна. 6.4.Хортой, галын аюултай барааны зар сурталчилгаанд тухайн барааны эдгээр шинж чанарын талаар заасан байна. 6.5. Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд дараах зүйлийг хориглоно: 6.5.1.тусгай зөвшөөрөл аваагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулах; 6.5.2.Монгол Улсын хууль тогтоомжоор үйлдвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бүтээгдэхүүнийг сурталчлах; 6.5.3. тарифын бус хязгаарлалт тогтоосон барааг сурталчлах; 6.5.4.хуульд заасны дагуу чанар, стандарт, эрүүл ахуйн баталгаажуулалтад заавал хамруулах бүтээгдэхүүнийг ийнхүү баталгаажуулаагүй бол сурталчлах; 6.5.5.Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг; 6.5.8.хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчилах.</p> <p>12 дугаар зүйл. Интернэтээр түгээх зар сурталчилгаа. 12.1.Зар сурталчилгаа түгээгч нь бусдын эзэмшилд байгаа интернэтийн хуудсанд өөрийн зар сурталчилгаагаа зөвшөөрөлгүй байрлуулахыг хориглоно. 12.2.Интернэтээр түгээж байгаа зар сурталчилгаанд зар сурталчилгаа түгээгчийн нэр, хаяг, харилцах утас зэрэг хэрэглэгч холбоо тогтооход шаардлагатай бусад мэдээлэл байна. 12.3.Хэрэв тухайн зар сурталчилгааг байрлуулсан хаягаар ороход тусгай төлбөр авдаг бол энэ талаархи санамжийг тухайн хаягаар орохоос өмнө хэрэглэгчид харагдахуйцаар байрлуулсан байна.</p> <p>13 дугаар зүйл. Эрүүл мэндийн салбар дахь зар сурталчилгаа 13.1.Олон нийтийн мэдээлэх хэрэгслээр зөвхөн жоргүй олгох эмийн тухай болон эмийг зохистой хэрэглэхтэй холбогдсон сурталчилгаа явуулж болно.</p>

23	Зар сурталчилгааны тухай	<p>13.2.Жороор олгох, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, эмчилгээний зориулалт бүхий мансууруулах бодис, ургамал, түүнчлэн тусгай мэдлэг, мэргэжил шаардагдах эмнэлгийн хэрэгслийг зөвхөн эрүүл мэндийн салбарын ажилтнуудад зориулсан мэдээлэх хэрэгслээр сурталчилна.</p> <p>13.3.Эмийг сурталчлахдаа тэдгээрийг хэрэглэх заавартай танилцахыг заавал сануулна.</p> <p>13.4.Эм, эмийн зүйлс (цаашид “эм” гэх)-ийн зар сурталчилгаанд дараахь зүйлийг хориглоно:</p> <p>13.4.1. улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийг сурталчлах;</p> <p>13.4.2.зөвхөн эмнэлгийн нөхцөлд хэрэглэх эмийг эмийн сан, бусад нөхцөлд борлуулахаар сурталчлах;</p> <p>13.4.3.тухайн эмийн гаж үйлчлэл, хориглох заалтыг нуун далдлах зорилгоор сурталчлах;</p> <p>13.4.4.тухайн эмийн үйлчлэлийн талаар урьдчилсан баталгаа гаргах;</p> <p>13.4.5.эмийн ерөнхий нэршилгүй, зөвхөн худалдааны нэршлээр сурталчлах;</p> <p>14 дүгээр зүйл. Байгаль орчны салбар дахь зар сурталчилгаа</p> <p>14.1.Нэн ховор, ховор ургамал, амьтны жагсаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш, мөчир, навч, бугын цусан эвэр, чив, засаа, согооны сүүл, сав, хүдрийн заар, баавгайн доньд зэрэг эрхтэнийг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгааг хориглоно.</p> <p>14.2.Хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу тодорхой хугацаанд агнах, бэлтгэхийг хориглосон амьтан, ургамлын эд эрхтэн, түүхий эдийг худалдах, худалдан авах тухай зар сурталчилгаа явуулахыг хориглоно.</p> <p>14¹ дүгээр зүйл.Хатуулаг багатай дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа14¹.1.Нийтийн хэвлэл захиалгад орсон сонин, сэтгүүл 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгааг дор дурдсан нөхцөлөөр нийтэлж болно:14¹.1.1.өдөр тутмын сонин нэг нүүрний 50 хувиас хэтрэхгүй хэмжээгээр долоо хоногт 1 удаа;</p> <p>14¹.1.2.энэ хуулийн 14.1.1-д зааснаас бусад сонин нэг удаагийн дугаарын хэвлэлийн нэг нүүрний 50 хувиас хэтрэхгүй хэмжээгээр сард 1 удаа;</p> <p>14¹.1.3.сэтгүүл нэг удаагийн дугаарын нэг нүүрнээс хэтрэхгүй хэмжээгээр сард 1 удаа.</p> <p>14¹.2. 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгааг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу интернэтээр түгээж болно.</p> <p>14¹.3.18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгаа нь согтууруулах ундааны хэрэглээг уриалсан шинжтэй байж болохгүй бөгөөд уг зар сурталчилгаанд “Хэтрүүлэн хэрэглэх нь таны эрүүл мэндэд хортой” гэсэн санамж, анхааруулгыг заавал хэрэглэсэн байна.</p> <p>14¹.4.18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архийг үйлдвэрлэгч, борлуулагч аж ахуйн нэгж нь нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах, дэмжих зорилгоор ивээн тэтгэсэн, санхүүжүүлсэн, хандив өгсөн бол уг арга хэмжээг зохион байгуулж байгаа газарт тухайн бүтээгдэхүүнээ сурталчилсан ханын самбар, зурагт хуудас, түүнтэй адилтгах бусад сурталчилгааны хэрэгслийг байрлуулж болно.</p>
24	Иргэний хууль	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.</p> <p>1.2.Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ.</p> <p>1.3.Хуульд өөрөөр заагаагүй бол татвар, төсөв, санхүү зэрэг захиргааны хууль тогтоомжоор зохицуулах болон захиргааны талаар нэг этгээд нөгөөдөө захирагдах эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.</p> <p>4 дүгээр зүйл. Иргэний хуулийг төсөөтэй хэрэглэх</p> <p>4.1.Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ.</p> <p>4.2.Төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй бол тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна.</p> <p>4.3.Тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно.</p>

24 Иргэний хууль	<p>5 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэх</p> <p>5.1. Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэхгүй.</p> <p>5.2. Шинээр баталсан хууль тогтоомж нь гэрээний нэг буюу хоёр талын эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол гэрээний нөхцөл хүчин төгөлдөр байна.</p> <p>5.3. Гэрээний талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнө үйлчилж байсан хууль тогтоомжоос илүү тааламжтай нөхцөл олгож байгаа шинээр баталсан хууль тогтоомжийг хэрэглэж болно.</p> <p>6 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцааны объект</p> <p>6.1. Хуульд заасан үндэслэл, журмаар иргэний гүйлгээнээс хасагдаагүй, мөнгөөр үнэлж болох, эдийн болон эдийн бус баялаг иргэний эрх зүйн харилцааны объект байна.</p> <p>6.2. Эдийн болон эдийн бус эрх, үйлдэл, эс үйлдэхүй, мэдээлэл иргэний эрх зүйн харилцааны объект байж болно.</p> <p>7 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч</p> <p>7.1. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна.</p> <p>7.2. Иргэн гэж иргэний эрх зүйн харилцаанд оролцогч- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно.</p> <p>7.3. Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно.</p> <p>8 дугаар зүйл. Иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл</p> <p>8.1. Иргэний эрх зүйн харилцаа дараахь үндэслэлээр үүснэ:</p> <p>8.1.1. хуульд заасан буюу заагаагүй боловч агуулгын хувьд хуульд үл харшлах хэлцэл;</p> <p>8.1.2. иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн шүүхийн шийдвэр;</p> <p>8.1.3. хуульд заасан бол иргэний эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн захиргааны шийдвэр;</p> <p>8.1.4. оюуны үнэт зүйл бүтээх;</p> <p>8.1.5. гэм хор учруулах;</p> <p>8.1.6. үндэслэлгүйгээр эд юмс олж авах, эзэмших;</p> <p>8.1.7. иргэний эрх зүйн харилцааг үүсгэсэн хууль зүйн үйл явдал бий болох;</p> <p>8.1.8. иргэний эрх зүйн харилцаа үүсгэхээр хуульд заасан бусад үндэслэл.</p> <p>9 дүгээр зүйл. Иргэний эрх зүйн хамгаалалт</p> <p>9.1. Иргэний эрх зүйн хамгаалалт нь зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой байна.</p> <p>9.2. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч эрхээ хамгаалуулах этгээдийг хуульд заасны дагуу сонгох эрхтэй.</p> <p>9.3. Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитр хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ.</p> <p>9.4. Иргэний эрхийг дараахь аргаар хамгаална:</p> <p>9.4.1. эрхийг хүлээн зөвшөөрөх;</p> <p>9.4.2. эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчихөөс өмнөх байдлыг сэргээх;</p> <p>9.4.3. хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх;</p> <p>9.4.4. учруулсан хохирлыг арилгуулах;</p> <p>9.4.5. эдийн бус гэм хорыг арилгуулах;</p> <p>9.4.6. хууль болон гэрээнд заасан анз төлүүлэх;</p> <p>9.4.7. бусдын эрх зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгох;</p> <p>9.4.8. иргэний эрх зүйн харилцааг өөрчлөх, дуусгавар болгох;</p> <p>9.4.9. өөртөө туслах;</p> <p>9.4.10. хуулиар тогтоосон бусад арга.</p> <p>25 дугаар зүйл. Хуулийн этгээд</p> <p>25.1. Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.</p> <p>25.2. Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно.</p>
---------------------	--

24	<p style="text-align: center;">Иргэний хууль</p> <p>33 дугаар зүйл. Хуулийн этгээдийн төрөл</p> <p>33.1. Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна.</p> <p>33.2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.</p> <p>34 дүгээр зүйл. Компани</p> <p>34.1. Хувь эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ.</p> <p>34.2. Компанийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.</p> <p>35 дугаар зүйл. Нөхөрлөл</p> <p>35.1. Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.</p> <p>35.2. Нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.</p> <p>36 дугаар зүйл. Холбоо, сан, хоршоо</p> <p>36.1. Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.</p> <p>36.2. Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ.</p> <p>36.3. Холбоо, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.</p> <p>36.4. Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.</p> <p>36.5. Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна.</p> <p>36.6. Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцоходоо сангийн эрх зүйн байдлын талаархи хуулийн заалтыг мөрдөнө.</p> <p>49 дүгээр зүйл. Биржийн хэлцэл</p> <p>49.1. Биржийн гүйлгээнд оруулах эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх / эд хөрөнгө, үнэт цаас гэх мэт/- ээ харилцан шилжүүлэх тухай хэлцлийг хууль тогтоомжид заасан журмын дагуу байгуулж, биржид бүртгүүлнэ.</p> <p>49.2. Хууль, тухайн төрлийн хэлцлийн шинж байдалд харшлахгүй бол биржийн хэлцэлд түүний агуулгад нийцүүлэн зохих гэрээ /худалдах-худалдан авах, комиссийн зэрэг/-ний журмыг хэрэглэж болно.</p> <p>49.3. Талуудын худалдааны нууцыг агуулсан, тэдний зөвшөөрөлгүйгээр мэдээлж болохгүй нөхцөлийг биржийн тухай хууль тогтоомжоор тодорхойлно.</p> <p>49.4. Биржийн хэлцэл байгуулах, түүнээс үүсэх эрх, үүрэгтэй холбогдон гарсан маргааныг эрх бүхий байгууллага хянан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийн талаар талууд шүүхэд гомдол гаргаж болно.</p> <p>83 дугаар зүйл. Хөрөнгө</p> <p>83.1. Аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохиолдолд дээрх баялаг нь хөрөнгө болно.</p> <p>175 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр барьцааны зүйлийг албадан худалдах</p> <p>175.1. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 174 дүгээр зүйлд заасны дагуу шаардлага гаргасан боловч үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлтийг үндэслэн ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан худалдана.</p> <p>175.2. Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, үүрэг гүйцэтгүүлэгчийн хамтран гаргасан өргөдөл, тухайн зүйлийн талаар эд хөрөнгийн эрх бүхий талуудын саналыг харгалзан үл хөдлөх эд хөрөнгийг худалдах өөр хэлбэрийг шүүх тогтоож болно.</p> <p>175.3. Үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч, өмчлөгч дуудлага худалдаанд оролцох эрхтэй.</p> <p>175.4. Үл хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах шийдвэр гарснаар үүрэг гүйцэтгэгч уг эд хөрөнгийн үр шимийг өөртөө үлдээх эрхээ алдана.</p> <p>175.5. Үүрэг гүйцэтгэгч ипотекийн зүйл болох байшин, эсхүл түүний тодорхой хэсэгт өөрөө буюу гэр бүлийн гишүүдийн хамт оршин сууж байгаа бол ипотекийн зүйлийг албадан худалдах тухай шүүхийн шийдвэр гарсан үеэс хөлсөлгөч болж, үүрэг гүйцэтгүүлэгчид орон сууц хөлсөлсний хөлсийг, тухайн үеийн ханшаар төлөх үүрэгтэй.</p> <p>175.6. Дуудлага худалдаа явуулахаар шүүхээс томилогдсон этгээд, дуудлага худалдааг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор явуулна.</p>
----	--

<p>24</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Иргэний хууль</p>	<p>175.7. Дуудлага худалдаа явуулахаар шүүхээс томилогдсон этгээд дуудлага худалдаа эхлэхээс 14 хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийгэд мэдээнэ.</p> <p>176 дугаар зүйл. Дуудлага худалдааг зогсоох, түр хойшлуулах</p> <p>176.1. Дуудлага худалдаа явуулснаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болох өмчлөгч буюу гуравдагч этгээд үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг урьдчилан хангасан тохиолдолд дуудлага худалдаа явуулахыг зогсоож болно.</p> <p>176.2. Шүүх өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн, эд хөрөнгийн эрх бүхий талуудын саналыг харгалзан дараахь тохиолдолд дуудлага худалдаа явуулах ажиллагааг 6 сар хүртэл хугацаагаар түр хойшлуулж болно:</p> <p>176.2.1. Үүрэг гүйцэтгэгчийн төлбөл зохих өрийн шинж чанараас шалтгаалан дуудлага худалдааг түр хойшлуулах боломжтой бол;</p> <p>176.2.2. Өмчлөгчийн хувийн болон эдийн засгийн харилцаа холбоог харгалзан үзэх шаардлагатай бол.</p> <p>176.3. Энэ хуулийн 176.2-т зааснаар дуудлага худалдаа явуулахыг түр хойшлуулах нь үүрэг гүйцэтгүүлэгчид илтгэд сөрөг үр дагавар бий болгоно гэж шүүх үзвэл өмчлөгчийн гаргасан хүсэлтийг хангахгүй байж болно.</p> <p>177 дугаар зүйл. Дуудлага худалдаа явуулах үеийн үнэ</p> <p>177.1. Дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх эд хөрөнгийн санал болгох үнийг дуудлага худалдаа явуулахаас өмнө үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, өмчлөгч харилцан тохиролцож тогтоох бөгөөд хэрэв тохиролцохгүй бол дуудлага худалдаа явуулах эрх бүхий этгээд шинжээчийн саналыг үндэслэн тогтооно. Шинжээчийг дуудлага худалдаа явуулах эрх бүхий этгээд томилно.</p> <p>177.2. Анхны дуудлага худалдаагаар санал болгосон үнэд хүрэх санал гараагүй буюу дуудлага худалдаанд хэн ч оролцоогүй бол хоёр дахь дуудлага худалдааг явуулна.</p> <p>177.3. Хоёр дахь дуудлага худалдааг эхний дуудлага худалдаа явуулснаас хойш 30 хоногийн дотор явуулна. Дуудлага худалдааг хоёр дахь удаа явуулж байгаа тухай хуульд заасан журмаар нийгэд мэдээнэ.</p> <p>177.4. Хоёр дахь дуудлага худалдаанд оролцогчоос санал болгосон үнэ нь дуудлага худалдаа явуулахтай холбогдсон зардал болон үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахад хүрэлцэхүйц байна. Энэ хэмжээнд хүрэхгүй бол дуудлага худалдаа явуулаагүй гэж үзнэ. Дуудлага худалдаатай холбогдсон зардлыг өмчлөгч хариуцна.</p> <p>178 дугаар зүйл. Дуудлага худалдааны зүйлийг өмчлөх эрх үүсэх</p> <p>178.1. Хамгийн өндөр үнэ амласан худалдан авагч албадан дуудлага худалдаа явуулж байгаа бүрэн эрх бүхий этгээдэд үнийг шилжүүлэх үүрэгтэй бөгөөд уг үнээс дуудлага худалдаа явуулахтай холбогдсон зардлыг гаргуулна.</p> <p>178.2. Дуудлага худалдаагаар худалдсан зүйлийн үнийг бүрэн төлсөн үеэс худалдан авагч тухайн зүйлийн өмчлөгч болно.</p> <p>178.3. Өмчлөх эрх шилжсэнээр үүрэг гүйцэтгүүлэгчийн албадан гүйцэтгүүлж байгаа ипотекоос хойш бүртгүүлсэн бусад ипотека болон тухайн хөрөнгийн хувьд хязгаарласан эд хөрөнгийн бүх эрх дуусгавар болно.</p> <p>178.4. Харин тухайн үл хөдлөх эд хөрөнгийн хувьд эдлэх бусад хязгаарлагдмал эрх хэвээр хадгалагдана.</p> <p>178.5. Дуудлага худалдаагаар үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авсан шинэ өмчлөгч нь өмчлөх эрх шилжих үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хөлслөх, түрээслэх гэрээний тал болно.</p> <p>179 дүгээр зүйл. Дуудлага худалдаанаас орсон орлогыг хуваарилах</p> <p>179.1. Үүрэг гүйцэтгүүлэгч нь улсын бүртгэлд ипотекийн эрх бүхий цорын ганц этгээдээр бүртгэгдсэн, эсхүл дуудлага худалдаанаас орсон орлогоос түүнийг зохион байгуулсантай холбогдсон зардлыг төлөөд үлдсэн хэсэг нь бүх үүрэг гүйцэтгүүлэгчдийн шаардлагыг хангахад хүрэлцэхүйц байвал уг худалдааг зохион байгуулсан эрх бүхий этгээд зардлыг тооцсоны дараа үлдсэн орлогыг үүрэг гүйцэтгүүлэгч нарт зохих дараалал, журмын дагуу хуваарилж, үлдэгдлийг эд хөрөнгө нь дуудлага худалдаанд орсон өмчлөгчид шилжүүлнэ.</p> <p>179.2. Хэрэв үл хөдлөх эд хөрөнгийг худалдсан үнэ нь ипотекийн эрх бүхий бүх үүрэг гүйцэтгүүлэгчдийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй байвал дуудлагын худалдааг зохион байгуулсан эрх бүхий этгээд дуудлага худалдаа зохион байгуулахтай холбогдон гарсан зардлыг хасаж, үлдсэн мөнгийг тусгай дансанд хийж, улсын бүртгэлд бүртгүүлсэн дарааллын дагуу үүрэг гүйцэтгүүлэгчдэд хуваарилна.</p> <p>180 дугаар зүйл. Дуудлага худалдаа зохион байгуулах эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанаас үүсэх хариуцлага</p> <p>180.1. Дуудлага худалдаа зохион байгуулахаар томилогдсон бүрэн эрх бүхий этгээд уг үүргээ зохих ёсоор биелүүлж чадаагүйгээс бусдад гэм хор учруулсан бол хохирлыг энэ хуулийн 497 дугаар зүйлд заасны дагуу хариуцна.</p> <p>197 дугаар зүйл. Үнэ хаялцуулах ажиллагаа</p> <p>197.1. Үнэ хаялцуулах замаар гэрээ байгуулж болно.</p>
--	--

24	<p>Иргэний хууль</p> <p>197.2. Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээг үнэ хаялцаж ялсан этгээдтэй байгуулна.</p> <p>197.3. Үнэ хаялцуулах ажиллагааг зохион байгуулагч нь өмчлөгч буюу эрх эзэмшигч, эсхүл эрх олгогдсон этгээд байж болно.</p> <p>197.4. Эрх олгогдсон байгууллага өмчлөгч буюу эрх эзэмшигчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр тэдгээрийн нэрийн өмнөөс, эсхүл өөрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.</p> <p>197.5. Эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрхийг худалдах гэрээг гагцхүү хуульд заасан бол үнэ хаялцуулах замаар байгуулна.</p> <p>197.6. Үнэ хаялцуулах ажиллагааг дуудлага худалдаа буюу уралдааны хэлбэрээр явуулна.</p> <p>197.7. Дуудлага худалдаагаар үнэ хаялцан ялагч нь хамгийн өндөр үнэ санал болгосон этгээд байна.</p> <p>197.8. Уралдаанд ялагч нь уралдааныг зохион байгуулах комиссоос урьдчилан тодорхойлсноор хамгийн сайн нөхцөлийг хангасан этгээд байх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол үнэ хаялцуулах ажиллагааны хэлбэрийг уг эд хөрөнгийн өмчлөгч буюу эд хөрөнгийн эрх эзэмшигч тогтооно.</p> <p>197.9. Нэг этгээд оролцсон бол дуудлага худалдаа, уралдаан явагдаагүй гэж үзнэ.</p> <p>197.10. Дуудлага худалдаа буюу уралдааныг нээлттэй буюу хаалттай явуулж болно.</p> <p>197.11. Нээлттэй дуудлага худалдаа, уралдаанд ямар ч этгээд оролцож болно.</p> <p>197.12. Хаалттай дуудлага худалдаа, уралдаанд энэ зорилгоор тусгайлан уригдсан этгээд оролцоно.</p> <p>197.13. Хуульд өөрөөр заагаагүй бол зохион байгуулагч нь зарыг үнэ хаялцуулах ажиллагаа явуулахаас гучаас доошгүй хоногийн өмнө гаргах бөгөөд түүнд ажиллагаа явуулах хэлбэр, газар, хугацаа, гэрээний зүйл, анхны үнэ, оролцогчдыг бүртгэх, ялсан этгээдийг тогтоох журам болон бусад мэдээллийг тусгана. Гэрээний зүйл нь гэрээ байгуулах эрх бол гэрээ байгуулах хугацааг заана.</p> <p>197.14. Хууль буюу зард өөрөөр заагаагүй бол нээлттэй дуудлага худалдаа, уралдаан зохион байгуулагч тэдгээрийг явуулахаас татгалзах эрхтэй. Гэхдээ дуудлага худалдаа явуулахаар товлон зарласан өдрөөс гурваас доошгүй хоногийн, уралдаан явуулахаар зарласан өдрөөс гучаас доошгүй хоногийн өмнө ийнхүү татгалзаж болно.</p> <p>197.15. Энэ хуулийн 197.14-т заасан хугацааг зөрчиж дуудлага худалдаа хийх буюу уралдаан явуулахаас татгалзсан зохион байгуулагч оролцогчдод учирсан шууд хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.</p> <p>197.16. Хаалттай дуудлага худалдаа, уралдаан зохион байгуулагч нь түүнд уригдсан оролцогчдод учирсан хохирлыг ямар хугацаанд дуудлага худалдаа, уралдаан явуулахаас татгалзсанаас үл хамааран нөхөн төлөх үүрэгтэй.</p> <p>197.17. Үнэ хаялцуулах ажиллагаанд оролцогч зард заасан хэмжээ, журмаар, заасан хугацаанд дэнчин тавина.</p> <p>197.18. Үнэ хаялцуулах ажиллагааг явуулаагүй, түүнд оролцоогүй, эсхүл оролцсон боловч ялаагүй этгээдэд дэнчинг буцаан олгоно.</p> <p>197.19. Ялсан этгээдтэй гэрээ байгуулахдаа дэнчинг гэрээний үүргийн гүйцэтгэлд оруулан тооцно.</p> <p>197.20. Үнэ хаялцуулах ажиллагаанд ялсан этгээд болон ажиллагаа зохион байгуулагч дуудлага худалдаа, уралдааны үр дүнгийн тухай тэмдэглэлд явуулсан өдөрт нь гарын үсэг зурах бөгөөд энэ тэмдэглэл гэрээний адил хүчинтэй байна.</p> <p>197.21. Ялсан этгээд тэмдэглэлд гарын үсэг зурахаас зайлсхийвэл тавьсан дэнчингээ алдана.</p> <p>197.22. Зохион байгуулагч тэмдэглэлд гарын үсэг зурахаас зайлсхийвэл нөгөө талын тавьсан дэнчинг буцааж өгөхийн зэрэгцээ ажиллагаанд оролцсоноос учирсан хохирлыг дэнчингээс давсан хэмжээгээр нөхөн төлөх үүрэгтэй.</p> <p>197.23. Үнэ хаялцуулах ажиллагааг гэрээ байгуулах эрх олж авах нөхцөлтэйгөөр явуулсан бол уг ажиллагааг явуулж дуусаад тэмдэглэл үйлдсэнээс хойш хорь хоногийн дотор, эсхүл зард дурдсан хугацаанд талууд гэрээнд гарын үсэг зурна. Талуудын нэг нь гэрээ байгуулахаас зайлсхийвэл нөгөө тал нь гэрээг байгуулсанд тооцож, үүргийн гүйцэтгэлийг хангуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.</p> <p>197.24. Хуулиар тогтоосон журам зөрчиж явуулсан үнэ хаялцуулах ажиллагаа хүчин төгөлдөр бус байна.</p> <p>197.25. Хүчин төгөлдөр бус үнэ хаялцуулах ажиллагаанд ялсан этгээдтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байна.</p> <p>197.26. Энэ зүйлд заасан журам шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар явуулах дуудлага худалдаанд нэгэн адил хамаарна.</p> <p>198 дугаар зүйл. Гэрээг тайлбарлах</p> <p>198.1. Гэрээг тайлбарлахдаа түүний үгийн шууд утгыг анхаарна.</p> <p>198.2. Гэрээний аль нэг нөхцөлийн утга нь ойлгомжгүй бол түүний агуулгыг бусад нөхцөл болон гэрээний ерөнхий агуулгатай харьцуулах замаар тодорхойлно.</p>
----	--

<p>24</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Иргэний хууль</p>	<p>198.3.Гэрээний зарим үг хэллэгийг нутгийн онцлогоос шалтгаалан өөр өөр агуулгаар тайлбарлаж болохоор байвал гэрээ байгуулсан талуудын оршин суугаа газарт хэрэглэж заншсан агуулгаар, талууд нь өөр өөр газар оршин суудаг бол гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн талын оршин суугаа газарт хэрэглэж заншсан агуулгаар тайлбарлана.</p> <p>198.4.Хоорондоо зөрчилтэй буюу олон утга санааг агуулсан үг хэллэг байвал гэрээний агуулгад илүү тохирсон утга санаагаар тайлбарлана.</p> <p>198.5.Холимог гэрээний агуулгыг тайлбарлахдаа гэрээний гүйцэтгэлд илүү төсөөтэй тухайн төрлийн гэрээг зохицуулсан хуулийн хэм хэмжээг анхаарна.</p> <p>198.6.Энэ хуулийн 198.1-198.5-д заасан журмаар гэрээний агуулгыг тодорхойлох боломжгүй бол гэрээний зорилгыг харгалзан талуудын нэгдмэл санааг тодруулах бөгөөд үүний тулд гэрээ байгуулахаас өмнө хийсэн хэлэлцээ, харилцан илгээсэн баримт бичиг, талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзнэ.</p> <p>243 дугаар зүйл. Худалдах-худалдан авах гэрээ</p> <p>243.1.Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ.</p> <p>243.2.Худалдагч нь худалдаж байгаа эд хөрөнгийн зориулалт, хэрэглээний шинж чанар, хадгалах, хэрэглэх, тээвэрлэх нөхцөл, журам, баталгаат болон эдэлгээний хугацаа, үйлдвэрлэгчтэй холбогдсон үнэн зөв, бүрэн мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй.</p> <p>244 дүгээр зүйл. Худалдах-худалдан авах гэрээний үнэ</p> <p>244.1.Худалдах-худалдан авах гэрээнд үнийг шууд заагаагүй бол талууд үнэ тодорхойлох арга хэрэгслийн тухай хэлэлцэн тохиролцож болно.</p> <p>245 дугаар зүйл. Хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон зардлыг хуваарилах</p> <p>245.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон /жигнэх, савлах, баглах гэх мэт/ зардлыг худалдагч, барааг худалдагчийн байгаа газраас өөр газар хүргэх, зөөх, тээвэрлэх, хүлээн авахтай холбогдсон зардлыг худалдан авагч хариуцна.245.2.Гэрээнд өөрөөр заагаагүй бол үл хөдлөх эд хөрөнгө худалдах-худалдан авахад гэрээ болон шаардагдах баримт бичиг бүрдүүлэх, баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх, улсын бүртгэлийн газар бүртгүүлэхтэй холбогдсон зардлыг худалдан авагч хариуцна.</p> <p>246 дугаар зүйл. Эд хөрөнгө илгээх талаар худалдагчийн хүлээх үүрэг</p> <p>246.1.Гэрээ ёсоор худалдагч эд хөрөнгийг тээвэрлэгчид шилжүүлсэн бөгөөд тухайн эд хөрөнгөд ямар нэгэн таних тэмдэг буюу бусад хэрэгслээр тэмдэглэл хийгээгүй бол түүнийг илгээсэн тухай худалдан авагчид мэдэгдэж, ачааны дэлгэрэнгүй жагсаалтыг илгээх үүрэгтэй.</p> <p>246.2.Хэрэв худалдагч эд хөрөнгийг илгээх үүрэг хүлээсэн бол эд хөрөнгийг тохирсон газар хүргэхэд шаардагдах гэрээ тухайн төрлийн тээвэрлэлтийн ердийн нөхцөлөөр хийх үүрэгтэй.</p> <p>246.3.Тээвэрлэлтийн явцад эд хөрөнгийг даатгуулах үүрэг худалдагч хүлээгээгүй бол худалдан авагчийн хүсэлтээр даатгалын гэрээ байгуулахад шаардагдах, өөрт байгаа бүхий л мэдээллийг түүнд өгөх үүрэг хүлээнэ.</p> <p>247 дугаар зүйл. Үр шим болон эрсдэл худалдан авагчид шилжих</p> <p>247.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол худалдсан эд хөрөнгийг худалдан авагчид шилжүүлснээр тухайн эд хөрөнгийг ашигласны үр дүнд олсон үр шим болон уг эд хөрөнгө тохиолдлоор устаж, гэмтсэний эрсдэл худалдан авагчид шилжинэ.</p> <p>247.2.Худалдагч худалдсан эд хөрөнгийг худалдан авагчийн хүсэлтээр гэрээнд зааснаас өөр газар хүргүүлэхээр илгээсэн бол тухайн эд хөрөнгийг тээвэрлэгчид, эсхүл эрх бүхий этгээдэд шилжүүлсэн үеэс худалдан авагчид үр шим, эрсдэл нь шилжинэ.</p> <p>248 дугаар зүйл. Эд хөрөнгийг хүлээн авсанд тооцох</p> <p>248.1.Хуульд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгө хүлээн авах нөхцөлийг гэрээгээр тодорхойлно.</p> <p>248.2.Худалдан авагч эд хөрөнгийг хүлээн авсныг гэрчлэх тодорхой үйлдэл хийсэн бол түүнийг эд хөрөнгө хүлээн авсанд тооцно.</p> <p>249 дүгээр зүйл. Гэрээний талууд үүргээсээ татгалзах</p> <p>249.1.Гэрээ байгуулснаас хойш гэрээний аль нэг тал хүлээсэн үүргийнхээ дийлэнх хэсгийг биелүүлж чадахгүй бодит нөхцөл бий болсон бол нөгөө тал хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзаж болно.</p> <p>249.2.Хэрэв нэг талын хүлээсэн үүргийн гүйцэтгэл нь хуульд заасан үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар урьдчилан хангагдсан бол нөгөө тал үүргээсээ татгалзаж болохгүй.</p> <p>249.3.Худалдсан эд хөрөнгийг хэсэг хэсгээр нийлүүлэх тохиолдолд нэг тал нь эд хөрөнгийг нийлүүлэх нэг удаагийн үүргээ биелүүлээгүйгээс дараагийн нийлүүлэлт биелэгдэхгүй байх бодит нөхцөл бий болсон</p>
--	--

24	<p>бол нөгөө тал нь энэ хуулийн 204.2, 219.2-т заасан хугацаа өнгөрсний дараа гэрээний үүргээсээ татгалзаж болно.</p> <p>250 дугаар зүйл. Худалдсан эд хөрөнгийг эзэмшилдээ авах давуу эрх</p> <p>250.1.Худалдагч нэг эд хөрөнгийг хэд хэдэн этгээдэд худалдсан бол уг эд хөрөнгийг хамгийн түрүүнд эзэмшилдээ авсан худалдан авагч, хэрэв эд хөрөнгө хэний ч эзэмшилд шилжээгүй байвал түрүүлж гэрээ хийсэн этгээд эзэмшилдээ шилжүүлэн авах давуу эрхтэй.</p> <p>251 дүгээр зүйл. Худалдсан эд хөрөнгийн биет байдлын доголдол</p> <p>251.1.Гэрээгээр тогтоосон тоо, хэмжээ, чанар бүхий эд хөрөнгийг биет байдлын хувьд доголдолгүй гэж үзнэ.</p> <p>251.2.Хэрэв гэрээнд эд хөрөнгийн чанарын талаар заагаагүй бол гэрээнд заасан зориулалтаар ашиглах боломжтой эд хөрөнгийг биет байдлын доголдолгүй гэж үзнэ.</p> <p>251.3.Үүргийн гүйцэтгэлд ноцтой нөлөө үзүүлэхээргүй бол эд хөрөнгийн зарим хэсгийг дутуу буюу гэрээнд зааснаас өөр барааг бага хэмжээгээр шилжүүлсэн, эсхүл эд хөрөнгийн нэг хэсэг нь доголдолтой байсан ч түүнийг бүхэлд нь доголдолтой гэж үзэхгүй.</p> <p>252 дугаар зүйл. Худалдсан эд хөрөнгийн эрхийн доголдол</p> <p>252.1.Худалдсан эд хөрөнгийн хувьд гуравдагч этгээд өөрийн эдлэх эрхийн талаар худалдагчид гомдлын шаардлага гаргахааргүй бол эрхийн доголдолгүй эд хөрөнгө гэнэ.</p> <p>252.2.Хүчин төгөлдөр бус эрхийг хөрөнгийн бүртгэлд бүртгүүлсэн бол түүнийг эрхийн доголдолтой гэнэ.</p> <p>253 дугаар зүйл. Эд хөрөнгийн доголдлын талаархи худалдагчийн эрх, үүрэг</p> <p>253.1.Худалдсан эд хөрөнгө нь доголдолтой бол худалдагч уг доголдлыг арилгах, хэрэв эд хөрөнгө нь төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгө байвал тухайн төрлийн ижил эд хөрөнгөөр буюу тухайн цаг үед худалдан авагчид шаардлагатай өөр эд хөрөнгөөр сольж өгөх үүрэгтэй.</p> <p>253.2.Энэ хуулийн 253.1-д зааснаар доголдлыг арилгахтай холбогдсон /ачих, тэвэрлэх, гүйцэтгэсэн ажлын хөлс, зарцуулсан материалын үнэ гэх мэт/ зардлыг худалдагч хариуцна.</p> <p>253.3.Худалдагч нь доголдолтой эд хөрөнгийн оронд өөр доголдолгүй эд хөрөнгийг худалдан авагчид шилжүүлсэн бол өмнө нь шилжүүлсэн доголдолтой эд хөрөнгөө худалдан авагчаас буцаан авахаар шаардах эрхтэй.</p> <p>254 дүгээр зүйл. Эд хөрөнгийн доголдлын талаархи худалдан авагчийн эрх, үүрэг</p> <p>254.1.Худалдан авагч нь эд хөрөнгийн доголдлыг арилгуулах буюу доголдолгүй тухайн төрлийн эд хөрөнгөөр солиулах, доголдлыг арилгахад гаргасан зардлаа төлүүлэх, эсхүл гэрээг цуцлах тухай шаардлага гаргах эрхтэй.</p> <p>254.2.Худалдан авагч нь баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаанд энэ хуулийн 254.1-д заасан шаардлагыг гаргаагүй бол тэрээр доголдлыг арилгахад шаардлагатай мөнгөний хэмжээгээр анхны үнийг бууруулахаар шаардаж болно. Энэ тохиолдолд үнэлгээг гэрээ байгуулах үеийн үнээр тодорхойлно.</p> <p>254.3.Энэ хуулийн 251.3-т зааснаас бусад тохиолдолд худалдагч нь гэрээнд заасан тоо, хэмжээнээс дутуу эд хөрөнгө илгээсэн бол худалдан авагч уг эд хөрөнгийг хүлээн авахаас татгалзах эрхтэй.</p> <p>254.4.Худалдан авагч энэ хуулийн 254.3-т заасан эд хөрөнгийг хүлээн авсан бол худалдагч нь гэрээний үнэд хувь тэнцүүлэн дутуу эд хөрөнгийн үнийг буцааж төлнө.</p> <p>254.5.Худалдагчийн шилжүүлсэн эд хөрөнгө нь гэрээнд заасан тоо хэмжээнээс их байвал худалдан авагч уг эд хөрөнгийг хүлээн авч, үнийг нь гэрээний үнэд хувь тэнцүүлэн төлөх буюу гэрээнд заасан хэмжээнээс илүү хэсгийг худалдагчийн зардлаар буцаана.</p> <p>254.6.Худалдагч эд хөрөнгийн баталгаат хугацаа тогтоосон бол энэ хугацааны дотор, баталгаат хугацаа тогтоогоогүй бол тухайн эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэн авснаас хойш зургаан сарын дотор доголдлыг илрүүлсэн худалдан авагч энэ хуулийн 254.1-д заасан шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй.</p> <p>254.7.Эд хөрөнгийн баталгаат хугацааг худалдан авагчид эрсдэл шилжсэн үеэс эхлэн тоолох бөгөөд хэрэв баталгаат хугацааны дотор гол доголдлыг илрүүлсэн бол худалдан авагчид эрсдэл шилжих үед уг доголдол байсан гэж үзнэ.</p> <p>255 дугаар зүйл. Худалдан авагч шаардлага гаргах эрхээ алдах</p> <p>255.1. Дараахь тохиолдолд худалдан авагч шаардлага гаргах эрхээ алдана:</p> <p>255.1.1.эд хөрөнгө хүлээж авах үедээ уг эд хөрөнгийн доголдлын талаар мэдсэн буюу мэдэх боломжтой байхад түүнийг хүлээн авсан;</p> <p>255.1.2.аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь уг үйл ажиллагаатай холбоотой эд хөрөнгийг шилжүүлэн авах үедээ нэн даруй шалган авах үүргээ биелүүлээгүй;</p> <p>255.1.3.тухайн эд хөрөнгийн доголдол нь худалдан авагч түүнийг тэвэрлэх, хадгалах, ашиглах журам зөрчсөнөөс, эсхүл гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас үүссэн.</p>
----	---

24	Иргэний хууль	<p>255.2.Худалдагч эд хөрөнгийг шилжүүлэх үед түүний доголдлыг мэдсээр байж нуун дарагдуулсан бол энэ хуулийн 255.1 хамаарахгүй.</p> <p>256 дугаар зүйл. Эд хөрөнгийн доголдолтой холбогдуулан гэрээг цуцлах</p> <p>256.1.Эд хөрөнгийн доголдолтой холбогдуулан худалдагч, худалдан авагчийн аль нь ч гэрээг цуцлах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд худалдагч нь худалдан авагчид учирсан хохирол, зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.</p> <p>256.2.Хэд хэдэн эд хөрөнгийг худалдсан тохиолдолд тэдгээрийн зарим хэсэг нь доголдолтой бол гэрээг зөвхөн доголдолтой хэсгээр, хэрэв доголдолтой хэсэг нь бусад хэсэгтэйгээ нэгдмэл зориулалттай ашиглагдах бол гэрээг бүхэлд нь цуцалж болно.</p> <p>256.3.Гол эд хөрөнгө доголдолтой бол бүхэлд нь, дагалдах эд хөрөнгө нь доголдолтой бол гагцхүү тэр хэсгээр нь гэрээг цуцалж болно.</p> <p>257 дугаар зүйл. Хариуцлагыг хязгаарласан хэлцэл хүчин төгөлдөр бус байх</p> <p>257.1.Ямар нэгэн доголдолтой эд хөрөнгийг худалдсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй байх, эсхүл хүлээх хариуцлагыг хязгаарлахаар талууд тохиролцон гэрээнд зааж болох боловч худалдагч нь эд хөрөнгийн доголдлыг зоринд нуун дарагдуулсан бол уул тохиролцоо хүчин төгөлдөр бус байна.</p> <p>258 дугаар зүйл. Худалдсан эд хөрөнгийг хадгалах үүрэг</p> <p>258.1.Худалдан авагч худалдан авсан эд хөрөнгөө хугацаанд нь хүлээж аваагүй бол худалдагч уг эд хөрөнгийг хадгалах үүрэгтэй.</p> <p>258.2.Худалдан авагч эд хөрөнгийн үнийг төлөх, зохих зардлыг нөхөн төлөх хүртэл худалдагч эд хөрөнгийг өөртөө үлдээж саатуулах эрхтэй.</p> <p>258.3.Худалдан авагч эд хөрөнгийг хүлээн авсан боловч эрхийнхээ дагуу буцааж өгөх хүсэлтэй бол түүнийг хадгалж, бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй бөгөөд худалдагч зохих зардлыг төлөх хүртэл худалдан авагч уг эд хөрөнгийг өөртөө үлдээх эрхтэй.</p> <p>258.4.Харьцангуй өндөр зардал гаргахааргүй бол эд хөрөнгийг хадгалах үүрэг бүхий тал нь нөгөө талынхаа зардлаар гуравлагч этгээдийн агуулахад эд хөрөнгийг хадгалж болно.</p> <p>259 дүгээр зүйл. Хадгалж байгаа эд хөрөнгийг худалдах</p> <p>259.1.Гэрээний нэг тал эд хөрөнгийг хүлээж авахгүй удаасан буюу хадгалахтай холбогдсон зардлыг төлөхгүй бол эд хөрөнгийг хадгалж байгаа тал нь зохих журмын дагуу түүнийг худалдах эрхтэй. Эд хөрөнгийг худалдах тухай нөгөө талдаа долоо хоногийн дотор мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>259.2.Энэ хуулийн 259.1-д зааснаар эд хөрөнгийг худалдсан үнээс түүнийг хадгалах, худалдахтай холбогдсон зардлыг суутган тооцож үлдсэн мөнгийг нөгөө талдаа шилжүүлнэ.</p> <p>259.3.Энэ хуулийн 258 дугаар зүйлд заасан тохиолдолд хадгалах эд хөрөнгө нь түргэн муудах буюу үнэ нь буурах, эсхүл түүнийг хадгалахад харьцангуй өндөр зардал шаардагдахаар бол хадгалах үүрэг бүхий тал нь энэ зүйлд заасан журмын дагуу түүнийг худалдах үүрэгтэй.</p> <p>260 дугаар зүйл. Эрх, шаардлага, бусад хөрөнгө худалдах-худалдан авах</p> <p>260.1.Үүргийн агуулгад харшлахгүй бол эрх, шаардлага, бусад хөрөнгө худалдах-худалдан авахад эд хөрөнгө худалдах-худалдан авах гэрээний талаархи энэ хуулийн заалтууд нэгэн адил хамаарна.</p> <p>260.2.Эрх худалдахад худалдагч нь уг эрх хүчин төгөлдөр болох тухай үндэслэл гаргах, эрх шилжүүлэхтэй холбогдсон зардлыг хариуцна.</p> <p>260.3.Эд хөрөнгө эзэмших боломж олгож байгаа эрхийг худалдсан тохиолдолд худалдагч тухайн эд хөрөнгийг худалдан авагчид биет байдлын болон эрхийн доголдолгүй шилжүүлэх үүрэгтэй.</p> <p>261 дүгээр зүйл. Гэрээний талууд үүргээ зөрчсөнөөс учирсан гэм хорыг арилгах</p> <p>261.1.Худалдах-худалдан авах гэрээний нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс нөгөө талдаа учруулсан хохирлыг гэм хор арилгах нийтлэг журмыг баримтлан арилгана.</p> <p>262 дугаар зүйл. Зээлээр худалдах-худалдан авах гэрээ</p> <p>262.1.Зээлээр худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь худалдан авагч үнийг төлөхөөс өмнө эд хөрөнгийг шилжүүлэх, худалдан авагч нь үнийг гэрээнд заасны дагуу тодорхой цаг хугацааны дараа хэсэгчлэн буюу бүрэн, эсхүл тодорхой цаг хугацааны туршид хэсэгчлэн төлөх үүргийг тус тус хүлээнэ.</p> <p>263 дугаар зүйл. Зээлээр худалдах-худалдан авах гэрээний хэлбэр</p> <p>263.1.Хуульд өөрөөр заагаагүй бол зээлээр худалдах-худалдан авах гэрээг бичгээр хийнэ.</p> <p>263.2.Гэрээнд дараахь нөхцөлийг заавал тусгана:</p> <p>263.2.1.бэлэн мөнгөөр төлөх төлбөрийн хэмжээ;</p> <p>263.2.2.хэсэгчлэн хийх төлбөрийн хэмжээ, хугацаа;</p> <p>263.2.3. төлбөл зохих хүүгийн хэмжээ;</p> <p>263.2.4.үнэ, эсхүл үнийг тодорхойлох журам.</p>
----	---------------	---

24	<p>Иргэний хууль</p> <p>263.3.Худалдагч гэрээ болон дагалдах баримт бичгийн хувийг худалдан авагчид шилжүүлэх үүрэгтэй.</p> <p>263.4.Энэ зүйлд заасан журмыг зөрчиж гэрээ байгуулсан бол энэ хуулийн 196.1.1-д зааснаар гэрээг байгуулсан гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд худалдан авагч хүү төлөхгүй, гагцхүү эд хөрөнгийн үнийг төлнө. Төлбөрийг гэрээнд заасан хугацааны дотор гүйцэтгэнэ.</p> <p>264 дүгээр зүйл. Худалдагч гэрээнээс татгалзах</p> <p>264.1.Зээлээр худалдах-худалдан авах гэрээгээр хүлээсэн үүргээ худалдан авагч биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол худалдагч гэрээнээс татгалзах эрхтэй. Талууд гэрээгээр авсан бүх зүйлээ харилцан буцааж өгөх үүрэгтэй.</p> <p>264.2.Энэ хуулийн 264.1-д заасан тохиолдолд худалдагч нь учирсан хохирол, зардлаа худалдан авагчаас шаардах эрхтэй.</p> <p>265 дугаар зүйл. Эд хөрөнгө буцаан худалдан авах худалдагчийн эрх</p> <p>265.1.Худалдах-худалдан авах гэрээнд заасан бол худалдагч нь худалдсан эд хөрөнгөө худалдан авагчаас буцаан худалдан авах эрхтэй бөгөөд худалдагчийн энэ эрх нь түүний хүсэл зоригоос хамааран хэрэгжинэ.</p> <p>266 дугаар зүйл. Гэрээний үнэ</p> <p>266.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн эд хөрөнгийг анх худалдсан үнээр буцаан худалдаж авна.</p> <p>266.2.Эд хөрөнгийг засан сайжруулсны үр дүнд өртөг нь нэмэгдсэн бол түүнийг буцаан худалдаж байгаа тал нь нэмэгдүүлсэн өртгийн хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр нийт зардлаа шаардах эрхтэй.</p> <p>267 дугаар зүйл. Эд хөрөнгийг буцаан худалдаж байгаа талын хүлээх үүрэг</p> <p>267.1.Эд хөрөнгийг буцаан худалдаж байгаа тал нь түүнийг дагалдах зүйлийн хамт худалдан авагчид шилжүүлэх үүрэгтэй.</p> <p>267.2.Энэ хуулийн 265 дугаар зүйлд заасан эрхээ худалдагч хэрэгжүүлэхээс өмнө эд хөрөнгийг буцаан худалдагч нь түүнийг гэмтээсэн, үрэгдүүлсэн, өөр эд хөрөнгөөр орлуулсан тохиолдолд түүнээс болж учирсан гэм хорыг өөрөө хариуцан арилгах үүрэгтэй.</p> <p>267.3.Энэ хуулийн 265 дугаар зүйлд заасан эрхээ худалдагч хэрэгжүүлэхээс өмнө эд хөрөнгийг буцаан худалдаж байгаа тал нь түүнийг гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлж болохгүй. Энэ журмыг зөрчиж хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.</p> <p>268 дугаар зүйл. Буцаан худалдан авах эрх хэрэгжүүлэх хугацаа</p> <p>268.1.Эд хөрөнгийг буцаан худалдан авах эрх хэрэгжүүлэх хугацааг талууд тохиролцон тогтоох боловч энэ хугацаа нь таван жилээс хэтрэхгүй.</p> <p>269 дүгээр зүйл. Ирээдүйд эд хөрөнгө худалдах-худалдан авах гэрээ</p> <p>269.1.Тодорхой цаг хугацаа, эсхүл тодорхой үйл явдал болохоос өмнө ямар нэгэн зүйлийг худалдах, эсхүл худалдан авахаар гэрээний талууд тохиролцох буюу худалдан авагч талын санаачилгаар тодорхой эд хөрөнгийг олж авах эрхтэй байхаар гэрээ байгуулж болно.</p> <p>269.2.Энэ хуулийн 269.1-д заасан гэрээнд худалдах-худалдан авах гэрээний талаархи энэ хуулийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна.</p> <p>270 дугаар зүйл. Худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэх</p> <p>270.1.Худалдагч нь тухайн эд хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдах тохиолдолд уг эд хөрөнгийг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>270.2.Худалдагч тухайн эд хөрөнгийг худалдан авах давуу эрх бүхий этгээдэд эрхээ хэрэгжүүлэх хугацаа тогтоох бөгөөд энэ хугацаанд давуу эрх бүхий этгээд эрхээ хэрэгжүүлээгүй бол худалдагч гуравдагч этгээдтэй худалдах-худалдан авах гэрээ байгуулж болно.</p> <p>270.3.Худалдагч энэ хуулийн 270.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол худалдан авах давуу эрх бүхий этгээд нь худалдагчаас гуравдагч этгээдэд санал болгосон нөхцөлөөр худалдах-худалдан авах гэрээ байгуулахаар шаардах эрхтэй.</p> <p>271 дүгээр зүйл. Худалдагчийн гуравдагч этгээдтэй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байх</p> <p>271.1.Худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэхгүй буюу уг эрхийг хэрэгжүүлэх нөхцөлд давуу эрх бүхий этгээдтэй хийсэн гэрээнээс татгалзахаар гуравдагч этгээдтэй хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.</p> <p>272 дугаар зүйл. Гуравдагч этгээдийн хүлээх нэмэгдэл үүрэг</p> <p>272.1.Гуравдагч этгээд нь худалдагчтай байгуулсан гэрээ ёсоор нэмэгдэл ямар нэгэн үйлчилгээ үзүүлэх буюу үүрэг хүлээсэн бол худалдан авах давуу эрх бүхий этгээд уг үйлчилгээ буюу нэмэгдэл үүргийн үнийг төлнө.</p> <p>272.2.Хэрэв нэмэгдэл үйлчилгээ буюу үүрэг нь мөнгөөр илэрхийлэгдэх боломжгүй бол худалдан авах давуу эрх хэрэгжихгүй.</p> <p>272.3.Худалдан авах давуу эрхийг эдлүүлэхгүй байх зорилгоор гуравдагч этгээд нэмэгдэл үүрэг хүлээхээр худалдагчтай хийсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна.</p>
----	--

24	Иргэний хууль	<p>273 дугаар зүйл. Худалдан авах давуу эрх үл шилжих</p> <p>273.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол худалдан авах давуу эрхийг бусдад шилжүүлж болохгүй.</p> <p>274 дүгээр зүйл. Арилжааны гэрээ</p> <p>274.1.Арилжааны гэрээгээр талууд тодорхой хөрөнгийг харилцан өмчлөлд шилжүүлэх үүрэг хүлээнэ.</p> <p>274.2.Арилжааны гэрээгээр талууд нь арилжиж байгаа хөрөнгийн хувьд худалдагч, арилжин авч байгаа хөрөнгийн хувьд худалдан авагч болно.</p> <p>274.3.Арилжааны гэрээнд худалдах-худалдан авах гэрээний талаархи энэ хуулийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна.</p> <p>274.4.Төрийн өмчлөлийн мөнгө, үнэт цаасаар арилжаа хийх журмыг хуулиар тогтооно.</p> <p>275 дугаар зүйл. Арилжих хөрөнгийн үнийн зөрүүг тооцох</p> <p>275.1.Арилжааны гэрээгээр харилцан солилцож байгаа хөрөнгийн үнэ нь тэнцүү биш бол үнийн зөрүүг мөнгөөр тооцож болно.</p> <p>380 дугаар зүйл. Тээвэрлэлтийн гэрээ</p> <p>380.1.Тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч нь зорчигч буюу ачаа, тээшийг тогтоосон газар хүргэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.</p> <p>380.2.Зорчигч буюу ачаа, тээшийг тээвэрлэх нөхцөл, тээвэрлэлтийн талаар талуудын хүлээх хариуцлага нь хууль, хуульд нийцсэн тодорхой төрлийн тээврийн дүрмээр тодорхойлогдоно.</p> <p>381 дүгээр зүйл. Гэрээ байгуулах</p> <p>381.1.Зорчигч буюу ачаа, тээш тээвэрлэхийг нийтэд санал болгож байгаа этгээд нь зайлшгүй тагталзах үндэслэл байхгүй бол тээвэрлэлтийн гэрээг заавал байгуулах үүрэгтэй.</p> <p>382 дугаар зүйл. Зорчигч тээвэрлэлт</p> <p>382.1.Зорчигч тээвэрлэлтийн гэрээг зорчих пайз, тасалбарыг зорчигчид гардуулснаар байгуулагдсан гэж үзнэ.</p> <p>382.2.Зорчих пайз, тасалбарыг бусдад дамжуулахаар буюу үл дамжуулахаар үйлдэж болох бөгөөд бусдад дамжуулах боломж тээвэрлэлт эхлэхэд дуусна.</p> <p>383 дугаар зүйл. Гэрээг цуцлах</p> <p>383.1.Гэрээнд ямар нэгэн байдлаар саатал учруулахааргүй бол зорчигч нь тээвэрлэлтийн гэрээг хэдийд ч цуцалж болох бөгөөд гэрээг цуцалснаас үүссэн хохирлыг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй.</p> <p>383.2.Урьдчилан мэдэх боломжгүй байсан бөгөөд мэдсэн тохиолдолд гэрээг хийхгүй байх шалтгаан болохоор нөхцөл байдал тээвэрлэгчийн зүгээс илэрсэн, түүнчлэн гэрээнд заасан газарт хүрч очих болон замд явах хугацаа хожимдох магадлал байгаа тохиолдолд зорчигч гэрээ байгуулахаас тагталзаж болно. Энэ тохиолдолд хохирлыг нөхөн төлөх үүрэг үүсэхгүй.</p> <p>384 дүгээр зүйл. Тээвэрлэгчийн хүлээх хариуцлага</p> <p>384.1.Тээвэрлэлтийн явцад зорчигчид өөрт нь буюу түүний эд хөрөнгөд гэм хор учирсан, авч яваа зүйл нь алдагдсан, гэмтсэн бол тээвэрлэгч хууль болон тодорхой төрлийн тээврийн дүрэмд заасан хариуцлага хүлээнэ.</p> <p>384.2.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас, эсхүл зорчигчийн буруугаас буюу түүний авч явсан зүйлээс шалтгаалж гэм хор учирсан бол тээвэрлэгч хариуцлага хүлээхгүй.</p> <p>384.3.Тухайн төрлийн тээврийн хэрэгслийн жолооч болон бусад ажилтнуудын үйл ажиллагааны дутагдал, тээврийн хэрэгслийн бүрэн бус ажиллагаа, эвдрэл, эд материалын доголдол, дутагдал зэргээс зорчигчид хохирол учирсан нь тээвэрлэгчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.</p> <p>384.4.Тээвэрлэгчийн шууд санаатай буюу хэт болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалаагүй болон гэрээнд өөрөөр заагаагүй бол тээвэрлэгч нь хугацаа хожимдсоноос учирсан хохирлыг хариуцахгүй.</p> <p>384.5.Тээвэрлэгчийн хариуцлагыг гэрээгээр хязгаарлах буюу чөлөөлж болохгүй.</p> <p>385 дугаар зүйл. Зорчигчийн хүлээх хариуцлага</p> <p>385.1.Зорчигч нь өөрийн буруутай үйл ажиллагаа, түүнчлэн авч яваа ачаа, тээш болон бусад эд хөрөнгөөс шалтгаалж тээвэрлэгчид учирсан хохирлыг хариуцна.</p> <p>385.2.Зорчигч нь ачаа тээвэрлэлтийн явцад баримтлах хадгалалт, тээвэрлэлтийн бүхий л нөхцөл, журмыг чанд баримталсан бол хохирлыг хариуцахгүй.</p> <p>413 дугаар зүйл. Худалдааны зуучлагч</p> <p>413.1.Аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд худалдах-худалдан авах, даатгал, тээвэр, эд хөрөнгө хөлслөх, эсхүл худалдааны бусад үйл ажиллагаанд зуучлал явуулж байгаа этгээд худалдааны зуучлагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.</p>
----	---------------	---

24	Иргэний хууль	<p>413.2.Энэ хуулийн 413.1-д зааснаас бусад хэлцэл болон үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой хэлцлийг худалдааны зуучлагчийн тусламжтайгаар хэрэгжүүлсэн тохиолдолд худалдааны зуучлагч гэж үзэхгүй.</p> <p>413.3.Гэрээний талууд хориглоогүй буюу тухайн үүргээс чөлөөлөөгүй бол хэлцэл байгуулагдсаны дараа зуучлагч нь гэрээний талуудад хэлцлийн зүйл, нөхцөл, оролцогч тал, бараа, үнэт цаас худалдах худалдан авах гэрээ байсан бол тэдгээрийн төрөл, тоо, хэмжээ, гэрээний үнэ, хугацаа зэргийг тусгасан баримтыг гарын үсэг зурж олгоно.</p> <p>413.4.Нэн даруй биелэгдэхээс бусад хэлцэлд энэ хуулийн 413.3-г заасан баримт бичигт талууд гарын үсэг зурна.</p> <p>413.5.Хэрэв хэлцлийн нэг тал баримтад гарын үсэг зурах буюу эсхүл түүнийг хүлээн авахаас татгалзвал худалдааны зуучлагч нөгөө талд энэ тухай нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>413.6.Нөгөө талыг заагаагүй худалдааны зуучлагчийн баримтыг талуудын аль нэг нь хүлээн авсан бөгөөд хожим мэдэгдсэн талын эсрэг үндэслэл бүхий гомдол гаргаагүй бол түүнтэй хэлцэл хийсэн гэж үзнэ.</p> <p>413.7.Гэрээний нэг талыг зуучлагч ердийн боломжит буюу үүргийн шинж чанарт тохирсон хугацаанд нөгөө талд мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>413.8.Гэрээний нэг тал нь нэрлэгдээгүй, эсхүл нэрлэгдсэн этгээдийн эсрэг үндэслэл бүхий гомдол гаргасан бол нөгөө тал нь гэрээ байгуулахтай холбогдсон үр дагаврыг шаардах эрхтэй.</p> <p>413.9.Дээж авах замаар барааг худалдаж байвал худалдааны зуучлагч нь барааны дээжид тусгай тэмдэг тавих, дээжийг гэрээний талуудад олгох зорилгоор худалдан авагч барааны чанарт гомдол гаргалгүйгээр хүлээж авах хүртэл хадгалах үүрэгтэй.</p> <p>413.10.Талууд хоорондын зуучлалын үр дүнд байгуулагдсан гэрээнээс худалдааны зуучлагч аливаа ашиг олох, эсхүл мөнгөн төлбөр авах эрхгүй.</p> <p>413.11.Худалдааны зуучлагч өөрийн буруугаас үүссэн хохирлыг талуудын өмнө хариуцна.</p> <p>413.12.Худалдааны зуучлагчид олгох зуучлалын хөлс, шагналыг хэн төлөх талаар тохиролцоогүй бол гэрээний талууд тогтоосон хөлс, шагналыг тэнцүү хэмжээгээр төлөх үүрэгтэй.</p> <p>414 дүгээр зүйл. Худалдааны зуучлагчийн хөтөлж тэмдэглэл</p> <p>414.1.Худалдааны зуучлагч өдөр бүр дэс дараатай тэмдэглэл хөтөлж, түүнд байгуулсан бүх хэлцлээ бүртгэж, тухай бүр гарын үсэг зурна.</p> <p>414.2.Худалдааны зуучлагч гэрээний талуудын шаардсан үед тэмдэглэлээс зуучлалын тусламжтайгаар байгуулсан хэлцлийн тухай мэдээллийг агуулсан өөрийн гарын үсэгтэй баримтыг олгох үүрэгтэй.</p> <p>415 дугаар зүйл. Худалдааны төлөөлөгч, комисс</p> <p>415.1.Үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс, түүний зардлаар гэрээ байгуулах буюу бараа, эрх, үйлчилгээг борлуулахад зуучилж байгаа этгээдийг худалдааны төлөөлөгч гэнэ.</p> <p>415.2.Өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ бусдын зардлаар барааг борлуулж, эрх хэрэгжүүлэх этгээдийг комисс гэнэ.</p> <p>415.3.Худалдааны төлөөлөгч буюу комисс нь үйлчлүүлэгчийн заавраар түүний эрх ашиг, ердийн шаардлагад нийцүүлэн үүргээ гүйцэтгэж, үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангана. Гэрээнд өөрөөр заагаагүй бол улирал бүрийн сүүлчийн арав хоногт өөрийн үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээний хөлс, шагналын тооцоо, комиссийн төлбөрийн дүн зэргийг агуулсан тайланг үйлчлүүлэгчид гаргаж өгнө.</p> <p>415.4.Сар бүрийн эцэст үйлчлүүлэгч хөлс, шагналыг, комисс нь олсон ашгаа үйлчлүүлэгчид тус тус төлнө.</p> <p>415.5.Үйлчлүүлэгч гэрээнд заасан нөхцөлийг биелүүлээгүй, эсхүл зуучлалын үндсэн дээр зохих хэлцэл байгуулаагүй бол худалдааны төлөөлөгч, комисс нь хөлс, шагнал шаардах эрхтэй.</p> <p>415.6.Хэрэв хэлцлийг үйлчлүүлэгчийн бус нөгөө талын буруугаас байгуулаагүй бол хөлс, шагнал шаардах эрх үүсэхгүй.</p> <p>415.7.Хэлцэл хийгч нөгөө тал үүргээ гүйцэтгэж чадахгүй болох нь тогтоогдвол худалдааны төлөөлөгч, комисс нь хөлс, шагнал шаардах эрхээ алдаж, өмнө авсан хөлс, шагналыг үйлчлүүлэгчид буцаан өгнө.</p> <p>415.8.Комисс нь барааг үйлчлүүлэгчийн тогтоосон үнээс өөр үнээр худалдах тохиолдолд түүнд энэ тухай нэн даруй мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд үйлчлүүлэгч хариу өгөөгүй бол түүнийг зөвшөөрсөнд тооцно.</p> <p>415.9.Барааг илүү ашигтайгаар худалдсан тохиолдолд олсон ашиг нь үйлчлүүлэгчид үлдэнэ.</p> <p>416 дугаар зүйл. Хөлс, шагнал, шимтгэлийн хэмжээ</p> <p>416.1.Хөлс, шагнал, шимтгэлийн хэмжээг харилцан тохиролцоогүй бол тогтсон нийтлэг жишиг, хэмжээгээр тохиролцсон гэж үзнэ.</p> <p>416.2.Хөлс, шагналыг төлбөр төлөх талын төлбөрийн дүнгээс тооцох бөгөөд ингэхдээ төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэсний хөнгөлөлт, төлбөр тооцоо, савлалт, гаалийн хураамж, татвар төлөх зэрэгтэй холбогдон үүссэн нэмэлт зардлыг хасаж бодно.</p> <p>416.3.Нэмэлт зардлыг гуравдагч этгээд төлсөн тохиолдолд энэ хуулийн 416.2 хамаарахгүй.</p>
----	---------------	---

<p>24</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Иргэний хууль</p>	<p>416.4. Даатгалын гэрээнд даатгалын үнийн дүнгээс хөлс, шагналыг тооцох бөгөөд ийм үнийн дүн байхгүй бол даатгалын хураамжаас тооцно.</p> <p>417 дугаар зүйл. Худалдааны төлөөлөгч, комисстой байгуулах гэрээний хугацаа</p> <p>417.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол худалдааны төлөөлөгчтэй байгуулах гэрээ нэг жилийн хугацаатай байна. Гэрээний хугацаа дуусгавар болохоос гурван сарын өмнө түүнийг цуцлах тухай санал гаргаагүй бол гэрээг нэг жилээр сунгасанд тооцно.</p> <p>418 дугаар зүйл. Худалдааны төлөөлөгчид олгох нөхөн олговор</p> <p>418.1. Худалдааны төлөөлөгч гэрээ дуусгавар болсны дараа үйлчлүүлэгчээс дараахь тохиолдолд нөхөн олговор олгохыг шаардах эрхтэй:</p> <p>418.1.1. Үйлчлүүлэгч худалдааны төлөөлөгчийн зуучлалаар шинэ үйлчлүүлэгчтэй ажил хэргийн харилцаанд давуу эрх олж авсан;</p> <p>418.1.2. Шинээр хамрагдсан үйлчлүүлэгчтэй байгуулсан хэлцлийг сунгаснаар хөлс, шагнал авах эрхээ алдсан.</p> <p>418.2. Шинээр үйлчлүүлэгч хамруулсан гэдэгт үйлчлүүлэгч их хэмжээний ашиг олох боломжтой ажил хэргийн холбоо тогтоосныг ойлгоно.</p> <p>418.3. Нөхөн олговор нь худалдааны төлөөлөгчийн үйл ажиллагааны сүүлийн таван жилд авч байсан, эсхүл нэг жилд олох хөлс, шагналын дундаж хэмжээнээс илүүгүй байна. Нэг жилээс доош хугацаатай байгуулсан гэрээнд худалдааны төлөөлөгчийн үйл ажиллагааны хугацаанд олж болох хөлс, шагналын дундаж дүнгээс тооцно.</p> <p>418.4. Нөхөн олговор олгохыг шаардах эрхээс татгалзах, гэрээ дуусгавар болохоос өмнө түүнийг урьдчилан олгохыг хориглоно.</p> <p>418.5. Гомдол дараахь тохиолдолд хүчин төгөлдөр бус байна:</p> <p>418.5.1. Үйлдвэрийн үйл ажиллагаа нь гэрээг цуцлах үндэслэл болсноос бусад тохиолдолд худалдааны төлөөлөгч өөрийн санаачилгаар гэрээг цуцалсан, эсхүл өндөр нас, өвчний улмаас үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болсон;</p> <p>418.5.2. Худалдааны төлөөлөгчийн буруутай үйл ажиллагааны улмаас үйлчлүүлэгч гэрээг цуцалсан;</p> <p>418.5.3. Үйлчлүүлэгч, худалдааны төлөөлөгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу худалдааны төлөөлөгчийн оронд гэрээний харилцаанд гуравдагч этгээд оролцож байгаа.</p> <p>418.6. Энэ хуулийн 418.5.3-т заасан хэлцлийг гэрээ дуусгавар болохоос өмнө байгуулж үл болно.</p> <p>418.7. Нөхөн олговор авах эрхийг гэрээ дуусгавар болсон үеэс эхлэн нэг жилийн дотор хэрэгжүүлнэ.</p> <p>428 дугаар зүйл. Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээ</p> <p>428.1. Хуульд өөрөөр заагаагүй бол барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээний хадгалагч нь эд хөрөнгийг хүлээн авахад түүний чанар, төрөл, жин, хэмжээ, тоо болон бусад шинжийг шалгах үүрэг хүлээхгүй.</p> <p>428.2. Хадгалагчид шилжүүлж байгаа эд хөрөнгө шилжүүлэлтийн үеийн гадаад үзлэгээр гэмтсэн, эсхүл иж бүрдэл дутуу болох нь мэдэгдэж байвал хадгалагч хадгалуулагчид энэ тухай нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд уг үүргээ биелүүлээгүйгээс хадгалуулагчид учирсан хохирлыг нөхөн төлнө.</p> <p>428.3. Хадгалагч нь хадгалагдаж байгаа эд хөрөнгийг өөр агуулахад шилжүүлэх болон түүний шинж өөрчлөгдсөн, эсхүл өөрчлөгдөх аюул учирч байгаа талаар өөрийн мэдэж байгаа агуулахын баримтын сүүлчийн эзэмшигчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд уг үүргээ биелүүлээгүй бол хохирлыг хариуцна.</p> <p>428.4. Хадгалагч нэг төрлийн эд хөрөнгийг гагцхүү өмчлөгчийн зөвшөөрөлтэйгээр түүнтэй ижил төрлийн эд хөрөнгөтэй нийлүүлж хадгалж болно. Ийнхүү нийлүүлснээс бий болсон эд хөрөнгө нь хадгалуулагчдын дундын өмч болох бөгөөд хадгалуулагчид оногдох хэсгийг хадгалуулсан эд хөрөнгийн хэмжээгээр тодорхойлно.</p> <p>428.5. Хадгалуулагчид оногдох хэсгийг хадгалагч бусад хадгалуулагчийн зөвшөөрөлгүйгээр буцаан өгөх эрхтэй.</p> <p>428.6. Хадгалалтад шилжүүлсэн эд хөрөнгө нь өөрийн үнэ цэнийг алдахуйцаар гэмтэж өөрчлөгдсөнийг хадгалагч эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд ийнхүү мэдэгдэх цаг хугацаа хүрэлцэхгүй буюу мэдэгдэх боломжгүй бол түүнийг худалдах эрхтэй.</p> <p>428.7. Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээнд хадгалалтын гэрээний журам нэгэн адил үйлчилнэ.</p> <p>429 дүгээр зүйл. Агуулахын баримт</p> <p>429.1. Хадгалагч хадгалуулахаар шилжүүлж өгсөн эд хөрөнгийг хүлээн авахдаа хадгалуулагчид агуулахын баримт олгоно.</p> <p>429.2. Агуулахын баримтад дараахь зүйлийг заавал тусгана:</p>
--	---

24	<p>Иргэний хууль</p> <p>429.2.1. агуулахын баримт олгосон огноо, бүртгэлийн дугаар;</p> <p>429.2.2. гэрээний талуудын нэр, хаяг;</p> <p>429.2.3. эд хөрөнгийг хадгалах газар;</p> <p>429.2.4. хадгалах эд хөрөнгийн тоо, хэмжээ, жин, өнгө, чанар, боодлын тодорхойлолт;</p> <p>429.2.5. хадгалалтын хөлс, бусад зайлшгүй зардлын хэмжээ;</p> <p>429.2.6. хадгалах эд хөрөнгийг даатгуулах бол даатгалын үнэ;</p> <p>429.2.7. гэрээний хугацаа;</p> <p>429.2.8. хадгалагчийн гарын үсэг, тамга, тэмдэг.</p> <p>429.3. Талууд энэ хуулийн 429.2-г зааснаас бусад нөхцөлийг агуулахын баримтад нэмж тусгаж болно.</p> <p>429.4. Энэ хуулийн 429.2-г заасан нөхцөлийг агуулахын баримтад бүрэн тусгаагүй нь талуудыг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.</p> <p>429.5. Агуулахын баримт эзэмшигч нь өөр үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор эд хөрөнгийг агуулахаас гаргахгүй гэсэн баталгаа гаргаж, агуулахад байгаа эд хөрөнгөө барьцаалж болно.</p> <p>429.6. Хадгалагч зөвшөөрсөн бол хадгалуулагч агуулахын баримтыг бичилт хийж гуравдагч этгээдэд шилжүүлж болно.</p> <p>429.7. Агуулахын баримтыг бичилтийн дагуу шилжүүлсэн бол хадгалагч нь түүнд дурдсан мэдээллийн үнэн зөвийг баримт эзэмшигчийн өмнө хариуцах бөгөөд харин уг мэдээллийг хадгалуулагч, эсхүл гуравдагч этгээдийн өгсөн мэдээллийг үндэслэсэн гэж уг баримтад тэмдэглэсэн бол хадгалагч хариуцлага хүлээхгүй.</p> <p>429.8. Хадгалагч мэдээлэл буруу ташаа гэдгийг мэдэж байсан бол баримтад тэмдэглэл хийсэн ч энэ хуулийн 429.7-д заасан хариуцлагыг хүлээнэ.</p> <p>429.9. Эд хөрөнгийг нийлүүлж хадгалсан тохиолдолд хадгалагч энэ хуулийн 429.7-д заасан тэмдэглэлийг хийх эрхгүй.</p> <p>429.10. Агуулахын зөвшөөрлийн баримт олгосон хадгалагч хадгалж байгаа эд хөрөнгийг гагцхүү агуулахын баримтын хууль ёсны эзэмшигчид олгоно.</p> <p>429.11. Агуулахын барьцааны баримт олгосон бол хадгалагч түүнийг буцаан авахаар шаардах эрхтэй.</p> <p>429.12. Хадгалагч бичилт хийн шилжүүлсэн баримтын үнэн эсэхийг шалгах үүрэггүй бөгөөд шилжүүлэлт нь агуулахын баримт дахь зохих тэмдэглэлээр баталгаажна.</p> <p>429.13. Агуулахын баримт, эсхүл барьцааны баримтыг гэсэн, үрэгдүүлсэн тохиолдолд хууль ёсны эзэмшигч нь үрэгдүүлсэн баримт бичгийг хүчингүйд тооцуулахаар шүүхэд өргөдөл гаргаж болох бөгөөд хадгалагч шүүхийн шийдвэрийг үндэслэн агуулахын болон барьцааны баримтуудыг шинээр олгоно.</p> <p>429.14. Агуулахад хадгалуулахаар шилжүүлсэн эд хөрөнгийг барьцаалахад өмчлөгч нь барьцааны баримтад тусгай тэмдэглэл хийж түүнийг шилжүүлнэ.</p> <p>429.15. Бичилт хийн шилжүүлсэн баримтад хадгалуулагч, зээлдүүлэгч болон тэдгээрийн үүргийн талаархи мэдээллийг тусгана.</p> <p>429.16. Эд хөрөнгө хадгалуулсан баримтыг шилжүүлсэн тухай хадгалагчид мэдэгдэх бөгөөд хадгалагч зохих бичилтийг хийнэ.</p> <p>429.17. Эд хөрөнгийн хадгалалттай холбогдон үүссэн зардлыг төлүүлэхээр хадгалагч тухайн эд хөрөнгийг барьцаалах эрхтэй.</p> <p>429.18. Агуулахын баримтыг бичилт хийн шилжүүлсэн бол шинэ эзэмшигчид барьцаалах эрх үүснэ.</p> <p>430 дугаар зүйл. Хадгалалтын хугацаа дуусгавар болох</p> <p>430.1. Хадгалалтын гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө, хугацаа тогтоогоогүй бол эд хөрөнгө хадгалуулахаар шилжүүлсэн өдрөөс эхлэн гурван сарын дотор хадгалагч эд хөрөнгөө буцаан авахыг хадгалуулагчаас шаардах эрхгүй.</p> <p>430.2. Хадгалалтын хугацаа дуусгавар болсны дараа агуулахын баримт эзэмшигч нь эд хөрөнгийг агуулахаас гаргах арга хэмжээ авахгүй бол хадгалагч түүнд арван дөрөв хоногийн нэмэлт хугацаа олгох бөгөөд энэ хугацаанд эд хөрөнгийг буцаан авахгүй бол хадгалагч түүнийг худалдах эрхтэй.</p> <p>430.3. Эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хадгалалтын явцад гарсан зайлшгүй зардал, хөлсийг хасаж, үлдсэн хэсгийг агуулахын баримт эзэмшигчид шилжүүлнэ</p>
----	---

25	Компанийн тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь компани үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувь нийлүүлэгчдийн эрх, үүргийг тогтоох болон компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>8 дугаар зүйл. Компанийн үйл ажиллагааны чиглэл, байгуулаххугацаа</p> <p>8.1. Компани нь хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд компани эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх, үүргийг хүлээнэ.</p> <p>8.2. Компанийн эрхлэх үйл ажиллагааны хүрээг дүрмээр хязгаарлаж болно. Ингэж хязгаарласан нь энэ хязгаарлалтыг мэдэхгүйгээр хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа гуравдагч этгээдийн өмнө уг компанийн хүлээсэн үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.</p> <p>8.3. Хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа эрхлэх компани нь холбогдох эрх бүхий байгууллагаас бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр энэ үйл ажиллагааг эрхлэн явуулна.</p> <p>8.4. Компанийн дүрмд өөрөөр заагаагүй бол компанийг тодорхой бус хугацаагаар үүсгэн байгуулна.</p>
26	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>8 дугаар зүйл. Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг</p> <p>8.1. Мал, махны үйлвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:</p> <p>8.1.1. мал, мах бэлтгэх ажлыг бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;</p> <p>8.1.2. мал, мах бэлтгэх, худалдах-худалдан авах гэрээ болон түүний хавсралт, эрүүл ахуй, ариун цэврийн сертификатыг 6 сар хүртэл хугацаагаар хадгалж байх;</p> <p>8.1.3. амьдын жингээр авч нядалж, бэлтгэж байгаа малын толгой, арьс, ширийг анхан шатны боловсруулалт хийж, нядалгаа хийснээс хойш 3 хоног хадгалж, эрх бүхий албан тушаалтанд саадгүй үзүүлж байх;</p> <p>8.1.4. мал, мах бэлтгэх ажлыг энэ хуулийн 5.1.5-д заасан цэгт хийх.</p> <p>8.2. Тээврийн хэрэгслийн жолооч нь мах бэлтгэлийн зориулалттай мал, махыг тээвэрлэхдээ гарал үүслийн гэрчилгээтэй эсэхийг нь шалгасны үндсэн дээр тээвэрлэнэ.</p> <p>9 дүгээр зүйл. Малыг бусдын өмчлөлд шилжүүлэх тавигдах шаардлага</p> <p>9.1. Малыг зөвхөн Иргэний хуульд заасан холбогдох гэрээний үндсэн дээр бусдын өмчлөлд шилжүүлнэ.</p> <p>9.2. Энэ хуулийн 9.1-д заасан гэрээнд бусдын өмчлөлд шилжүүлж байгаа малын нэг бүрчилсэн бүртгэлийг хавсаргасан байна.</p> <p>9.3. Энэ хуулийн 9.2-т заасан бүртгэлд малын төрөл, нас, хүйс, им тамганы талаар тодорхой заасан байна.</p> <p>10 дугаар зүйл. Мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ</p> <p>10.1. Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төв суурин газарт борлуулах, худалдах зорилгоор оруулж байгаа мал, маханд мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ олгоно.</p> <p>10.2. Мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээний загвар, олгох журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p>

27	Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь мал, тэжээвэр амьтны /цаашид “мал” гэх/ удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>10 дугаар зүйл. Хяналтын албаны эрх, үүрэг</p> <p>10.1.5. малын эм, бэлдмэл, өвчин үүсгэгч болон бүтээгдэхүүний омог, эмийн түүхий эд, үр, хөврөл үрийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, худалдах, хэрэглэх явцад хяналт тавих, дүгнэлт гаргах;</p> <p>10.1.11. малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний чанарт хяналт тавих;</p> <p>10.1.12. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ болон малын үр, хөврөл үр, эм, бэлдмэл, мал эмнэлгийн зориулалттай багаж хэрэгсэл, өвчин үүсгэгчийг ургуулж үржүүлэх үйлдвэрлэл эрхлэх, малын тэжээл үйлдвэрлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, малын гаралтай түүхий эдээр үйлдвэрлэл явуулах талаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтийг хянан үзэж дүгнэлт гаргах;</p> <p>10.1.13. мал эмнэлэг, үржлийн нэгжийн ажил, үйлчилгээ болон малын үр, хөврөл үр, эм, бэлдмэл, мал эмнэлгийн зориулалттай багаж хэрэгсэл, өвчин үүсгэгчийг ургуулж үржүүлэх үйлдвэрлэл эрхлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөл, малын эмчийн мэргэжлийн итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах үндэслэл, дүгнэлтээ тусгай зөвшөөрөл, итгэмжлэл олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>13 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн эрх</p> <p>13.1.3. гойд ашиг шимт мал болон цөм сүргээс үржлийн мал бойжуулах, үр, хөврөл үр үйлдвэрлэх, худалдан борлуулах;</p> <p>14 дүгээр зүйл. Иргэн, хуулийн этгээдийн үүрэг</p> <p>14.1. Иргэн, хуулийн этгээд дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:</p> <p>14.1.1. малыг нядлах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, боловсруулах ажлыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байр, агуулах, орчинд хийж гүйцэтгэх;</p> <p>14.1.2. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг аймаг, нийслэл, сумын нутаг дэвсгэрээс нөгөөд шилжүүлэх, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, тээвэрлэх, хүлээн авах, улсын хилээр нэвтрүүлэхэд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэж гэрчилгээ авах;</p>
28	МУ-ын Үндсэн хууль	<p>Арван зургадугаар зүйл. Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:</p> <p>3. Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө</p> <p>4. ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.</p>
29	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, төсвөөс буцаан олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>4.1.1. “борлуулалт” гэж барааг бусдын өмчлөлд төлбөртэйгээр шилжүүлэх, ажил, үйлчилгээг төлбөртэйгээр гүйцэтгэхийг;</p> <p>4.1.2. “бараа” гэж мөнгөн хөрөнгөнөөс бусад бүх төрлийн эд хөрөнгийг;</p> <p>4.1.4. “аж ахуйн үйл ажиллагаа” гэж ашиг олох зорилготой болон тийм зорилгогүй, бүхэлд нь буюу хэсэгчлэн бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;</p> <p>5 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч</p> <p>5.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа импортлосон болон экспортлосон этгээд, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байна.</p> <p>5.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын хэмжээ нь 10 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн гадаадын хуулийн этгээдийн төлөөний газарт энэ зүйлийн 5.1 дэх заалт нэгэн адил үйлчилнэ.</p> <p>6 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах</p> <p>6.1. Энэ хуулийн 4.1.10-г заасан нөхцөл хангасан этгээд ажлын 3 хоногт багтаан нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх өргөдлөө харьяалах татварын албанд гаргана.</p>

<p>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай</p>	<p>6.2.Харъяалах татварын алба нь энэ хуулийн 7.1.3 болон 13 дугаар зүйлд зааснаас бусад энэ хуулийн 4.1.10-т заасан этгээдийн өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдөрт багтаан нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэж, тухайн этгээдэд гэрчилгээ олгоно.</p> <p>6.3.Энэ хуулийн 6.2-т заасан гэрчилгээний загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.</p> <p>6.4.Дараахь нөхцлийг хангасан тохиолдолд иргэн, хуулийн этгээд сайн дураараа нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж болно:</p> <p>6.4.2.үндсэн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого энэ хуулийн 6.4.1-д заасан хэмжээнд хүрсэн эсэхээс үл хамааран Монгол Улсад 2.0 сая ам. доллар ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн.</p> <p>6.5.Энэ хуулийн 6.4-т заасан орлого болон хөрөнгө оруулалт нь сүүлийн нэг жилд тухайн иргэн, хуулийн этгээдийн орлого, татвар тодорхойлох хуудас болон орлогын албан татварын тайлангаар нотлогдсон байхаас гадна уг этгээд нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухайхууль, олон улсын стандартын дагуу хөтөлж хэвшсэн байвал зохино.</p> <p>7 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээ</p> <p>7.1.Хуульд өөрөөр заагаагүй бол дор дурдсан бараа, ажил, үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулна:</p> <p>7.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа;</p> <p>7.1.2.худалдах, хэрэглэх буюу ашиглах зориулалтаар Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаад улсад экспортолсон бүх төрлийн бараа;</p> <p>7.1.3. худалдах, хэрэглэх буюу ашиглах зориулалтаар гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт импортолсон бүх төрлийн бараа;</p> <p>7.1.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ.</p> <p>7.2. Монгол Улсад байрладаггүй гадаадын хуулийн этгээд, түүнчлэн оршин суугч бус хувь хүний Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнийн дүн 10.0 сая төгрөг ба түүнээс дээш байвал энэ хуулийн 7.1.4 дэх заалт нэгэн адил хамаарна.</p> <p>7.3. Дор дурдсан үйл ажиллагааг “бараа борлуулсан” -д хамааруулна:</p> <p>7.3.1.аж ахуйн болон тодорхой бизнес эрхлэх эрхийг борлуулах;</p> <p>7.3.2.татвар төлөгч нь худалдаа, үйлдвэрлэл, ажил, үйлчилгээгээ зогсоож, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн бүртгэлээс хасагдах үед бизнесийн хөрөнгөөс өөртөө бараа үлдээх;</p> <p>7.3.3. бараанд энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу албан татварын хасалт хийх;</p> <p>7.3.4. өрийн төлбөрийг бараа шилжүүлэх замаар хаах;</p> <p>7.3.5. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугч бус этгээд Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн захиалгаар бараа борлуулах.</p> <p>7.4. Дор дурдсан үйл ажиллагааг “үйлчилгээ үзүүлсэн”-д хамааруулна:</p> <p>7.4.1.цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, шуудан, харилцаа холбооны болон бусад үйлчилгээ үзүүлэх;</p> <p>7.4.2.бараа түрээслүүлэх буюу бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах;</p> <p>7.4.3.зочид буудал буюу түүнтэй адилтгах байранд байр түрээслүүлэх буюу бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах;</p> <p>7.4.4.байшин, барилгад байр түрээслүүлэх буюу бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах;</p> <p>7.4.5.байшин, барилгаас бусад үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө түрээслүүлэх буюу бусад хэлбэрээр эзэмшүүлэх, ашиглуулах;</p> <p>7.4.6.шинэ бүтээл, бүтээгдхүүний загвар, ашигтай загвар, зохиогчийн эрхэд хамаарах бүтээл, барааны тэмдэг, ноу-хау, хөрөнгийн мэдээллийг шилжүүлэх, түрээслүүлэх, худалдах;</p> <p>7.4.7.эд мөнгөний хонжворт сугалаа гаргах, төлбөрт таавар, бооцоот тоглоом тоглуулах, зуучлагчийн үйлчилгээ үзүүлэх;</p> <p>7.4.8.өрийн төлбөрийг ажил, үйлчилгээ үзүүлэх замаар хаах;</p> <p>7.4.9.Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугч бус этгээдээс Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн захиалгаар ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх;</p> <p>7.4.11.ажил, үйлчилгээнд энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу татварын хасалт хийх.</p> <p>7.5.Энэ хуулийн 7.1-д заасан бараа, ажил, үйлчилгээнд татвар ногдуулахад дор дурдсан нөхцөлийг хангасан байна:</p>
---	---

29	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай	<p>7.5.1. тухайн этгээд нь энэ хуулийн 5, 6 дугаар зүйлд заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч байх;</p> <p>7.5.2. борлуулалтыг аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд хийсэн байх.</p> <p>7.6. Энэ хуулийн 7.5.1 дэх заалтад мөн хуулийн 7.3.5, 7.4.9 дэх заалт хамаарахгүй.</p> <p>8 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах</p> <p>8.1. Нэмэгдсэн өртгийн албан татварыг дор дурдсан журмаар ногдуулна:</p> <p>8.1.1. бараа, ажил, үйлчилгээг импортолсон буюу экспортолсон, түүнчлэн борлуулсан бол тухай бүрт;</p> <p>8.1.2. барилга угсралтын ажил гүйцэтгэсэн бол эцсийн борлуулалтад;</p> <p>8.1.3. санхүүгийн түрээсийн зүйлийг худалдан авсан буюу импортолсон бол түрээсийн төлбөр хийхээр тохирсон хуваарийг баримтлан тухай бүрт .</p> <p>8.2. Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан орлогод албан татвар ногдуулах, мөн хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу уг албан татвараас чөлөөлөхдөө “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ыг баримтална.</p> <p>8.3. Энэ хуулийн 8.2-т заасан “Ангилал”-ыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>9 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээ</p> <p>9.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг дор дурдсан журмаар тодорхойлно:</p> <p>9.1.1. импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасны дагуу тодорхойлсон гаалийн үнэ дээр гаалийн албан татвар, онцгой болон бусад албан татварыг нэмж;</p> <p>9.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн болон борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг тэдгээрийн тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн;</p> <p>9.1.3. Энэ хуулийн 7.3.1, 7.3.2 -т заасан үйл ажиллагаанд нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг тэдгээр бараа, ажил, үйлчилгээний тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн;</p> <p>9.1.4. эд мөнгөний хонжворт сугалаа, төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйлчилгээ эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг оролцогчдын төлсөн нийт мөнгөн дүнгээс хожлын төлбөрт төлсөн мөнгөний хэмжээг хасч;</p> <p>9.1.5. өрийн төлбөрийг бараа шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх замаар барагдуулсан бол үнийнх нь дүнгээр.</p> <p>9.2. Дараахь тохиолдолд нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг харьяалах татварын алба тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн тодорхойлно:</p> <p>9.2.1. борлуулсан бараа , гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнэ тариф тодорхойгүй;</p> <p>9.2.2. бараа ,ажил, үйлчилгээг харилцан солилцсон;</p> <p>9.2.3. харилцан хамаарал бүхий этгээдүүд үнэгүй, эсхүл зах зээлийнхээс хямд буюу өндөр үнэ, тарифаар хоорондоо бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>9.3. Нэмэгдсэн өртгийн албан татвар тооцох үнэлгээг гадаад валютаар хийсэн бол түүнийг энэ хуулийн 10.2-т зааснаар тогтоосон өдрийн Монголбанкны ханшийг үндэслэн төгрөгт шилжүүлнэ.</p> <p>11 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулах хувь</p> <p>11.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нэмэгдсэн өртгийн албан татварыг импортолсон болон үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний албан татвар тооцох үнэлгээний 10 хувиар ногдуулна.</p> <p>11.2. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан бараа, ажил, үйлчилгээнд ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татварын хувь тэг /“0”/-гэй тэнцүү байна.</p> <p>11.3. Нэмэгдсэн өртгийн албан татварыг импортлосон болон үйлдвэрлэсэн борлуулсан автобензин, дизелийн түлшний албан татвар тооцох үнэлгээний 0-10 хувиар ногдуулна.</p> <p>11.4. Импортлосон болон үйлдвэрлэсэн, борлуулсан автобензин, дизелийн түлшний нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээг энэ хуулийн 11.3-т заасан хязгаарт багтаан салбарын онцлогийг харгалзан Засгийн газар тогтооно.</p> <p>12 дугаар зүйл. Албан татварын тэг /“0”/ хувь, хэмжээг хэрэглэх</p> <p>12.1. Экспортод гаргасан дараахь бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тэг хувь /“0”/-тай тэнцүү байна:</p> <p>12.1.1. худалдах зориулалтаар Монгол Улсын нутаг дэвсгэрээс экспортод гаргасан бөгөөд гаалийн байгууллагад мэдүүлсэн бараа;</p>
----	--	---

<p>29</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай</p>	<p>12.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаад улсад, гадаад улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрт, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсын нутгаар дамжуулан бусад улсад гаргасан зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ;</p> <p>12.1.3.Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна үзүүлсэн /албан татвараас чөлөөлсөн үйлчилгээг оролцуулан/ үйлчилгээ;</p> <p>12.1.4.үйлчилгээ үзүүлэх үед Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаагүй гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээ /түүний дотор албан татвараас чөлөөлсөн үйлчилгээг оролцуулан/;</p> <p>12.1.5.олон улсын нислэг үйлдэж буй дотоодын болон гадаадын агаарын тээврийн хөлөгт үзүүлэх нислэгийн хөдөлгөөний удирдлага, техникийн болон шатахууны үйлчилгээ, цэвэрлэгээ, нислэгийн явцад нисэх бүрэлдэхүүнд болон зорчигчдод худалдаа, хоол, ундаагаар үйлчилсэн үйлчилгээ;</p> <p>12.1.6.Засгийн газар, Монголбанкны захиалгаар дотоодод үйлдвэрлэсэн төрийн одон медаль, мөнгөн тэмдэгт, зоос.</p> <p>12.1.7.экспортод гаргасан уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн.</p> <p>12.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа хөдлөх, үл хөдлөх хөрөнгөтэй шууд холбоотойгоор үзүүлсэн үйлчилгээнд мөн хуулийн 12.1.4. дэх заалт хамаарахгүй.</p> <p>12.3.Энэ хуулийн 12.1 дэх заалт нь гадаадын иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр экспортын үйл ажиллагаа эрхэлж байгаа, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдэд хамаарна.</p> <p>12.4.Энэ хуулийн 12.1.4-т заасан иргэн, хуулийн этгээдийг дор дурдсан тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаагүй гэж үзнэ:</p> <p>12.4.2. тухайн улсад төлөөний газаргүй бөгөөд уг этгээд нь Монгол Улсаас өөр улсад байнга оршин суудаг буюу байрладаг;</p> <p>12.4.3. тухайн улс болон Монгол Улсын аль алинд нь төлөөний газартай боловч уг үйлчилгээ нь гадаад улс дахь төлөөний газрын хэрэгцээнд бүхэлдээ буюу ихэвчлэн зориулагдсан.</p> <p>12.5.Энэ хуулийн 12.1.7-д заасан экспортод гаргасан уул уурхайн эцсийн бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал, кодыг Засгийн газар тогтооно.</p> <p>13 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.</p> <p>13.1.Дараахь барааг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө:</p> <p>13.1.1.гаалийн байгууллагаас баталсан, зорчигчдод татваргүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хэмжээ бүхий зорчигчдын биедээ авч яваа хувийн хэрэглээний бараа;</p> <p>13.1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэсний байгууллага түүний төрөлжсөн салбарын хэрэгцээнд зориулан импортолсон бараа;</p> <p>13.1.3.Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагчдын хувийн хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээг тухайн улсад албан татвараас чөлөөлдөг бол тэр улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагчдын хувийн хэрэгцээнд зориулж Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ;</p> <p>13.1.4.гадаад улсын Засгийн газар, төрийн бус байгууллага, олон улсын болон буяны байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламжаар авсан бараа;</p> <p>13.1.5. хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэглээнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэл;</p> <p>13.1.7.иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг, түүний сэлбэг;</p> <p>13.1.8.орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байр буюу түүний хэсгийг борлуулсны орлого;</p> <p>13.1.9.газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах талаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тостой холбоотой үйл ажиллагаанд зориулан импортолсон техник, тоног төхөөрөмж, материал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, автобензин, дизелийн түлш;</p> <p>13.1.10.эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэн;</p> <p>13.1.11.хийн түлш, түүний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, механизм, техник, хэрэгсэл, тоноглол;</p> <p>13.1.12.гадаад улсад захиалгаар хийлгэсэн Монгол Улсын мөнгөн тэмдэгт;</p> <p>13.1.13.борлуулсан алт;</p> <p>13.1.14.борлуулсан сонин;</p> <p>13.1.15. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршилтын бүтээгдэхүүн.</p>
---	--

29	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай	<p>13.1.16.энэ хуулийн 12.1.7-д зааснаас бусад уул уурхайн бүтээгдэхүүн.</p> <p>13.2.Энэ хуулийн 13.1.11, 13.1.21, 13.1.22-г хамаарах барааны жагсаалтыг Засгийн газар батална.</p> <p>13.3.Арван мянган төгрөгөөс доош үнэтэй бараа, ажил, үйлчилгээг нэг удаа худалдан авахад энэ хуулийн 13.1.3 дахь заалт хамаарахгүй.</p> <p>13.4.Тусгай зориулалтын бус автомашин худалдан авахад энэ хуулийн 13.1.6 дахь заалт хамаарахгүй.</p> <p>13.5.Худалдах зориулалтаар шинээр барьсан орон сууцны зориулалттай байр, түүний хэсэгт энэ хуулийн 13.1.8 дахь заалт үйлчлэхгүй.</p> <p>13.6.13.Авто тээврийн тухайхуулийн 3.1.11-г заасан нийтийн тээврийн үйлчилгээ;</p> <p>13.6.14.аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд гадаад улсын аялал жуулчлалын байгууллагаатай гэрээ байгуулж жуулчдыг нь хүлээн авах, уг үйлчилгээг төлөвлөх, сурталчлах, бичиг баримтыг нь бүрдүүлэх зэргээр гадаадын жуулчдад үзүүлсэн /туроператор/ үйлчилгээ.</p> <p>13.7.Жилийн 10.0 сая ба түүнээс доош төгрөгийн борлуулалтын орлоготой үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэгчид /импортлогчоос бусад/-ийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.</p> <p>13.8.Эм, эм бэлдмэл, эмнэлгийн багаж, техник хэрэгсэл үйлдвэрлэх, худалдан борлуулахад энэ хуулийн 13.6.10 дахь заалт үйлчлэхгүй.</p> <p>13.9.Энэ хуулийн 13.6.14-г заасан үйлчилгээнд жуулчдад үйлчлэх бааз, ресторан, жуулчин тээвэрлэх, газарчлах болон зочид буудлын үйлчилгээ хамаарахгүй.</p> <p>13.10.Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, тэдгээрт ажиллагчдад энэ хуулийн 13.1.3-т заасан албан татварын чөлөөлөлтийг эдлүүлэхдээ, төлсөн албан татварыг нь буцаан олгох зарчмыг баримтална.</p> <p>13.11.Бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэлийн дотоод эргэлтэд ашигласнаас бусад хэлбэрээр бусдад үнэ төлбөргүй шилжүүлсэн буюу хувийнхаа хэрэгцээнд ашигласан бол нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхгүй.</p> <p>14 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварт хасалт хийх</p> <p>14.1.Иргэн, хуулийн этгээд нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэнээс хойшхи хугацаанд энэ хуулийн 7, 8, 11 дүгээр зүйлд заасны дагуу төлсөн дор дурдсан нэмэгдсэн өртгийн албан татварыг түүний төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татвараас хасч тооцно:</p> <p>14.1.1.үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд төлсөн;</p> <p>14.1.2. худалдах, түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар өөрөө шууд импортолсон бараа, ажил, үйлчилгээнд төлсөн;</p> <p>14.1.3. нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдэх үед бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвартай нь хамт худалдан авсан бол үнийн дүнгээс төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасч;</p> <p>14.1.4. мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, хуулийн этгээд өөрөө бэлтгэсэн буюу тариалсан бөгөөд үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй мах, өндөг, арьс шир, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон дотооддоо үйлдвэрлэсэн гурилыг дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнэд нь 10 хувийн нэмэгдсэн өртгийн албан татвар шингэсэн гэж үзэж, тэдгээрийг худалдан авсан этгээдийн төлөх нэмэгдсэн өртгийн албан татварыг уг хувиар хасч тус тус тооцно.</p> <p>14.2.Энэ хуулийн 14.1.4-г заасан анхдагч түүхий эдийг импортолсон буюу худалдан авч зуучлан борлуулсан бол төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татвараас хасалт хийхгүй.</p> <p>14.3.Худалдан авагч нь бэлтгэн нийлүүлэгчид нэмэгдсэн өртгийн албан татвар төлсөн нь нэхэмжлэл, падаан болон нягтлан бодох бүртгэлийн бусад баримтад тусгагдаагүй бол уг албан татварыг хасч тооцохгүй.</p> <p>14.4.Дараахь бараа, ажил, үйлчилгээг импортлох, худалдаж авахад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг худалдан авагчийн төлөх уг албан татварын нийт дүнгээс хасахгүй:</p> <p>14.4.1.суудлын автомашин, түүний эд анги, сэлбэг;</p> <p>14.4.2.хувийн болон ажиллагчдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, үйлчилгээ;</p> <p>14.4.3.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулж импортолсон болон худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээ.</p> <p>14.5.Суудлын авто машин, түүний эд анги, сэлбэгийг худалдан борлуулах үйл ажиллагааг эрхлэн явуулахаар өөрийнхөө гэрээ, дүрэмд тусган түүнийхээ дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдэд энэ хуулийн 14.4.1 дэх заалт үйлчлэхгүй.</p> <p>14.6.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу тухайн сард хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татварын дүнгээс их байвал татварын алба дараахь байдлаар зохицуулна:</p> <p>14.6.1.дараагийн сар, улирал, жилд төлөх нэмэгдсэн өртгийн албан татварт шилжүүлэн тооцох;</p>
----	--	--

<p>29</p>	<p>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай</p> <p>14.6.2.хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөвт төлөх бусад төрлийн албан татварын төлбөрт шилжүүлэн тооцох.</p> <p>14.7.Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар импортолсон болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний зарим хэсгийг нь нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох, үлдсэн хэсгийг нь уг татвараас чөлөөлөгдөх үйлдвэрлэл, үйлчилгээнд буюу албан татвар ногдуулахгүй хэрэглээнд ашигласан бол зөвхөн нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох үйлдвэрлэл, үйлчилгээнд ашигласан хэсгийг нь хасч тооцно.</p> <p>15 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох</p> <p>15.1.Илүү төлсөн, эсхүл хуульд заасан бол нэмэгдсэн өртгийн албан татварыг дор дурдсан журмаар албан татвар төлөгчид буцаан олгоно:</p> <p>15.1.2.энэ хуулийн 13.1.3-т заасан дипломаг төлөөлөгчийн болон консулын газар, тэдгээрийн ажилтан тухайн сард дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан авах хүсэлтээ холбогдох баримтын хамт дараа сарын 10-ны дотор татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэх;</p> <p>15.1.4.татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 15.1.2. 15.1.3-т зааснаар ирүүлсэн хүсэлт, саналыг хүлээн авснаасаа хойш ажлын 7 хоногт багтаан хянаж буцаан олгох татварын хэмжээг тодорхойлж, энэ тухайгаа албан татвар төлөгчид бичгээр мэдэгдэж, албан татвар төлөгчийн нэр, регистрийн дугаар, харилцагчийн банкны дансны дугаар, буцааж өгөх албан татварын хэмжээ, өрийн дүн зэргийг тодорхойлсон саналыг ажлын 2 хоногт багтаан санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;</p> <p>15.1.5.Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 15.1.4-т заасан саналыг хүлээн авснаасаа хойш ажлын 45 хоногт багтаан татварыг буцаан олгох.</p> <p>15.2.Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>15.3.Буцааж олгох нэмэгдсэн өртгийн албан татвар нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн сар, улирал, жилд улсын төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 15 хувиас хувиас хэтрэхээргүй байна.</p> <p>15.4.Энэ хуулийн 6.9-д заасан этгээд нь нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийлгэх буюу илүү төлсөн татварыг буцаан авах эрхтэй.</p> <p>15.5.Өөрийнхөө үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг экспортолсон бол албан татварыг сар бүр, бусад албан татвар төлөгчийн албан татварыг улиралд нэг удаа улсын төсвөөс буцаан олгоно.</p>
<p>30</p>	<p>Нөхөрлөлийн тухай хууль</p> <p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь нөхөрлөлийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, тэдгээрийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, бүртгэл, тайлан гаргах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Гадаад худалдааны эрх</p> <p>Нөхөрлөл эдийн засгийн гадаад харилцаанд бие даан оролцох эрхтэй.</p> <p>5 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл авах</p> <p>1. Тусгай зөвшөөрөл шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нөхөрлөл хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авна.</p> <p>2. Нөхөрлөл татан буугдах үед эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл хүчингүй болох бөгөөд бүртгэх байгууллага энэ тухай тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад мэдэгдэнэ.</p> <p>9 дүгээр зүйл. Нөхөрлөлийг бүртгэх</p> <p>1. Нөхөрлөлийг оршин байгаа газрынх нь нутаг дэвсгэрийн бүртгэх байгууллага, тэдгээрийн өргөдлийг үндэслэн улсын бүртгэлд бүртгэнэ.</p> <p>2. Гадаад улсад байгуулагдсан бөгөөд энэ хуульд заасан нөхөрлөлтэй адил төрлийн хуулийн этгээд, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар бол энэ хуульд заасан журмын дагуу бүртгүүлж, Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.</p> <p>3. Нөхөрлөлийг бүртгэгдсэн өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.</p>

31	Онцгой албан татварын тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь эх орны үйлдвэрийн болон импортоор авсан зарим бараа, түүнчлэн төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдэд онцгой албан татвар ногдуулах, түүнийг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Онцгой албан татвар төлөгч</p> <p>3.1. Энэ хуульд заасан онцгой албан татвар ногдох бараа импортолсон болон дотоодод үйлдвэрлэж борлуулсан, түүнчлэн төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхэлж байгаа хувь хүн, хуулийн этгээдэд онцгой албан татвар төлөгч байна.</p> <p>4 дүгээр зүйл. Онцгой албан татвар ногдох бараа, үйл ажиллагаа</p> <p>4.1. Дараахь бараанд онцгой албан татвар ногдуулна:</p> <p>4.1.1. бүх төрлийн согтууруулах ундаа;</p> <p>4.1.2. бүх төрлийн тамхи;</p> <p>4.1.3. автобензин, дизелийн түлш;</p> <p>4.1.4. суудлын автомашин.</p> <p>7 дугаар зүйл. Онцгой албан татвараас чөлөөлөх</p> <p>7.1. Дараахь барааг онцгой албан татвараас чөлөөлнө:</p> <p>7.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэн экспортод гаргасан энэ хуулийн 4.1-д заасан бараа;</p> <p>7.1.2. гэрийн нөхцөлд энгийн аргаар өөрийн хэрэгцээнд зориулж сүү, сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи;</p> <p>7.1.3. хамрын тамхи;</p> <p>7.1.4. гаалийн байгууллагаас зорчигчдын хувийн хэрэгцээнд зориулж татваргүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хэмжээний архи, тамхи;</p> <p>7.1.5. хос тэжээлт автомашин;</p> <p>7.1.6. шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин;</p> <p>7.1.7. цахилгаан тэжээлт машин.</p>
32	Онцгой албан татварын тэмдгийн тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад үйлдвэрлэсэн болон импортолсон архи, тамхинд онцгой албан татварын тусгай тэмдэг /цаашид “тэмдэг” гэх/ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Онцгой албан татварын тэмдгийг олгох, хэрэглэх</p> <p>4.1. Онцгой албан татварын тэмдгийг Монгол Улсад үйлдвэрлэсэн архи, тамхинд аж ахуйн нэгж, байгууллагын архи, тамхи үйлдвэрлэх зөвшөөрөл, тэдгээрийг худалдах, худалдан авах гэрээг, импортын архи, тамхинд аж ахуйн нэгж, байгууллагын импортлох, худалдан борлуулах гэрээг тус тус үндэслэн Үндэсний татварын алба олгоно.</p> <p>4.2. Тэмдэггүйархи, тамхийг бэлтгэннийлүүлэх, импортлох, худалдах, тэмдгийг хуурамчаар үйлдэх, борлуулах, хэрэглэхийг хориглоно.</p> <p>5 дугаар зүйл. Архи, тамхины үйлдвэрлэл болон импортын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг</p> <p>5.1. Архи, тамхины үйлдвэрлэл болон импортын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэгтэй:</p> <p>5.1.1. өөрийн үйлдвэрлэсэн бараанд тэмдэг нааж борлуулах;</p> <p>5.1.2. үйлдвэрлэлд хэрэглэж байгаа спиртийн хэмжээ, үйлдвэрлэсэн архины тоо хэмжээг үнэн зөвөөр тодорхойлж, холбогдох татварын болон мэргэжлийн хяналтын байгууллагад өгч байх.</p> <p>5.1.3. импортлох архи, тамхины тоо хэмжээг үнэн зөвөөр тодорхойлж, харьяалах татварын алба болон холбогдох гаалийн байгууллагад өгөх;</p> <p>5.1.4. импортлох архи, тамхинд онцгой албан татварын тэмдэг наах.</p> <p>5.2. Архи, тамхины үйлдвэрлэл болон импортын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага үндэсний татварын албанаас авсан тэмдгийг бусдад шилжүүлэх, худалдахыг хориглоно.</p>

<p>33</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Албан татвар ногдуулах ажил, үйлчилгээ</p> <p>4.1. Иргэний зөвхөн хувиараа эрхэлж байгаа дараахь ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулна:</p> <p>4.1.1. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ;</p> <p>4.1.2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцлээр зохицуулагдаагүй бусад ажил, үйлчилгээ.</p> <p>5 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ</p> <p>5.1. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй дараахь ажил, үйлчилгээ эрхлэгч иргэнд сар тутам хуульд заасан хэмжээгээр албан татвар ногдуулна:</p> <p>5.3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулсан аливаа гэрээ, хэлцлээр зохицуулагдаагүй дараахь ажил, үйлчилгээ эрхлэгч иргэний албан татвар ногдуулах орлогыг жишгээр тодорхойлох аргачлалыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална:</p> <p>5.3.1. автомашин болон тээврийн бусад хэрэгсэлд засвар, үйлчилгээ хийх;</p> <p>5.3.2. барилгын засал, чимэглэл, засвар, үйлчилгээ хийх, зураг төсөл зохиох;</p> <p>5.3.3. бильярд тоглуулах;</p> <p>5.3.4. гуанз, цайны газар, буфет, кафе, зуушны газар ажиллуулах;</p> <p>5.3.5. чингэлэг, тээврийн хэрэгсэл дээрээс худалдаа хийх;</p> <p>5.3.6. эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, эмийн худалдаа хийх;</p> <p>5.3.7. төрөл бүрийн хүнсний зүйл үйлдвэрлэж, худалдах;</p> <p>5.3.8. хот, сумын дотор автомашинаар зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ хийх;</p> <p>5.3.9. сум, аймаг, хот, хооронд автомашинаар зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ хийх</p> <p>5.3.10. авто зогсоол ажиллуулах;</p> <p>5.3.11. малын арьс шир, ноос, ноолуур болон бусад түүхий эдийг зуучлан цуглуулж, худалдах;</p> <p>5.3.12. цахилгаан ба хийн гагнуурын үйлчилгээ;</p> <p>5.3.13. хөрөө рам ажиллуулах;</p> <p>5.3.14. төрөл бүрийн гар утасны худалдаа, засвар, үйлчилгээ эрхлэх;</p> <p>5.3.15. тээврийн хэрэгсэл, сэлбэгийн худалдаа хийх;</p> <p>5.3.16. интернетийн үйлчилгээ;</p> <p>5.3.17. нүдний шилний худалдаа, засвар, үйлчилгээ;</p> <p>5.3.18. үсчин, гоо сайхны үйлчилгээ.</p> <p>6 дугаар зүйл. Албан татвар төлөгчийг бүртгэх, гэрчилгээ олгох</p> <p>6.1. Энэ хуулийн 5.1-д заасан ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэн нь тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд бүртгүүлж, албан татварыг бэлнээр буюу бэлэн бусаар төлж, энэ тухай гэрчилгээ авна.</p> <p>6.2. Энэхүү хуулийн 5.3-д заасан ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэн нь тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд бүртгүүлж, Улаанбаатар хотод 10000 төгрөг, Налайх, Багануур, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумд болон байнгын ажиллагаатай боомттой сумдад 8000 төгрөг, бусад аймгийн төвийн сумдад 6000 төгрөг, бусад газарт 4000 төгрөгийг сар бүр бэлнээр буюу бэлэн бусаар урьдчилгаа хэлбэрээр төлж, албан татвар төлөгчийн гэрчилгээ авч тэмдэглүүлэн татварын тайлангаар дараа тооцоо хийж байна.</p>
---	---

34	Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>Энэ хууль нь санхүүгийн түрээс /лизинг/-тэй холбогдсон харилцааг зохицуулна.</p> <p>3 дугаар зүйл. Санхүүгийн түрээс, түүний төрөл</p> <p>3.1. “Санхүүгийн түрээс” гэж түрээслүүлэгч нь түрээслэгчийн захиалгын дагуу энэ хуулийн 6.1-д заасан эд хөрөнгийг өөрөө үйлдвэрлэх буюу гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлэх, эсхүл түүнээс худалдан авч гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд, төлбөртэйгээр түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх, түрээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлөхийг ойлгох бөгөөд үүнийг “анхдагч түрээс” гэж үзнэ.</p> <p>3.2. Санхүүгийн түрээс нь энэ хуулийн 3.1-д зааснаас гадна дараахь төрөлтэй байж болно:</p> <p>3.2.1. түрээслүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр түрээслэгч өөрөө түрээслүүлэгчийн эрх, үүргийг хүлээж түрээсийн зүйлийг гэрээний дагуу бусдад түрээслүүлэх санхүүгийн “дамжуулах түрээс”;</p> <p>3.2.2. түрээслүүлэгч санхүүгийн түрээсийн гэрээ дуусгавар болсны дараа анхдагч түрээслэгчээс түрээсийн зүйлийг буцаан авч өөр түрээслэгчид түрээслүүлэх санхүүгийн “хоёрдогч түрээс”;</p> <p>3.2.3. санхүүгийн түрээсийн гэрээгээр түрээсийн зүйл түрээслэгчийн өмчлөлд шилжсэний дараа түрээслэгч түрээслүүлэгчийн эрх, үүргийг хүлээж гуравдагч этгээдэд буцаан түрээслэх санхүүгийн “эргэх түрээс”.</p> <p>4 дүгээр зүйл. Санхүүгийн дамжуулах түрээс</p> <p>4.1. Дамжуулах түрээсийн түрээслүүлэгч, түрээслэгч нь энэ хуульд заасан журмын дагуу гэрээ байгуулж мөн хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.</p> <p>4.2. Анхдагч түрээсийн гэрээг цуцлах буюу түүнээс татгалзсан тохиолдолд дамжуулах түрээсийн гэрээ нэгэн адил дуусгавар болно.</p> <p>4.3. Түрээсийн гэрээ энэ хуулийн 4.2-г заасны дагуу хугацаанаасаа өмнө дуусгавар болох тохиолдолд дамжуулан түрээслэгч нь анхдагч түрээслүүлэгчтэй тэргүүн ээлжинд гэрээ байгуулах эрхтэй.</p> <p>4.4. Шүүх анхдагч түрээсийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тохиолдолд уг гэрээний үндсэн дээр байгуулсан дамжуулах түрээсийн гэрээ нэгэн адил хүчин төгөлдөр бусад тооцогдоно.</p> <p>4.5. Дамжуулах түрээсийн гэрээний хугацаа анхдагч түрээсийн гэрээний хугацаанаас илүүгүй байна.</p> <p>5 дугаар зүйл. Санхүүгийн түрээст тавих шаардлага</p> <p>5.1. Санхүүгийн түрээс дор дурдсан шаардлагын аль нэгийг хангасан байна:</p> <p>5.1.1. гэрээний хугацаа дуусгавар болоход түрээсийн зүйлийг түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэхээр гэрээнд тусгасан байх;</p> <p>5.1.2. гэрээний хугацааг тухайн түрээсийн зүйл болох эд хөрөнгийн ашиглалтын хугацааны дөрөвний гурваас багагүй байхаар тогтоосон байх;</p> <p>5.1.3. гэрээний нийт үнийг тухайн түрээсийн зүйл болох эд хөрөнгийн үнийн дүнгийн 90 болон түүнээс дээш хувьтай тэнцүү байхаар тогтоосон байх.</p>
35	Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>10 дугаар зүйл. Техникийн зохицуулалт</p> <p>10.1. Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хуурамч бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор техникийн зохицуулалтыг хэрэглэнэ.</p> <p>10.2. Техникийн зохицуулалтыг Засгийн газар батална.</p> <p>10.3. Стандартчиллын төв байгууллага техникийн зохицуулалтын төсөлд шүүлт хийж, дүгнэлт гаргана.</p> <p>10.4. Засгийн газар тухайн техникийн зохицуулалтыг мөрдүүлэх үндэслэл болж байсан нөхцөл, зорилго өөрчлөгдсөн тохиолдолд техникийн зохицуулалтыг хүчингүй болгох буюу түүнд өөрчлөлт оруулна.</p> <p>10.5. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудаас санал болгож буй олон улсын худалдаанд хэрэглэх техникийн зохицуулалтыг улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөх асуудлыг худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.</p>

	<p>10.6. Стандартчиллын төв байгууллага нь Монгол Улсаас олон улсын худалдаанд хэрэглэхээр санал болгосон техникийн зохицуулалтыг батлахаас гурваас доошгүй сарын өмнө Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудад энэ тухай мэдээлнэ.</p> <p>12 дугаар зүйл. Тохирлын үнэлгээний зорилго, төрөл, зарчим</p> <p>12.1. Тохирлын үнэлгээг бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, зөв сонголт хийхэд туслах, хуурамч бүтээгдэхүүнээс хэрэглэгчийг хамгаалах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор хэрэглэнэ.</p>
<p>36</p> <p>Статистикийн тухай</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны зарчим, статистикийн байгууллага, мэдээлэгчийн бүрэн эрхийг тогтоож, тэдгээрийн хооронд болон хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр хангах явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>6 дугаар зүйл. Албан ёсны статистикийн мэдээллийн үзүүлэлт, түүнийг гаргах үндэслэл</p> <p>1. Албан ёсны статистикийн мэдээллэд дараахь үндсэн үзүүлэлт хамаарна:</p> <p>1/ макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт:</p> <p style="padding-left: 20px;">a/ дотоодын нийт бүтээгдэхүүн;</p> <p style="padding-left: 20px;">б/ инфляцийн түвшин, хэрэглээний үнэ;</p> <p>3/ үйлдвэрлэл, шинжлэх ухаан, технологийн статистикийн үзүүлэлт:</p> <p>в/ хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл</p> <p>д/ аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт;</p> <p>е/ аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;</p> <p>и/ экспорт, импортын гол нэр төрөл, хэмжээ;</p> <p>4/ шүүхийн статистикийн үзүүлэлт:</p> <p>г/ дампуурсан аж ахуйн нэгж;</p> <p>2. Мөнгө, зээл, санхүү, гааль, татвар, байгаль орчин, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан техник, технологи, хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, шүүхийн статистикийн мэдээллийг холбогдох яам, төрийн бусад албан газар тус тус эрхлэн гаргаж, Үндэсний статистикийн хороонд өгнө.</p> <p>19 дүгээр зүйл. Яам, төрийн бусад албан газрын статистикийн мэдээллийн талаархи бүрэн эрх</p> <p>Яам, төрийн бусад албан газар энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/ албан ёсны статистикийн мэдээллийг тогтоосон хугацаанд Үндэсний статистикийн хороонд гаргаж өгөх;</p> <p>2/ Үндэсний статистикийн хорооноос холбогдох статистикийн мэдээллийг авч ашиглах;</p> <p>3/ салбарын удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор захиргааны статистик мэдээлэл авах, мэдээллийн санг бий болгох;</p> <p>4/ улсын хэмжээнд тухайн мэдээллээр давхардал гаргахгүйн тулд захиргааны статистик мэдээллийн үзүүлэлт, аргачлал, зааврыг Үндэсний статистикийн хорооноос зөвшөөрснөөр батлах;</p> <p>6/ хуулийн этгээдийг бүртгэх байгууллага нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалт дахь шаардлагатай мэдээлэл, түүнд орсон өөрчлөлтийг Үндэсний статистикийн хороонд тухай бүрт мэдээлэх.</p> <p>5/ үйлдвэрлэл, үйлчилгээний талаар мэдээлэл, судалгаа авах, гаргах;</p> <p>21 дүгээр зүйл. Баг, хорооны Засаг даргын статистикийн мэдээллийн талаархи бүрэн эрх</p> <p>Баг, хорооны Засаг дарга энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5/ үйлдвэрлэл, үйлчилгээний талаар мэдээлэл, судалгаа авах, гаргах.</p>

37	Улсын бүртгэлийн ерөнхий хууль	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэхуулийн зорилт нь улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоотой холбогдсон харилцаа гзохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл. Улсын бүртгэл, түүний нэгдсэн тогтолцоо</p> <p>4.2.Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо дараахь хэсгээс бүрдэнэ:</p> <p>4.2.1.иргэний улсын бүртгэл;</p> <p>4.2.2.хуулийн этгээдийн улсын бүртгэл;</p> <p>4.2.3.эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл.</p> <p>4.4.Хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгаварлохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн бүртгэлийнүйл ажиллагааг хуулийн этгээдийн улсын бүртгэл гэнэ.</p> <p>5.4. Хуулийн этгээдийн улсын бүртгэл дараахь төрөлтэй байна:</p> <p>5.4.1. хуулийн этгээдийн нэр, төрөл, хэлбэр, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн;</p> <p>5.4.2.хуулийн этгээдийг байгуулсан тухай /шинээр, эсхүл өөрчлөн байгуулсан/;</p> <p>5.4.3.хуулийн этгээдийг үүсгэн байгуулагчийн болон үүсгэн байгуулах баримт бичиг, түүнд орсон өөрчлөлтийн;</p> <p>5.4.4.хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох тухай /өөрчлөн байгуулах, татан буулгах/;</p> <p>5.4.5.өөрчлөн байгуулах замаар шинээр үүссэн болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлалын;</p> <p>5.4.6.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаарын;</p> <p>5.4.7.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн жагсаалтад орсон өөрчлөлтийн;</p> <p>5.4.8.тухайн хуулийн этгээд салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын хууль ёсны хаягийн;</p> <p>5.4.9.компани бол түүний хувьцааг эзэмшиж байгаа этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр,нэр,хаяг, эзэмшиж байгаа хувьцааны хэмжээ, түүнд орсон өөрчлөлтийн;</p> <p>5.4.10.компанийн хувьд үүсгэн байгуулах баримт бичигт заасан өөрийн хөрөнгийн хэмжээний;</p> <p>5.4.11.хуулийн этгээдийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн;</p> <p>5.4.12.хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтны овог, эцэг /эх/-ийннэр, нэр, албан тушаал, иргэний үнэмлэх, бичиг баримт болон татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;</p> <p>5.4.13.жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэний.</p>
38	Цагаануур худалдааны чөлөөг бүсийн эрх зүйн байдлын тухай	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь “Цагаануур” худалдааны чөлөөт бүс /цаашид “Цагаануур” бүс гэх/-ийн эрх зүйн байдлыг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>4 дүгээр зүйл.Орлогын албан татварын хөнгөлөлт, албан татвараас чөлөөлөх</p> <p>4.3.”Цагаануур” бүсэд бараа, бүтээгдэхүүнийг хадгалах, хамгаалах, сав, баглаа боодлыг сайжруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа 10 болон түүнээс дээш жил ажиллахаар чөлөөт бүсийн захирагчийн ажлын албатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс тооцон орлогын албан татвараас эхний жилд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.</p> <p>5 дугаар зүйл.Газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт</p> <p>5.1.”Цагаануур” бүсэд дараахь чиглэлээр газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ:</p> <p>5.1.1.худалдаа, нийтийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 3 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө;</p> <p>5.1.2.энэ хуулийн 4.1, 4.2-т заасан “Цагаануур” бүсийн үндсэн дэд бүтцийг бүрдүүлэх ажил эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс эхний 5 жилд газрын төлбөрөөс чөлөөлж, дараагийн 3 жилд 30 хувиар хөнгөлнө.</p>

<p>39</p> <p>Чөлөөт бүсийн тухай</p>	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь чөлөөт бүс байгуулах, түүний хэлбэр, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гаалийн дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Чөлөөт бүс, түүний хэлбэр</p> <p>3.1.”Чөлөөт бүс” гэж гаалийн болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцогдох, хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг хэлнэ.</p> <p>3.2.Чөлөөт бүс нь худалдааны, үйлдвэрлэлийн, хөдөө аж ахуйн, аялал жуулчлал-үйлчилгээний, эдийн засгийн гэсэн хэлбэртэй байна.</p> <p>3.3.Худалдааны чөлөөт бүсэд бараа, бүтээгдэхүүний мөн чанарыг нь алдагдуулахгүйгээр хадгалах, хамгаалах, түүний сав баглаа, боодлыг сайжруулах, борлогдох чанарыг дээшлүүлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлнэ.</p> <p>4 дүгээр зүйл. Чөлөөт бүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэм</p> <p>4.1.Чөлөөт бүсэд татварын хөнгөлөлттэй нөхцөл, аж ахуйн нэгжийн бүртгэлийн хөнгөвчилсөн журам, шалган нэвтрүүлэх хялбарчилсан горим үйлчилнэ.</p> <p>4.2. Зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг чөлөөт бүсэд зөвхөн гаалийн хяналт бүхий гарцаар нэвтрүүлднэ. Чөлөөт бүсэд гаалийн хяналт тавих журмыг гаалийн удирдах төв байгууллага батална.</p> <p>4.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг чөлөөт бүсэд нэвтрүүлэхийг хориглоно .</p> <p>4.4. Хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргах бараанд тарифийн бус хязгаарлалт тогтоохгүй.</p> <p>4.5.Чөлөөт бүсэд төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар хийнэ. Чөлөөт бүсэд валютын зохицуулалтын тусгай журам үйлчилнэ. Валютын зохицуулалтын журмыг Монголбанк тогтооно.</p> <p>13 дугаар зүйл. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахаг ахуйн нэгжийг бүртгэх</p> <p>13.1.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж бүртгүүлэхдээ дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>13.1.1. чөлөөт бүсэд эрхлэх, татварын хөнгөлөлтөд хамаарах үйлдвэрлэл, үйлчилгээ нь тухайн чөлөөт бүсийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэлд нийцэх;</p> <p>17 дугаар зүйл. Чөлөөт бүсэд татвар ногдуулах, татвараас чөлөөлөх</p> <p>17.1.Чөлөөт бүсэд бараа оруулахад дараахь албан татварыг ногдуулах болон татвараас чөлөөлнө:</p> <p>17.1.1. чөлөөт бүсэд барааг хилийн чанадаас оруулахад импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй;</p> <p>17.1.2. импортын гаалийн, онцгой болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг чөлөөт бүсэд оруулахад экспортын гаалийн албан татвар ногдуулахгүй.</p> <p>17.1.3. монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулахад экспортын гаалийн албан татвартай бол түүнийг ногдуулж, нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгоно.</p> <p>17.2. Чөлөөт бүсээс бараа гаргахад дараахь албан татварыг ногдуулах болон албан татвараас чөлөөлнө:</p> <p>17.2.1.барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн, онцгой албан татвар ногдуулна;</p> <p>17.2.2.энэ хуулийн 17.1.2-г заасан барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй.</p> <p>17.2.3.монголын барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулахад импортын гаалийн болон онцгой албан татвар ногдуулахгүй. Энэ тохиолдолд экспортын гаалийн татварыг буцаан олгож, нэмэгдсэн өртгийн албан татварыг ногдуулна.</p> <p>17.2.4.чөлөөт бүсээс барааг хилийн чанадад гаргахад экспортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй. Хуулиар тусгайлан ногдуулсан бол экспортын албан татвар ногдуулна.</p>
--------------------------------------	--

40	Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, түүнд хяналт тавих эрх зүйн үндсийг тогтоож, хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах, ашиглахад төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хэмжлийн нэгж</p> <p>5. Экспортод нийлүүлж байгаа бүтээгдэхүүний чанар, техникийн үзүүлэлтийг захиалагчаас хүссэн хэмжлийн нэгжээр илэрхийлж болно.</p> <p>7 дугаар зүйл. Хэмжилзүйн төрийн хяналт шалгалт, түүний хүрээ, хэлбэр</p> <p>2. Дараахь үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлалыг хэмжил зүйн төрийн хяналт шалгалтад хамруулна:</p> <p>1/ худалдаа, үйлчилгээний тооцоо;</p> <p>2/ хүн, мал эмнэлгийн шинжилгээ, эмчилгээ, оношлогоо;</p> <p>3/ байгаль орчны хамгаалал;</p> <p>4/ улсыг баглан хамгаалах, аюулгүй байдлыг хангах.</p> <p>4. Хэмжил зүйн төрийн хяналт шалгалтыг дараахь хэлбэрээр гүйцэтгэнэ:</p> <p>1/ савласан бүтээгдэхүүний тоон хэмжээг хянах;</p> <p>2/ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих.</p> <p>10 дугаар зүйл. Хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, суурилуулалт, засвар худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл</p> <p>Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, суурилуулалт, засвар, худалдах ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага Хэмжилзүйн төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авна.</p> <p>2. Тусгай зөвшөөрөлтэйгээр суурилуулах хэмжих хэрэгслийн жагсаалтыг хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>11 дүгээр зүйл. Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хяналт</p> <p>1. Савласан бүтээгдэхүүн нь дараахь шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ сав, боодлыг задлах буюу эвдэхгүйгээр түүний доторхи бараа, бүтээгдэхүүний тоон хэмжээг өөрчлөх боломжгүй савласан, боосон байх;</p> <p>2/ тухайн бүтээгдэхүүний хүнд, эзэлхүүн зэрэг бусад тоон үзүүлэлтийг сав, боодол дээр нь тэмдэглэсэн байх.</p> <p>2. Савласан, боосон, түүнчлэн ширхэгээр худалдах бүтээгдэхүүний тоон хэмжээний дундаж утга нь түүний холбогдох стандарт болон сав, боодол дээр буюу дагалдах баримт бичигт тэмдэглэсэн тоон хэмжээний хэвийн утгатай, тодорхой нэг савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний утга нь хэвийн утгын зөвшөөрөгдөх хэлбэлзлийн хязгаартай тус тус тохирч байна.</p>
41	Хувь хүний орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>5 дугаар зүйл. Албан татвар төлөгч</p> <p>5.1. Тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлого олоогүй ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсад оршин суугч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.</p> <p>12 дугаар зүйл. Үйл ажиллагааны орлого</p> <p>12.1. Үйл ажиллагааны орлогод хуулийн этгээд байгуулахгүйгээр бие даан мэргэжлийн үйлчилгээ, үйлдвэрлэл, арилжаа эрхэлж олсон дараахь орлогыг хамруулна:</p> <p>12.1.2. хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлого.</p> <p>12.2. Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна.</p> <p>13 дугаар зүйл. Хөрөнгийн орлого</p> <p>13.3. Эрхийн шимтгэлийн орлогод дараахь төлбөр хамаарна:</p> <p>13.3.1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасан зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг ашигласны төлбөр;</p> <p>13.3.2. Патентын тухай хуульд заасан шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар ашигласны төлбөр;</p>

		<p>13.3.3.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн дагуу барааны тэмдэг ашигласны төлбөр;</p> <p>13.3.4.Технологи дамжуулах тухай хуульд заасны дагуу технологи дамжуулсны төлбөр;</p> <p>13.3.5.Үйлдвэрлэл, худалдааны талаархи болон шинжлэх ухааны туршилттай холбогдсон мэдээллийг ашигласны төлбөр;</p> <p>13.3.6.энэ хуулийн 13.3.1-13.3.5-д заасантай адилтгах бусад эрх ашигласны төлбөр.</p>
42	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь хуулийн этгээд байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт орсныг улсын бүртгэлд бүртгэх, түүнчлэн хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>7 дугаар зүйл. Бүртгэх байгууллага</p> <p>7.1. Хуулийн этгээдийг дор дурдсан байгууллага /цаашид “бүртгэх байгууллага” гэх/ бүртгэнэ:</p> <p>7.1.1.нөхөрлөл, компани, хоршоо, төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, холбоо, сан, шашны байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар;</p> <p>17.1. Бүртгэх байгууллагын энэ хуулийн 13.1-д заасан шийдвэр нь улсын бүртгэлийн жагсаалтад тухайн хуулийн этгээдийг бүртгэх тухай бичилт хийх үндэслэл болно. Бүртгэлийн бичилт бүрт улсын бүртгэлийн дугаар олгож, бүртгэсэн огноог тэмдэглэнэ.</p> <p>17.2.Хуулийн этгээдийг улсын бүртгэлийн жагсаалтад оруулж, бүртгэлийн бичилт хийсний дараа тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгийн эхний хуудсан дээр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар, бүртгэсэн байгууллагын нэр, он, сар, өдөр бүхий тэмдэг дарж, хариуцсан бүртгэлийн ажилтан гарын үсэг зурсанаар тухайн хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.</p> <p>17.3.Бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан энэ тухай нийтэд мэдээнэ.</p> <p>17.4.Бүртгэх байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэснийг нотолж өргөдөл гаргагчид улсын бүртгэлийн гэрчилгээ буюу дугаар олгоно.</p> <p>17.5.Улсын бүртгэлийн гэрчилгээний загварыг Засгийн газар батална.</p>
43	Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь худалдаа, аж үйлдвэрийн танхим болон худалдааны танхим /цаашид «танхим» гэх/-ын бүрэн эрх, үйл ажиллагааны үндсэн чиглэл, түүний тогтолцоо, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох, танхим болон төрийн ба бусад байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн хоорондын харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Танхимын тухай ойлголт</p> <p>1. Танхим нь аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдаа, үйлдвэрлэл эрхлэхтэй холбогдсон нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах болон худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор байгуулсан ашгийг төлөө бус хуулийн этгээд мөн.</p> <p>4 дүгээр зүйл. Танхимын зорилт, бүрэн эрх</p> <p>1. Танхим нь улс орны эдийн засгийн хөгжилд тус дэмжлэг үзүүлэх, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх таатай нөхцөл бүрдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудаас гадаад, дотоодын байгууллагатай худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, өөрийн орны бараа, бүтээгдэхүүнийг экспортод гаргахад дэмжлэг үзүүлэх зорилтыг хэрэгжүүлнэ.</p> <p>2. Танхим нь дараахь бүрэн эрх эдэлнэ:</p> <p>1/ гишүүдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах асуудлаар төрийн байгууллагатай харилцах;</p> <p>2/ үйл ажиллагааны дүрэм, бүтэц, зохион байгуулалтаа батлах;</p> <p>3/ салбар болон төлөөлөгчийн газраа дотоод, гадаадад нээн ажиллуулах.</p> <p>3. Танхим нь бүрэн эрхийнхээ хүрээнд дараахь үйл ажиллагаа явуулна.</p> <p>1/ дотоод, гадаадын зах зээлийн мэдээлэл солилцох;</p> <p>2/ дотоод, гадаадын эдийн засгийн байгууллага, үйлдвэр, худалдааныхны судалгааны болон ажил хэргийн төлөөлөгчид солилцох, уулзалт хэлэлцээг зохион байгуулах;</p> <p>3/ гадаадын аж ахуйн нэгж, байгууллагуудад үйлдвэрлэл, худалдаа эрхлэхтэй нь холбогдсон үйлчилгээ үзүүлэх;</p> <p>4/ дотоод, гадаадад үйлдвэр, худалдааны олон улсын болон төрөлжсөн үзэсгэлэн, яармаг зохион байгуулах;</p>

43	Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль	<p>5/ реклам, сурталчилгааны үйлчилгээ үзүүлэх, уран сайхны зарлал, чимэглэлийн эхийг бэлтгэх, хийлгэх;</p> <p>6/ аж ахуйн нэгж, байгууллагууд зөвлөлгөө өгөх, үйлдвэр, худалдааны түнш эрх олохтой холбогдсон мэдээллээр хангах, боловсон хүчин бэлтгэхэд нь туслах болон бусад үйлчилгээ үзүүлэх;</p> <p>7/ олон улсын болон гадаад улсын худалдаа, эдийн засгийн байгууллага, танхим, худалдаа, үйлдвэрлэл дэмжих байгууллагатай хамтран ажиллах;</p> <p>8/ дотоодын шинээр бий болсон жижиг, дунд үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;</p> <p>9/ Монгол улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан бусад үйл ажиллагаа явуулах.</p> <p>6 дугаар зүйл. Үндэсний танхим</p> <p>2. Үндэсний танхим нь танхимын нийтлэг зорилт, бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дараахь тодорхой бүрэн эрхтэй байна:</p> <p>1/ төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал дүгнэлт оруулах, түүний дотоод, гадаадад тайлбарлан таниулах, хэрэгжилтэд нь тус дэмжлэг үзүүлэх;</p> <p>2/ худалдаа, үйлдвэрийнхний нийтлэг эрх ашгийг төрийн эрх барих болон гүйцэтгэх дээд байгууллагад төлөөлөн илэрхийлэх, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар санал оруулах;</p> <p>3/ экспортын барааны гарал, үүслийг гэрчлэх;</p> <p>4/ хуульд зааснаар дэргэдээ гадаад худалдааны арбитр байгуулан ажиллуулах;</p> <p>5/ экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах;</p> <p>6/ давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх.</p> <p>11 дүгээр зүйл. Танхимын санхүүжилт, түүний эх үүсвэр</p> <p>1. Танхимын санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:</p> <p>1/ гишүүний татвар;</p> <p>2/ иргэд, байгууллагын хандив;</p> <p>3/ үйлчилгээний орлого.</p> <p>2. Танхим нь ашиг олох зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулахгүй боловч Иргэний хууль, энэ хуульд заасан буюу дүрмийнхээ зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээг төлбөртэй гүйцэтгэнэ.</p> <p>3. Танхимын үйлчилгээний хөлсний хэмжээг танхимын саналыг үндэслэн Сангийн сайд, Худалдаа үйлдвэрийн сайд хамтран тогтооно.</p>
44	Хоршооны тухай	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь хоршооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршооны тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл. Хоршоо, түүний үйл ажиллагааны төрөл</p> <p>3.4. Хоршоо нь дараахь төрлийн үйл ажиллагаа эрхэлж болно:</p> <p>3.4.1. түүхий эд боловсруулалтын;</p> <p>3.4.2. үйлдвэрлэлийн;</p> <p>3.4.3. хадгаламж, зээлийн;</p> <p>3.4.4. борлуулалт, хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн;</p> <p>3.4.5. үйлчилгээний;</p> <p>3.4.6. орон сууц барих зориулалтын;</p> <p>3.4.7. эд хэрэглэгчдийн;</p> <p>3.4.8. дүрэмд заасан үйл ажиллагаа.</p> <p>3.5. Хоршоо нь энэ хуулийн 3.4-т заасан хэд хэдэн үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхэлж болно.</p>

45	Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1.“Монгол Улсын нутаг дэвсгэр” гэж эдийн засгийн чөлөөт бүс, Монгол Улсад байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын байршлаас бусад Монгол Улсын газар нутгийг;</p> <p>3.1.2.“үндэсний мөнгөн тэмдэгт” гэж Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төлбөрийн хууль ёсны хэрэгсэл болох төгрөгийг хэлэх бөгөөд төгрөгийг англи хэл дээр “Togrog”, товчлолыг “MNT” гэж бичнэ;</p> <p>3.1.6.“гадаадын валют” гэж улс хоорондын худалдаа, эдийн засаг, санхүүгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж байгаа гадаад орны мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэж, түүгээр төлөгдөх үнэт цаас, төлбөрийн бусад хэрэгслийг;</p> <p>4 дүгээр зүйл.Үндэсний мөнгөн тэмдэгтийн хэрэглээ</p> <p>4.1.Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.</p>
46	Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдалын тухай	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн үндсийг тодорхойлж, үйлдвэрлэл, технологийн паркбайгуулах, түүний удирдлага, үйл ажиллагаа, хяналтын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.1.“үйлдвэрлэл, технологийн парк” /цаашид “парк” гэх/ гэж үйлдвэрлэл, технологийн хөгжлийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэх тусгайлсан нутаг дэвсгэр, бизнесийн таатай орчин, дэд бүтцийн хангамж бүхий, тодорхой салбарт үйл ажиллагаагаар харилцан уялдсан үйлдвэрлэл, технологи,үйлчилгээний цогцолборыг;</p> <p>3.1.3.“паркийн нэгж” паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллагыг.</p> <p>4 дүгээр зүйл.Парк байгуулах зорилго</p> <p>4.1.Паркийг дараахь зорилгоор байгуулна:</p> <p>4.1.5.жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох.</p>
47	Татварын ерөнхий хууль	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>12 дугаар зүйл. Татвар төлөгч</p> <p>12.1.Татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа, тодорхой эрх бүхий, эсхүл ажил үйлчилгээ эрхэлж, түүнчлэн газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц ашигласан, агаар, ус, хөрс бохирдуулснаас татвар төлөх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд татвар төлөгч байна.</p> <p>6 дугаар зүйл. Татвар ногдох зүйл</p> <p>6.1.Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна.</p> <p>7 дугаар зүйл. Татварын төрөл, ангилал</p> <p>7.1.Татварыг татварын төрөлд ангилж ба тодорхой төрлийн татварын харилцааг энэ хууль болон тухайн төрлийн татварын хуулиар зохицуулна.</p> <p>7.2.Тодорхой төрлийн татвар нь улсын болон орон нутгийн татварын аль нэгэнд хамаарна.</p>

48	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1.Энэ хуулийн зорилт нь хүний болон мал эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур /цаашид “эм” гэх/, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.24.“эмийн сан” гэж эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг эм, эмнэлгийн хэрэгслээр жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;</p> <p>4 дүгээр зүйл.Эмийн үндэсний бодлого</p> <p>4.5.Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн болон өнчин эмийн жагсаалтыг төрийн захиргааны холбогдох төв байгууллага батална.</p> <p>4.6.Энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон эмийн үнийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно.</p> <p>5 дугаар зүйл. Эмийн зөвлөл</p> <p>5.5.Эмийн зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.5.4.эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах;</p> <p>6 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын талаархи төрийн зохицуулалт</p> <p>6.1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналттай холбоотой үйл ажиллагааг төрийн зүгээс нэгдсэн зохицуулалтаар хангана.</p> <p>6.2.Энэ хуулийн 6.1-д заасан төрийн зохицуулалтыг дараахь үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ: 6.2.1.эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, зах зээл дэх чанар, аюулгүй байдлын тандалт судалгаа; 6.2.2.үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл 6.2.3.импорт, экспортын лиценз, хяналт, зохицуулалт; 6.2.8.эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрөл, хяналт; 6.2.9.зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт, хяналт; 6.2.10.эмнэлгийн мэргэжилтэн болон олон нийтэд зориулсан эмийн талаархи хараат бус, бодит мэдээлэл.</p> <p>6.3.Энэ хуулийн 6.2-т заасан зохицуулалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.</p> <p>7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл</p> <p>7.1.Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.</p> <p>7.2.Малын эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрлийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.</p>
49	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	<p>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь төрийн хяналт шалгалтын тогтолцоо, төрийн захиргааны хяналт шалгалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.</p> <p>3 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.“хяналт шалгалт ” гэж иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа / үйлдэл, эс үйлдэхүй/, түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг; 3.1.2.“хяналт шалгалтын арга, хэлбэр” гэж тухайн хяналт шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх, шалгуулагч этгээдийн үйл ажиллагаагаа явуулдаг нутаг дэвсгэр, байр, барилга байгууламж, өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд үзлэг хийх, бүтээгдэхүүн болон тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны орчноос дээж авч шинжлэх, турших, учирсан хор хохирол болон гаргасан зөрчлийн хоорондох уялдаа холбоог</p>

<p>49</p>	<p>Төрийн хяналт шалгалтын тухай хууль</p>	<p>тогтоох зорилгоор шинжилгээ явуулах зэрэг хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагын албан тушаалтан, түүнчлэн хууль тогтоомжид заасан журмын дагуу хяналт шалгалтад татагдан оролцож байгаа шинжээч, шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг;</p> <p>3.1.3."хяналт шалгалтын бүртгэл" гэж хийсэн хяналт шалгалт бүрийг зохих журмын дагуу мэдээллийн нэгдсэн санд бүртгэхийг.</p> <p>5 дугаар зүйл. Шинжилгээнд дээж авах</p> <p>5.1.Хяналт шалгалтын явцад бүтээгдэхүүнээс дээж /цаашид "дээж" гэх/ авах бол улсын байцаагч тусгайлан акт бичих бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:</p> <p>5.1.1.дээж авах тухай акт бичсэн он, сар, өдөр, газар;</p> <p>5.1.2.шалгуулагч этгээдийн нэр, хаяг;</p> <p>5.1.3.дээж авахад байлцсан шалгуулагч этгээдийн төлөөлөгчийн нэр, албан тушаал;</p> <p>5.1.4.дээж авсан улсын байцаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;</p> <p>5.1.5.дээж авах үндэслэл, шаардлага;</p> <p>5.1.6.импортолсон улс болон үйлдвэрлэгчийн нэр;</p> <p>5.1.7.дээж авсан хугацаа, бүтээгдэхүүний нэр, төрөл, савлалт, цувралын дугаар, үйлдвэрлэсэн болон хадгалалтын дуусах хугацаа, нийт импортолсон болон дээж авсан тоо хэмжээ, дээжийн үнэ.</p>
<p>50</p>	<p>Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль</p>	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1."хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж" /цаашид "бирж" гэх/ гэж хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээгээр болон энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан биржийн арилжааны төрөл, хэлбэрээр зохион байгуулдаг компанийг;</p> <p>3.1.2."биржээр арилжих хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд" /цаашид "бараа, түүхий эд" гэх/ гэж биржээр арилжих барааны жагсаалтад орсон, гарал үүсэл, чанарын гэрчилгээтэй, биржийн гэрээний стандартыг хангасан бараа, түүхий эдийг;</p> <p>3.1.3."биржийн арилжаанд оролцогч" гэж биржид бараа, түүхий эд арилжих зорилгоор бүртгүүлсэн, биржийн арилжаанд оролцох зөвшөөрөлтэй хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо, биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийг;</p> <p>3.1.4."биржийн арилжааны зах зээлд оролцогч" гэж бараа, түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, чанар, тоо хэмжээг тодорхойлох, хадгалах, тээвэрлэх, зуучлан арилжих, биржийн арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, гарал үүслийг гэрчлэх, экспортлох үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээдийг;</p> <p>3.1.5."биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа" гэж бараа, түүхий эдийг гэрээний үндсэн дээр биржээр зуучлан арилжих ажиллагааг;</p> <p>3.1.6."биржийн арилжаа" гэж биржийн арилжаанд оролцогчдын хооронд байгуулах гэрээний үндсэн дээр бараа, түүхий эдийг худалдах, худалдан авах үйл ажиллагааг;</p> <p>3.1.7."биржийн дэнчин" гэж биржийн арилжааны зуучлагч /брокер/ нь гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хэрэгжүүлэх баталгаа болгон энэ хуулийн 6.1-д заасан байгууллага дахь өөрийн дансанд урьдчилан байршуулсан мөнгийг;</p> <p>3.1.8."суудлын эрх" гэж биржийн арилжаанд тогтмол оролцох эрхийг.</p> <p>4 дүгээр зүйл.Бирж</p> <p>4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжааг зохион байгуулах төрөлжсөн нэг бирж үйл ажиллагаа явуулна.</p> <p>4.2.Бирж нь биржийн арилжааг зохион байгуулахдаа бие даасан, нээлттэй, ил тод, харааг бус байх үндсэн зарчмыг баримтална.</p> <p>4.3.Бирж нь зориулалтын байр, төвлөрсөн мэдээллийн сантай байх бөгөөд биржийн арилжааг зохион байгуулах программ хангамж, сүлжээний найдвартай байдлыг хангасан байна.</p> <p>4.4.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа биржийн арилжаанд оролцогч нь цахим сүлжээгээр дамжуулан биржийн арилжаанд шууд оролцож болно.</p>

50	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай	<p>4.5.Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>4.6.Энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргахдаа биржээр арилжаалсан байна.</p> <p>4.7.Бараа, түүхий эдийг биржийн арилжаанд оролцож худалдан авсан тухай тодорхойлолтыг үндэслэн дор дурдсан иргэн, хуулийн этгээдэд урамшуулал олгох журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална:</p> <p>4.7.1.хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо /цаашид “хоршоо” гэх/-ны гишүүн;</p> <p>4.7.2.газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч.</p> <p>4.8.Биржээс гадуурх бараа, түүхий эдийн арилжаанд биржийн нэр ашиглахыг хориглоно.</p> <p>4.9.Биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.</p> <p>4.10.Энэ хуулийн 4.5, 5.1.7-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг төсвийн хөрөнгөөр худалдан авах бол биржээр дамжуулна.</p> <p>4.11.Бирж нь өөрийн нэрийн өмнөөс болон бусад оролцогчийн нэрийн өмнөөс биржийн арилжаанд оролцохыг хориглоно.</p> <p>5 дугаар зүйл.Биржийн чиг үүрэг</p> <p>5.1.Бирж нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1.биржийн арилжааг зохион байгуулах;</p> <p>5.1.2.биржийн байнгын гишүүн оролцогчид суудлын эрх олгох;</p> <p>5.1.3.биржийн байнгын бус гишүүн оролцогчид биржийн арилжаанд оролцох зөвшөөрөл олгох;</p> <p>5.1.4.энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргах тохиолдолд биржээр арилжсан тухай тодорхойлолтыг Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх эрх бүхий байгууллагад хүргүүлэх;</p> <p>5.1.5.биржийн арилжаанд оролцогчийг сургах, мэргэшүүлэх, итгэмжлэл олгох;</p> <p>5.1.6.биржийн арилжаанд оролцогчийг шаардлагатай мэдээллээр хангах;</p> <p>5.1.7.энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсноос бусад нэр төрлийн бараа, түүхий эдийг биржээр арилжих жагсаалтыг батлах;</p> <p>5.1.8.биржийн арилжаанд оролцогчийн хүсэлтээр бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг хянан баталгаажуулж магадлагаа гаргах;</p> <p>5.1.9.биржийн арилжааны явцад зохиомлоор үнэ өсгөх, бууруулах оролдлого хийж байгаа эсэхэд хяналт тавих, таслан зогсоох;</p> <p>5.1.10.нэг хэлцлээр арилжих бараа, түүхий эдийн доод хэмжээг тогтоох;</p> <p>5.1.11.стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох.</p> <p>5.2.Бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын нийтлэг үйл ажиллагааг зохицуулсан дор дурдсан журмыг энэ хуулийн 8.1-д заасан Биржийн зохицуулах зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, мөрдүүлнэ:</p> <p>5.2.1. бараа, түүхий эдийг бэлтгэх, хаяглах, хадгалах, тээвэрлэх;</p> <p>5.2.2.бараа, түүхий эдийг бүртгэх;</p> <p>5.2.3.бараа, түүхий эдийг агуулахад хүлээн авах;</p> <p>5.2.4.биржээр арилжих гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх;</p> <p>5.2.5.биржийн арилжааг зохион байгуулах;</p> <p>5.2.6.биржийн арилжааны үнэ бүрдэлтэд хяналт тавих;</p> <p>5.2.7.биржийн арилжааны төлбөр тооцоо хийх;</p> <p>5.2.8.энэ хуулийн 4.3-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах;</p> <p>5.2.9.биржийн арилжаанд оролцогчийн үйл ажиллагааг зохицуулах;</p> <p>5.2.10.энэ хуулийн 5.1.11-д заасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох;</p> <p>5.2.11.биржээр арилжих бараа, түүхий эдийн гарал үүсэл, чанарыг баталгаажуулах;</p> <p>5.2.12. биржийн дэнчингийн хувь хэмжээг тогтоох;</p> <p>5.2.13.баталгааны санд биржийн дэнчин байршуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулах;</p> <p>5.2.14.бусад.</p>
----	---	---

<p>50</p> <p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Холоо аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль</p>	<p>6 дугаар зүйл.Биржийн төлбөр тооцоо, хадгаламж</p> <p>6.1.Бирж нь биржийн гэрээний төлбөрийн үүргийг тодорхойлох, төлбөр тооцоог гүйцэтгэх, гэрээг бүртгэх, хадгалах үйлчилгээг гэрээний үндсэн дээр банк, үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагаар гүйцэтгүүлэх, эсхүл уг үүргийг гүйцэтгэх тусгайлсан нэгж /цаашид “төлбөр тооцооны төв” гэх/-тэй байна.</p> <p>6.2.Энэ хуулийн 6.1-д заасан төлбөр тооцооны төв нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42, 44, 45 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:</p> <p>6.2.1.талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн болон хэсэгчлэн биелүүлээгүйгээс гарах хохирлын хэмжээг тодорхойлох;</p> <p>6.2.2.гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргийг гүйцэтгүүлэх;</p> <p>6.2.3.энэ хуулийн 6.2.2-т заасан үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор төлбөр тооцооны эрсдэлийг зохицуулах;</p> <p>6.2.4.бусад.</p> <p>7 дугаар зүйл.Биржийн арилжааны төрөл, хэлбэр</p> <p>7.1.Биржээр зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээг ашиглан дуудлага худалдааны хэлбэрээр дараах төрлийн гэрээг арилжина:</p> <p>7.1.1.шууд арилжих гэрээ /spot/;</p> <p>7.1.2.хугацаат гэрээ /форвард/ ;</p> <p>7.1.3.нэг загварын гэрээ /фьючерс/;</p> <p>7.1.4.ирээдүйд худалдах, худалдан авах гэрээ /опцион/.</p> <p>7.2.Бараа, түүхий эдийг тогтоосон үнээр шууд, биет байдлаар нийлүүлэх гэрээг “шууд арилжих гэрээ” гэнэ.</p> <p>7.3.Бараа, түүхий эдийг тогтоосон хугацаанд, тохиролцсон нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд нийлүүлэх болон төлбөр гүйцэтгэх гэрээг “хугацаат гэрээ” гэнэ.</p> <p>7.4.Бараа, түүхий эдийг тогтоосон хугацаанд, тохиролцсон үнээр ирээдүйд нийлүүлэх стандарт нөхцөл бүхий гэрээг ”нэг загварын гэрээ” гэнэ.</p> <p>7.5.Иргэний хуулийн 269.1-д заасан гэрээг ”ирээдүйд худалдах, худалдан авах гэрээ” гэнэ.</p> <p>10 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогч</p> <p>10.1.Биржийн арилжаанд оролцогчийг байнгын болон байнгын бус гишүүн оролцогч гэж ангилна.</p> <p>10.2.Биржийн арилжааны зуучлагч /брокер/ нь үндэсний хөрөнгө оруулалт давамгайлсан хуулийн этгээд байх бөгөөд биржийн байнгын гишүүн оролцогч байна.</p> <p>10.3.Хоршоо нь байнгын бус гишүүн оролцогч байна.</p> <p>10.4.Биржийн байнгын гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт болон энэ хуулийн 11.2.3, 11.2.6-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд авна.</p> <p>10.5.Биржийн арилжаанд дараах этгээдийг оролцохыг хориглоно:</p> <p>10.5.1.биржийн ажилтан;</p> <p>10.5.2.даатгал, тусламжийн сан, тэдгээрийн ажилтан;</p> <p>10.5.3.хууль тогтоомжоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон бусад этгээд.</p> <p>10.6.Биржийн байнгын бус гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох зөвшөөрлийг биржээс авсан байна.</p> <p>10.7.Хоршоо нь анхан шатны тордолт хийж стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг биет байдлаар нийлүүлэх гэрээ байгуулж биржийн арилжаанд оролцоно.</p> <p>10.8.Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн биржийн арилжаанд биржийн байнгын гишүүн оролцогчоор зуучлуулан оролцоно.</p> <p>11 дүгээр зүйл. Биржийн арилжаанд оролцогчийн эрх, үүрэг</p> <p>11.1.Биржийн арилжаанд оролцогч нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй:</p> <p>11.1.1.биржийн арилжааг ил тод, шударгаар явуулах;</p> <p>11.1.2.стандартын /бэлтгэх, хадгалах, тэвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сумын мал эмнэлэг, үржлийн тасагт бүртгүүлж, мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулсан бараа, түүхий эдийг арилжих;</p> <p>11.1.3.бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг биржид үнэн зөв мэдээлэх, бүртгүүлэх;</p>
--	---

50	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль	<p>11.1.4.энэ хуулийн 11.1.3-т заасныг зөрчсөнөөс худалдан авагчид учирсан хохирлыг тухайн арилжаанд оролцогч хариуцан барагдуулах;</p> <p>11.1.5.биржийн арилжааны мэдээллийг ашиглах;</p> <p>11.1.6.биржийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.</p> <p>11.2.Биржийн байнгын гишүүн оролцогч нь энэ хуулийн 11.1-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:</p> <p>11.2.1.суудлын эрх авах;</p> <p>11.2.2.энэ хуулийн 7.1.1-7.1.4-т заасан гэрээ байгуулсны үндсэн дээр биржийн арилжаанд тогтмол оролцох;</p> <p>11.2.3.бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн агуулахтай байх, эсхүл итгэмжлэгдсэн агуулах бүхий этгээдтэй гэрээ байгуулсан байх;</p> <p>11.2.4.биржийн арилжааны сүлжээнд холбогдсон байх;</p> <p>11.2.5.эрх бүхий байгууллагаас зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;</p> <p>11.2.6.итгэмжлэгдсэн лаборатори, тээврийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байх.</p> <p>12 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогчид хориглох зүйл</p> <p>12.1.Биржийн арилжаанд оролцогчид дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>12.1.1.биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн болон түүний бараа, түүхий эдийн нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;</p> <p>12.1.2.харилцан тохиролцох замаар биржээр арилжих бараа, түүхий эдийн үнийн түвшинд хязгаар тогтоох;</p> <p>12.1.3.өөрийн болон биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн бараа, түүхий эдийг үйлдвэрлэсэн арга, хэрэглээний шинж чанарын гол үзүүлэлт, хэрэглэх аргын талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх, хуурч мэхлэх;</p> <p>12.1.4.хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.</p>
----	---	--

2. ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЖУРАМ

Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж нь өөрөө үйлдвэрлэл явуулахгүй боловч үйлдвэрлэгчээс бараа, материал худалдан авч, ямар нэг нэмэлт боловсруулалт хийлгүйгээр дахин худалддаг онцлогтой салбар бол худалдааны салбар юм.

Худалдааны байгууллагууд ихэнхдээ бөөний болон жижиглэн худалдаа дагнах эсвэл холимог хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Бөөний худалдаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эсвэл дараагийн шатны худалдаанд зориулан бөөнөөр борлуулах үйл ажиллагааг хамруулдаг бол харин жижиглэн худалдаанд хүн амын хэрэгцээнд зориулсан өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнд дахин боловсруулалт хийлгүй эцсийн хэрэглэгчид хүргэх үйл ажиллагаа багтдаг.



ААНБ-ын тоо бизнес регистрийн санд 2018 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй 85.7 мянган аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 33.9 мянган аж ахуйн нэгж буюу 39.6 хувь нь худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллага байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018*
Бүгд	59 843	64 301	72 182	78 585	85 749
Худалдааны салбарын ААНБ-ын тоо	22 793	24 194	27 744	30 510	33 930
Худалдааны салбарын ААНБ-ын эзлэх хувь	38.1	37.6	38.4	38.8	39.6

Улсын хэмжээнд худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 2018 онд 33930 болж, өмнөх оноос 3420 буюу 11.2 хувиар өслөө. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоог бүсээр авч үзвэл, Улаанбаатар хотод дийлэнх буюу 71.5 хувь, Төвийн бүсэд 9.1 хувь, Хангайн бүсэд 8.0 хувь, Баруун бүсэд 7.9 хувь, Зүүн бүсэд 3.4 хувь нь ногдож байна. Худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын тоо сүүлийн жилүүдэд тасралтгүй өсөж ирсэн байна.

Худалдааны аж ахуйн нэгж, байгууллагын 95.3 хувийг 1-9 ажиллагсадтай жижиг аж ахуйн нэгж, байгууллага эзэлж байна. 10-19 ажиллагчидтай аж ахуйн нэгж, 14 байгууллага 2.5 хувийг, 20-49 ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага 1.4 хувийг эзэлж, үлдэх 0.8 хувийг 50-иас дээш ажиллагчидтай ААНБ бүрдүүлж байна.

Худалдааны байгууллагууд үйл ажиллагаагаа Монгол улсад мөрдөгдөж буй стандартын дагуу хэрэгжүүлдэг. Түүнээс гадна олон даган мөрдөх нийтлэг журмууд байдаг-энэ нь стандарт юм.

Барааны чанарт тавигдвал зохих шаардлагуудыг хуульчлан баталгаажуулсан баримт бичгийг барааны стандарт гэнэ. Улс орон бүр өөрийн үйлдвэрлэж байгаа болон өөрийн зах зээлд худалдаалагдаж байгаа бараанд стандарттай байлгахыг зорьдог. Стандартын шаардлага хангасан бараанд тохирлын тэмдэг олгогдсон гэж үздэг. Мөн олон улсын хэмжээнд мөрддөг ISO хэмээх олон улсын стандарт байдаг.



Стандартыг түүхий эд, материал, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч үйлдвэр, аж ахуйн газрууд өөрсдөө боловсруулж стандарчиллын төв байгууллагаар батлуулна. Монгол улсын үндэсний стандартыг MNS (УСТ) гэж тэмдэглэдэг. Ихэнхдээ стандарт нь зургаан үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- стандартын нэр, зориулалт, дугаар, хамрах хүрээ, нэр томьёо
- барааны ангилалт, нэр төрөл, хэв маяг, хэмжээ
- барааны техникийн шаардлага гэж нэрлэгдэх физик, химийн үзүүлэлт
- барааг хүлээж авах, шалгах арга, сорилын дээж авах журам
- зэрэг, дугаарын ангилал
- барааг хаяглах, савлах, тээвэрлэх, хадгалах тухай зэрэг болно.

Стандарчилал зохиогдоогүй бүтээгдэхүүнд техникийн зохицуулалт (товчоор ТЗ гэж тэмдэглэнэ) боловсруулж батлан мөрдөж болно. Техникийн зохицуулалтыг гол нь шинэ бүтээгдэхүүн, жижиг бараа, хүүхдийн тоглоом зэрэг нэр төрөл нь байнга өөрчлөгдөж байдаг бараа зэрэгт зохионо.

Тав. БАРААНЫ КОД

Бараанд байгаа үндсэн шинж тэмдгийг үсэг, тоогоор томъёолж тэмдэглэснийг барааны код гэнэ. Бараа болгон өөрийн гэсэн код буюу дугаартай

байх зарчмыг үндэслэл болгодог бөгөөд барааг бүртгэх, захиалах, үнэ тооцох, шалгах ажлыг хөнгөвчлөхөд чухал ач холбогдолтой.

Орчин үед барааны кодын хэд хэдэн систем үйлчилж байдгаас хамгийн өргөн мөрдөгдөн хэрэглэгдэж байгаа нь зураасан кодын EAN, UPC, ITF систем юм. Үүнээс EAN системийн код нь дэлхийд үйлдвэрлэгдэж байгаа барааны 80 хувийг хамарч үйлчилж байгаа юм. Энэ кодын системийн барааны дугаар нь 13 оронтой тооноос бүрддэг. Энэ 13 оронтой тооны эхний 3 орон нь тухайн барааг үйлдвэрлэгч улс орныг, дараачийн 4-5 орон нь үйлдвэрийн газрыг заах ба түүний дараачийн 4-5 тоо нь барааны тухай мэдээллийг агуулж байдаг. Харин төгсгөлийн тоо нь хяналтын тоо буюу барааны кодыг шалгахад хэрэглэгдэнэ.

Тухайн барааны кодын үнэн зөвийг дараах байдлаар шалгадаг. Үүнд:

1. Тэгш байрлалд байгаа тоонуудыг нэмэх
2. Гарсан нийлбэрийг 3-аар үржүүлэх
3. Сондгой байрлал байгаа эхний 6 тоог нэмэх
4. Дээрх үржвэр болон нийлбэрийг хооронд нь нэмэх
5. Нэгжийн орны тоог сонгож авах
6. Нэгжийн орны цифрийг 10-аас хасах
7. Гарсан тоог хяналтын тоотой харьцуулах

Хэрвээ ийнхүү бодсоны дүнд хариу тоо нь хяналтын тоотой ижил бол уг барааг хуулийн дагуу үйлдвэрлэгдсэн гэж үзнэ.

Монгол улс барааны нэгдсэн кодын системийг 2004 оноос хэрэглэж эхэлсэн бөгөөд ямар нэг барааны код нь 865 гэсэн тоогоор эхэлсэн бол ихэнхдээ тухайн бараа монгол улсад үйлдвэрлэгдсэн гэсэн санааг агуулах боловч зарим үед монголд бүртгэгдсэн болохыг илтгэж байж болно. Жишээлбэл, Оросын холбооны улсаас импортлосон бүтээгдэхүүнийг монголын хэрэглэгчдэд зориулан бага хэмжээгээр савлан борлуулж байгаа тохиолдолд “865”-аар эхэлсэн код авч болох талтай. Энэ тохиолдолд уг барааг монголд үйлдвэрлэсэн биш харин Монголоос код авч бүртгүүлсэн гэдгийг илэрхийлнэ.

Их хэмжээтэй үйлдвэрлэгдэж байгаа бараанд 13-аас цөөн тухайлбал, 8 тооноос бүрдсэн код тэмдэглэсэн байж болно.

Жижиглэн худалдаалах бараанд хэрэглэгдэх EAN болон UPC системийн зураасан кодын жишээг дараах зургаас үзэж болно.



Бөөнөөр худалдаалах үед ITF-14 болон EAN/UCC-128 системийн кодыг ашиглана. Энэ үед кодын дугаар нь 14 оронтой байх шаардлагатай бөгөөд цөөн оронтой кодын өмнө нэгээс зургаан удаа “0” нэмж дугаарладаг.

Зарим улсын барааны кодын дугаарыг хавсралтаас үзнэ үү.

Зургаа. БАРААНЫ ХАЯГ, БАГЛАА БООДОЛ, ХАДГАЛАХ НӨХЦӨЛ

Хаяг: Аль ч үйлдвэрийн газар, аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн цех, тасгаас үйлдвэрлэгдэн гарч байгаа бараа бүр хаяглагдсан байх ёстой. Хаягийг тухайн бараа үйлдвэрлэгч хийж байх үүрэгтэй. Хаяганд:

- Үйлдвэрлэгчийн нэр
- Үйлдвэрлэгчийн хаяг
- Стандартын дугаар
- Барааны нэр
- Тоо, хэмжээ
- Барааны тухай товч мэдээлэл (найрлага, хэрэглэх, арчлах арга, тэжээллэг байдал г.м)
- Үйлдвэрлэсэн болон хэрэглээний зохистой хугацаа
- Хадгалалтын онцлог нөхцөл



зэргийг тодорхойлон заана.

Барааны баглаа, боодол: Баглаа, боодол нь барааг тээвэрлэх хадгалах, худалдах явцад чанарыг хамгаалах гол ач холбогдолтой. Савлалт нь барааг ус, чийг, нар салхи зэрэг гадны нөлөөнөөс хамгаалах, барааг бүртгэж тоолох өрж хураах ажлыг эмх цэгцтэй, хөнгөн шуурхай болгоход зохих хэмжээгээр нөлөөлдөг.

Савлалт хийсэн буюу баглаж боосон байдлыг анхны ба сүүлчийн гэж ангилж үздэг. Сүүлчийн савлалт хийсэн нэг баглаа боодол барааны бохир жин нь 50 кг – аас илүүгүй байх нь хөдөлмөр зүйн шаардлагад тохирно.

Хадгалах нөхцөл: Бараа нь үйлдвэрээс хэрэглэгч хүртэл урт замыг туулдаг. Барааг хадгалах явцад байнгын ба түр зуурын гэсэн хоёр өөрчлөлт явагддаг. Энэ өөрчлөлтийг хамгийн бага байлгах зорилгоор хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөлийг тогтоон мөрдөх нь ач холбогдолтой байдаг. Үүнтэй холбоотойгоор барааг тээвэрлэх хөсгийн төрлийг зөв тогтоох, тухайн нөхцөлийг хангасан агуулах, тоног төхөөрөмжтэй байх нь чухал. Хадгалалт, тээвэрлэлтийн гол нөхцөлд:

- агаарын харьцангуй чийгшил
- температур
- гэрэлтүүлэг
- эрүүл ахуй, ариун цэврийн үзүүлэлтүүд хамаарна.

Зарим гол нэр төрлийн барааны хадгалалтын нөхцөлийн талаар хавсралтаас танилцаж болно.

Долоо. БАРААНЫ ТЭМДЭГТҮҮД

Төрөл бүрийн барааны шинж чанар, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, арчлах болон хэрэглэх арга ажиллагааны онцлог нөхцөлийг зургаар болон бичиглэлээр нийтэд ойлгомжтой хэлбэрээр илэрхийлснийг барааны тэмдэгт гэж ойлгоно.

Барааны тэмдэгтүүд нь хэрэглэгч улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг билээ. Сүүлийн үед байгалийн гаралтай цэвэр бүтээгдэхүүн, байгал орчинд сөрөг нөлөөгүй болох талаас нь анхааруулсан тэмдэгтүүд олноор гарч байна. Мөн барааны сав баглааг эргүүлэн ашиглахад хэрэглэгч хэрхэх талаар зөвлөсөн тэмдэгтүүд ч гарах боллоо.

Бараа бүтээгдэхүүн болон тэдгээртэй хэрхэн харьцах ажиллагааг тодорхойлсон зарим тэмдэгтийн загваруудыг хавсаргав.

Карат гэж юу вэ?

Алт мөнгөн эдлэлийн стандартын шаардлагыг хангасан тухай тэмдэглэл бичигдсэн байдаг Олон улсын хэмжээнд дараах хоёр төрлийн тэмдэглэгээг өргөн хэргэлдэг/ сорьц, carat /

8.1. Худалдааны газар, цэг салбарын ангилал

Үйлдвэрлэгдсэн барааг хэрэглэгчдэд худалдаалах ажиллагаа нь маркетингийн бүтцийн салшгүй чухал хэсэг бөгөөд эцсийн үр дүнг тодорхойлж байдгаараа хамгийн ач холбогдолтой ажиллагаа юм.

Худалдааны зохион байгуулалт, технологи бол өргөн хэрэглээний барааг худалдан борлуулах ажиллагаатай холбогдсон үйл явцыг судалдаг салбар шинжлэх ухаан юм.

Уг шинжлэх ухааны тодорхойлсноор худалдаа нь бөөний ба жижиглэн гэсэн үндсэн 2 хэлбэрээс тогтоно.

Худалдааны зохион байгуулалтын асуудалд арилжааны үйл ажиллагаа, цэг салбарт тавигдах шаардлага, барааны баглаа боодол, реклам сурталчилгааны гэх мэт асуудлууд хамаарна.

Худалдааны газар, үйлчилгээний цэг салбарыг:

- **Бөөний худалдааны**



- **Жижиглэн худалдаалах гэж хуваадаг.**



Жижиглэн худалдааны цэг салбарыг суурин ба нүүдлийн гэж ангилна.

- **Суурин** худалдааны цэг салбарт байршуулсан газраа тогтмол оршиж, худалдаа үйлчилгээ явуулдаг дэлгүүр, мухлаг, асар, худалдааны автомат зэрэг цэгүүд хамрагдана.
- **Нүүдлийн** худалдааны цэг салбарыг худалдаа, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай жижиг суурин газрууд болон айл өрхүүдэд үйлчлэхэд зориулан зохион байгуулах нь зохимжтой байдаг. Энэ төрөлд авто дэлгүүр, мотоцикл, тэргэнцэр, дугуй, ердийн хөсөг, ганзагын худалдаа багтдаг.

Жижиглэн худалдааны цэг салбаруудын зохион байгуулалтад тавигдах шаардлагыг “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага” MNS 5021-1:2019 стандартад дор дурдсанаар тодорхойлсон байдаг.

3. ХУДАЛДААНЫ СТАНДАРТ

3.1. Худалдааны газрын нэр, томьёо

БАРААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, БАРААНЫ АНГИЛАЛ

Бараа гэж хүний хөдөлмөрөөр бүтсэн, хүний аль нэгэн хэрэгцээг хангах зориулалттай бөгөөд цаашид арилжаалагдахаар үйлдвэрлэгдсэн эд юмсыг хэлнэ.

Өөрөөр хэлбэл зах зээл дээр эрэл сурал болж байгаа, хэрэглэгчид эдэлж хэрэглэх гэсэн хүсэл сонирхлыг төрүүлэгч зүйлийг бараа гэж үзэж болох юм.

Үйлвэрлэхэд ашигласан түүхий эд, материал, үйлдвэрлэлтийн арга технологи, хэрэглээний зориулалт болон бусад шинж чанараас хамааран бараа бүр өөрийн өвөрмөц онцлогтой байдаг. Жишээ нь : Гутал хувцас, цай, гурил, будаа зэрэг нь өмсөж эдлэх, идэж уух хэрэгцээг хангаж байхад, ээмэг, бөгж, оо, энгэсэг нь гоёж гоодох хэрэгцээг хангаж байдаг.

Барааны хэрэглээ хангаж байгаа байдлыг “Бараа судлал”-ын шинжлэх ухаан судалдаг.

Бараа судлалын зорилго нь:

- Барааны хэрэглээний шинж чанар
- Ангилал, нэр төрөл, зэрэг дугаар
- Барааны чанарыг тодорхойлох арга
- Барааны хаяглалт, савлалт, тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл зэргийг судлах
- Барааны хэрэглээ хангах чадварыг тогтоон сайжруулж, боловсронгуй болгоход оршино.



Барааны ерөнхий ангилал:

Барааг хүний хэрэгцээг хангаж байгаа байдлаар нь ерөнхий хоёр хэсэгт хуваадаг. Үүнд:

- Хүнсний бараа
- Хүнсний биш бараа

Хүний бие организмын дотоод хэрэгцээг хангаж, эд эсийн өсөлт, нөхөн төлжилтийг хангаж энергийн эх үүсвэр болж байдаг зүйлийг хүнсний бараа гэх ба харин гадаад буюу бусад хэрэгцээг хангадаг эд юмсыг хүнсний биш бараа гэж үздэг.

1.1. Хүнсний бараа

Хүнсний бараа нь хүний тодорхой хэрэгцээг зориулалтынхаа дагуу хир зэрэг



хангаж байгаагаар түүний ач холбогдол тодорхойлогдоно. Хүнсний бараа нь:

- Тэжээллэг шинж чанартай,
- Илчлэг үүсгэдэг,
- Биологийн үнэт чанартай,
- Физиологийн ач холбогдолтой,
- Үнэр, амт төгс байх,
- Бие организмд хор нөлөөгүй байх ёстой.



Дээрх шаардлагууд нь хүнсэнд агуулагдах төрөл бүрийн бодисын хэмжээнээс шалтгаалан бараа бүрт харилцан адилгүй байдаг.

Хүнсний зүйлийг бүрдүүлдэг бодисуудад ус, эрдэс бодис, нүүрс ус, өөх тос, уураг, хүнсний хүчил, витамин, фермент, будагч бодис зэрэг хамаарна.

Хүнсний барааг хадгалах, тээвэрлэх ажиллагааг тэсвэрлэх байдлаар нь тэсвэртэй, түргэн гэмтэгч гэж ангилна. Түргэн гэмтэгч бараанд сүү, мах, загас, өндөг, хүнсний ногоо, жимс жимсгэнэ гэх мэт орно.

Хүнсний барааг түгээмэл болон онцлог шинжээр нь:

- Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ
- Үр тариа, түүгээр боловсруусан бүтээгдэхүүн
- Саахар, цардуул, зөгийн бал
- Чихэр, нарийн боов
- Ааг амттан
- Сүү, сүүн бүтээгдэхүүн
- Мах, махан бүтээгдэхүүн
- Өөх, тос
- Өндөг, түүгээр боловсруулсан бүтээгдэхүүн
- Загас гэсэн бүлгүүд болгон ангилдаг.

1.2. Хүнсний биш бараа

Хүнсний биш бараа нь хүний хэрэгцээтэй уялдан харьцангуй олон нэр төрөлтэй байх бөгөөд түүнд тавигдах шаардлагууд нь хэрэглээнээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. Өөрөөр хэлбэл нийтлэг шинж харьцангуй багатай байдгаараа хүнсний бараанаас ялгаатай байдаг.

Хүнсний биш барааг түүний зориулалт, үйлдвэрлэсэн арга, химийн бүрэлдэхүүн, түүхий эд материал зэрэг шинж тэмдгээр нь 20 бүлэг болгож хуваадаг.

- Хуванцар бараа (хуванцраар бэлтгэгдсэн бараа)
- Химийн бараа (гэр ахуйн зориулалт бүхий химийн бараа, цавуу,

өнгөлөх, тослох, гэрэлтүүлэх материал, аж ахуйн саван, угаагч бодис, барилгын будаг, лакны зүйл)

- Шил, шаазан бараа (шилэн болон шаазан, шаварлаг сав суулга бусад эдлэлүүд)
- Барилгын материал (шил, шаазан, төмөрлөг, модон хуванцар материал, будаг, лак, замазка гэх мэт)
- Мебель бараа
- Аж ахуйн төмөрлөг бараа (сав суулга, хөдөө аж ахуйн ба гэр аж ахуйн багаж хэрэгслүүд, хаалга цонхны хэрэглэл гэх мэт)
- Аж ахуйн цахилгаан бараа (цахилгааны утас, холбох залгуур, индүү плитка, тоос сорогч, угаагч, хөргөгч, оёдлын машин гэх мэт)
- Нэхмэл бараа (ноосон, торгон, хөвөн, олсон нэхмэл тэдгээрээс бэлтгэгдсэн ширхгийн эдлэлүүд)
- Сүлжмэл бараа (оймсны зүйл, бээлий, дотуур хувцас гэх мэт)
- Оёмол бараа (малгайн зүйл, бүх төрлийн хувцас)
- Гутлын зүйл
- Суран тоноглолын зүйл (эмээл, хазаар, ногт, морины тоног)
- Ангийн үсэн эдлэл (төрөл бүрийн ан амьтны арьс, үсээр үйлдвэрлэж бэлтгэгдсэн эдлэлүүд)
- Зөөлөн үст эдлэл (үслэг эдлэлийн үйлдвэрт ашиглагдаж буй гэрийн тэжээмэл амьтдын арьс, үсээр үйлдвэрлэж бэлтгэгдсэн эдлэлүүд)
- Жижиг бараа (хуванцар, арьс шир, төмөрлөг, модон бараа, толины зүйл)
- Цаг, гоёл чимэглэлийн зүйл (ээмэг, бөгж, хүзүүний зүүлт, энгэрийн зүүлт, бүх төрлийн цаг)
- Үнэртэн гоо сайхны бараа (үнэрт ус, сүрчиг, одеколон, оо, энгэсэг, нүүрний тос, уруулын будаг, хумсны лак, үсний будаг гэх мэт)
- Соёлын бараа (Сургуулийн ба бичгийн хэрэглэл, гэрэл зураг, радио, хөгжмийн бараа, хүүхдийн тоглоом, биеийн тамирын ба ан агнуурын зориулалттай хэрэгсэл)
- Ном хэвлэл
- Техникийн бараа (тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж)

Хүнсний биш барааны бүлгүүдийг цаашид дэд бүлэг болон нэр төрлүүдээр задлан үзэж болно. Тухайлбал, оёмол бараа гэсэн бүлэг нь малгайн зүйл, бэлэн хувцас, ор дэрний хэрэглэл гэж, бэлэн хувцас нь дотроо гадуур, дотуур өмсөх гэж, гадуур хувцас нь пальто, костюм гэж нарийвчлан ангилагдана. Мөн костюмыг хийц загвар, өнгө, өмсгөл хэмжээ, улирлын байдал, хэрэглэгчийн нас, хүйсийг харгалзан нэр төрлүүдэд хувааж үзнэ.

Барааны нэрсийн жагсаалтыг нэр төрөл гэнэ. Нэр төрөл нь худалдааны ба үйлдвэрийн гэж хоёр янз байдаг. Хүн амын эрэлт хүсэлтийг үндэслэн, худалдааны

цэг салбаруудад худалдаалагдаж байгаа барааны нэрсийн жагсаалтыг худалдааны, тухайн үйлдвэр, фабрик, завод, тасаг, цехээс үйлдвэрлэн гаргаж байгаа барааны нэрсийн жагсаалтыг үйлдвэрийн нэр төрөл гэнэ.

Хоёр. БАРААНЫ ШИНЖ

Нэг барааны нөгөөгөөс ялгагдах шинж тэмдгийг барааны шинж гэнэ. Бараа болгон өөрийн гэсэн өвөрмөц шинжтэй байдаг. Барааны шинж нь үйлвэрлэсэн түүхий эдийн шинж, үйлдвэрлэлийн технолог ажиллагаанаас голлон хамаардаг.

Барааны шинжийг:

- Химийн
- Физикийн
- Микробиологийн
- Эдэлгээнд тэсвэрлэх
- Нэтрүүлэх чадварын
- Эрүүл ахуйн
- Гоо сайхны гэж хувааж болно.

Гурав. БАРААНЫ ЧАНАР

Барааг зориулалтын дагуу хэрэглэх үед илрэн гарах хэрэглээний ашигтай шинжүүдийн нийлбэр цогцыг барааны чанар гэнэ. Барааны чанар нь түүний бат бөх, хүнд хөнгөн (хувийн жин), нягт сийрэг, дуу шингээх, ус чийг нэвтрүүлэх чадвар, цахилгаан дамжуулах байдал, төрөл бүрийн химийн бодистой харилцан үйлчлэлд орох байдал, тэжээллэг болон бусад бодисын агууламж зэргээс шалтгаалдаг.

Барааны чанарыг шалгах, шинжлэх аргууд

Барааны чанарыг шалгаж шинжлэн тодорхойлох аргыг энгийн ба лабораторийн гэж ангилна.

Мэдрэхүйн эрхтний туслалцаатайгаар барааны чанарыг тодорхойлж байгааг энгийн арга, тусгай зориулалтын тоног төхөөрөмж, химийн урвалжууд ашиглан барааны хими, физик, биохими, микробиологийн үзүүлэлтүүдийг тодорхойлохыг лабораторийн арга гэнэ.

Энгийн аргаар тодорхойлохдоо ижил төрлийн өөр бараатай буюу чанарын талаар тавигдвал зохих шаардлагыг тодорхойлсон шалгуур үзүүлэлттэй харьцуулан жиших аргыг хэрэглэж болдог.

3.2. Жижиглэн худалдааны газрын стандарт

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.080.30



Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага	MNS 5021-1:2019
Retail trade and its service. General requirements	MNS 5021:2007-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн С/33 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

1.1. Энэхүү стандартаар жижиглэн худалдааны газар, түүнд тавих ерөнхий болон нэмэлт шаардлагыг тогтооно.

1.2. Энэ стандарт нь дэлгүүрийн бус жижиглэн худалдааны газарт хамаарахгүй.

2. Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах стандарт, баримт бичгээс эш татсан бөгөөд эдгээрт өөрчлөлт, нэмэлт орсон тохиолдолд албан ёсны материалаас эш татна. Үүнд:

MNS 6506:2015 Худалдааны үйлчилгээ. Худалдааны газрын ангилал, нэр томъёо

MNS 5364:2011, Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага

ГОСТ Р 51773-2009, Услуги торговли, Классификация предприятий

MNS CAC RCP20:2007 Хүнсний олон улсын худалдаанд баримтлах ёс зүй

MNS CAC 1:2003, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчмын дадлын олон улсын зөвлөмжийн дүрэм

MNS CAC GL 32: 2017, Органик хүнсийг боловсруулах, үйлдвэрлэх, шошголох, худалдаалахад баримтлах арга зүйн удирдамж

MNS 6648:2016, Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын

MNS:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын нэр томъёо, тодорхойлолт

БнБД 2.03.12-87, Үйлдвэрийн барилга, байгууламжийн төлөвлөлтийн эрүүл ахуйн норм ба дүрэм.

MNS 4990:2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага

MNS 4996:2000, Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага

MNS 5390:2004, Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага

MNS 6423:2013, Монгол улсын барилга орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, ерөнхий шаардлага

MNS 5005:2015, Төлбөрийн баримт хэвлэх төхөөрөмж

MNS 6529:2015, Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримт

MNS 5343:2011, Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэх

MNS 5346:2017, Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ


3. Жижиглэн худалдааны газрын ангилал

3.1 Худалдааны газрыг үйл ажиллагаагаар нь:

3.1.1 дэлгүүрийн худалдаа

3.1.2 дэлгүүрийн бус худалдаа

3.2 Хүчин чадал, худалдааны талбайн хэмжээнээс хамааруулан 1 дүгээр хүснэгтэд заасан байдлаар тус тус ангилна.



1-р хүснэгт – Жижиглэн худалдааны газрын хүчин чадал, худалдааны талбайн хэмжээнээс хамааруулсан ангилал

№	Ангилал	Дэлгүүрийн төрөл	Хүчин чадлын хэмжээ м.кв		
			Нийслэл	Аймгийн төв	Сум, баг
1	Том	Хайпермаркет	>2001	>1001	-
2	Дунд	Супермаркет	>501	301-1000	>201
3	Багавтар	Минимаркет	101-500	101-300	101-200
4		Ая тухтай дэлгүүр /конвиниенс стоор/	>80	>60	>60
5	Бага	Хүнсний дэлгүүр	51-100	41-100	41-100
6		ШТС-ын дэргэдэх дэлгүүр	51-100	41-100	41-100
7		Төрөлжсөн барааны дэлгүүр	51-100	41-100	41-100
8		Мухлаг	20-50	20-40	20-40

4. Нэр томьёо, тодорхойлолт

4.1. жижиглэн худалдаа

хувийн болон гэр бүлийн эсвэл бусад хэрэгцээнд зориулсан барааг эцсийн хэрэглэгчдэд худалдан борлуулах үйл ажиллагаа

4.2. дэлгүүрийн худалдаа

батлагдсан зураг төслөөр баригдсан, суурин байгууламж бүхий стандартад нийцсэн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, мэргэжлийн хүний нөөцөөр ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан тав тухтай орчинд худалдан авагчдад бараа, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах үйл ажиллагаа

4.2.1. хайпермаркет

хүнсний болон хүнсний бус өргөн хэрэглээний барааг төрөлжсөн тасгуудаар өөртөө үйлчлэх хэлбэрээр худалдах дэлгүүр

4.2.2. супермаркет

хүнсний болон ахуйн өргөн хэрэглээний барааг төрөлжсөн тасгуудаар өөртөө үйлчлэх хэлбэрээр худалдах дэлгүүр

4.2.3. минимаркет

байнгын эрэлттэй хүнсний болон хүнсний бус барааг өөртөө үйлчлэх хэлбэрээр худалдах дэлгүүр

4.2.4. ая тухтай дэлгүүр

өдөр тутмын эрэлттэй хүнсний болон ахуйн хэрэглээний барааг өөртөө үйлчлэх хэлбэрээр худалдах, энэ стандартын 4.30-т заасан шаардлагыг хангасан түргэн хоолны үйлчилгээний хэсэгтэй дэлгүүр

Тайлбар: Түргэн хоолны үйлчилгээний хэсгийн талбайн хэмжээ нь худалдааны танхимын талбайн 20 хувиас хэтрэхгүй байна.

4.2.5. хүнсний дэлгүүр

байнгын эрэлттэй хүнсний барааг уламжлалт болон өөртөө үйлчлэх хэлбэрээр худалдах дэлгүүр

4.2.6. шатахуун түгээх станцын дэргэдэх дэлгүүр

өдөр тутмын эрэлттэй хүнсний болон ахуйн хэрэглээний барааг автомашины тос тосолгооны материал, сэлбэг хэрэгслээс тусгаарласан худалдааны танхимаар төрөлжүүлэн худалдах дэлгүүр

4.2.7. мухлаг

хязгаарлагдмал нэр төрлийн хүнсний болон ахуйн жижиг барааг худалдах нэг худалдагчийн ажлын байр бүхий дэлгүүр

4.3. төрөлжсөн барааны дэлгүүр

тодорхой бүлгийн барааг худалдах дэлгүүр

4.4. аутлет

тодорхой үйлдвэрлэгчийн үлдэгдэл нөөц ихтэй барааг хямд үнээр худалдах дэлгүүр

4.5. бутик

чамин загварын хязгаарлагдмал эрэлттэй барааг худалдах дэлгүүр

4.6. дэлгүүрийн талбай

худалдааны болон худалдааны бус талбайн нийлбэр

4.7. худалдааны талбай

худалдааны танхим, лангуу тавиур, тоног төхөөрөмж байршуулсан талбай, худалдан авагчийн зорчих, үйлчлүүлэх хэсэг, тооцооны цэг, худалдагчийн ажлын байрны талбайн нийлбэр

4.8. худалдааны бус талбай

бараа ачих буулгах, хүлээн авах, худалдаанд бэлтгэх, хадгалах, хөргөх камер болон захиргаа, аж ахуй, техникийн өрөө, ариун цэврийн өрөө болон бусад туслах өрөөний талбайн нийлбэр

4.9. бараа

эдийн засгийн ач холбогдол, үнэ бүхий худалдаж, солилцож болох эд зүйлс

4.10. барааны нэр төрөл

хэрэглээний зориулалт, шинж чанараараа нэг бүлэгт багтдаг бараа

4.11. өргөн хэрэглээний бараа

хэрэглэгчийн бүх төрлийн хэрэгцээг хангах өргөн нэр төрлийн хүнс, ахуйн хэрэглээний болон бэлэн хувцас, гэрийн тавилга, цахилгаан техникийн хэрэгсэл, барилгын материал, аяны хэрэгсэл, албан бичиг хэргийн болон ном соёлын бараа гэх мэт бүх бүлгийн бараа

4.12. өдөр тутмын эрэлттэй бараа

хэрэглэгчийн хувийн болон ахуйн хэрэгцээг хангах өдөр тутмын эрэлттэй бараа бүтээгдэхүүн

4.13. хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүн

физик, химийн шинж чанар хурдан өөрчлөгддөг, хадгалалтын онцгой горим шаарддаг хүнсний бүх төрлийн бүтээгдэхүүн

4.14. үнэ

барааны нэр төрөл, тоо хэмжээ, чанарт тохирсон мөнгөн төлбөрийн хэмжээ

4.15. татварын нэгдсэн систем

бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний төлбөрийн баримтын мэдээллийг цуглуулах, боловсруулах, тайлагнах үйлдэлтэй нэгдсэн систем

4.16. бүртгэлийн машин

албан татвар суутган төлөгчийн борлуулалтыг төлбөрийн баримтад заагдсаны дагуу бүртгэж, бүртгэлийн мэдээллийг төлбөр тооцооны бүртгэлийн системд дамжуулах тусгай зориулалт бүхий кассын машин, түүний салшгүй хэсэг болсон ПОС терминал буюу түүнтэй адилтгах програм хангамж бүхий тоног төхөөрөмж

4.17. төлбөрийн баримт /НӨАТ-ын баримт/

татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын MNS 6529:2015

стандартыг хангасан нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээг худалдан авсныг нотлох хяналтын баримт

4.18. худалдааны технологи

барааг дэлгүүрт хүлээн авах, хадгалах, жижиглэн савлах, байршуулах, сурталчлах, таниулах, худалдан авагчдад мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, захиалга хүлээн авах, төлбөр тооцоо хийх, худалдан авагчид олгох цогц ажилбарууд

4.19. худалдан авагчдад үйлчлэх технологи

угтах, барааг худалдан борлуулах, төлбөр тооцоо хийх, үдэх үйлчилгээний цогц ажилбарууд

4.20. планограмм

барааг бүлэглэн ангилж төрөлжүүлэн өрөлт байршлын зохистой харьцааны загвар боловсруулах технологи

4.21. категори бодлого

ижил төстэй шинж чанартай эсвэл нэг нэр төрлийн барааг бүрдүүлэх, байршуулах бодлого

4.22. худалдагч

барааг худалдан авагчдад сурталчлах, таниулах, худалдах, төлбөр тооцоо хийх үүрэгтэй худалдааны газрын ажилтан

4.23. худалдааны зөвлөх

барааг сурталчлах, таниулах, худалдан авагчдад мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх цогц үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй худалдааны газрын мэргэшсэн ажилтан

4.24. бараа түгээгч, жолооч

барааг захиалгын дагуу худалдан авагчдад хүргэх, хүлээлгэн өгөх, угсарч суурилуулах зэрэг нэмэлт үйлчилгээ үзүүлэх дэлгүүрийн болон дэлгүүрийн бус худалдааны газрын ажилтан

4.25. бараа ачигч, буулгагч

барааг тээврийн хэрэгслээс гар аргаар болон зориулалтын төхөөрөмжөөр буулгах, ачих, агуулахад шилжүүлж зөөвөрлөх худалдааны газрын туслах ажилтан

4.26. зориулалтын тээврийн хэрэгсэл

барааны шинж чанар, чанар байдлыг алдагдуулахгүй мөн гэмтэж муудахаас хамгаалах зориулалтын хөргөөх, хөлдөөх, чийглэх нэмэлт төхөөрөмжөөр тоногдсон битүү тэвш бүхий тээврийн хэрэгсэл

4.27. дэлгүүрийн нэмэлт үйлчилгээ

барааг гэрт нь хүргэх, угсарч суурилуулах, засварлах, сэлбэг эд ангийг нийлүүлэх гэх мэт худалдан авагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулж буй үйл ажиллагаа

4.28. борлуулалтын дараах үйлчилгээ

техникийн болон хэрэглээ, арчилгаа, тордолтын онцгой горим шаарддаг бараа, бүтээгдэхүүний талаар худалдан авагчдад нэмэлт зөвлөгөө өгөх, засвар

үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ

4.29. худалдааны газрын нэмэлт үйлчилгээ

шуудан, харилцаа холбоо, банк, санхүү, төлбөр тооцооны үйлчилгээ, ахуйн үйлчилгээний цэг гэх мэт

4.30. түргэн хоолны үйлчилгээний хэсэг

хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг тодорхой температурт халаах, халууныг тогтмол температурт барих, хадгалах, ердийн болон автомат ажиллагаатай төхөөрөмж, ширээ, сандлаар тоногдсон, Wi-fi орчин бүхий хэсэг

5. Ерөнхий шаардлага

5.1 Барилга, байгууламж, гадаад, дотоод орчинд тавих шаардлага

5.1.1 Мэргэжлийн байгууллагын зураг төслийн дагуу худалдаа, үйлчилгээний зориулалтаар баригдсан байна.

5.1.2 Төвлөрсөн системд холбогдоогүй тохиолдолд ариун цэврийн байгууламжийг хэсэгчилсэн инженерийн дэд бүтэц бүхий бохир ус цэвэрлэж болохуйцаар шийдвэрлэсэн байна.

5.1.3 Төвийн дулаанд холбогдоогүй тохиолдолд халаалтыг цахилгаанаар болон бусад эх үүсвэр ашигпан шийдсэн, эрчим хүчний хэмнэлттэй, утаагүй хэрэглээг бий болгосон байна.

5.1.4 Барилга байгууламжийн төлөвлөлт шийдэл нь үйлчилгээний технологийн урсгалыг хангасан байна.

5.1.5 Цахилгаан эрчим хүчийг төвийн эх үүсвэрээс болон нар салхины эх үүсвэрээр шийдсэн байна.

5.1.6 Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээг хангахаар төлөвлөгдсөн, тэргэнцэрийн зориулалтын зам, тохижилттой байна.

5.1.7 Хаягийг монгол хэл /кирилл үсэг/-ээр бичих бөгөөд гадаад хэлээр бичих тохиолдолд монгол бичвэрийн доод талд эсхүл хойно 2 дахин бага хэмжээгээр бичнэ.

5.1.8 Хаяг нь гэрэлтүүлэгтэй, фасадны талбайн 20 хувиас ихгүй байна.

5.1.9 MNS 6423, Монгол улсын барилга орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, ерөнхий шаардлага стандартад нийцсэн, бичлэгийг 30 хоног хадгалах хүчин чадалтай телекамерын системээр тоноглогдсон байна.

5.1.10 Нийт талбайн 30 хувиас доошгүй талбайд ногоон байгууламж, автомашины зогсоолыг төлөвлөсөн байна.

5.1.11 Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээллийн самбарыг байршуулан гадна орчны 50 м хүртэлх талбайг гэрэлтүүлэх гэрэлтүүлэгтэй байна.

5.1.11 Хог хаягдлыг ангилан ялгаж хаях хогийн савыг орох хаалганы гадна, дотор талд байрлуулсан байна.

5.1.12 Бараа хүлээн авах, буулгах тавцан, тэмдэглэгээ бүхий цардсан зам, талбайтай байна.

5.2 Худалдааны талбайн төлөвлөлтөд тавих шаардлага

5.2.1 Ажлын байрны дотоод орчны төлөвлөлтийг худалдаа, үйлчилгээний технологийн дагуу зохион байгуулсан байна.

5.2.2 Худалдагчийн ажлын байранд баруун тийш эргэх урсгал, хөдөлгөөнд нийцүүлэн тавилга, төхөөрөмжийг байршуулсан байна.

5.2.3 Худалдааны танхимын нэвтрэх бүсэд орох гарах урсгалыг зохицуулсан чиглүүлэгчийг байршуулсан байна.

5.2.4 Үүдний хэсэгт худалдан авагчийг урсгалыг чөлөөтэй байхаар 4 м²-аас багагүй талбайг төлөвлөж зохион байгуулсан байна.

5.3 Худалдааны бус талбайн төлөвлөлтөд тавих шаардлага

5.3.1 Үйлчилгээний хүчин чадлаас хамаарч бүтээгдэхүүн хадгалах төрөлжсөн агуулахтай байна.

5.3.2 Хүнсний бүтээгдэхүүнийг жижиглэн савлах, засалт, тордолт хийх худалдаанд бэлтгэх өрөөтэй байна. ТАЙЛБАР: Мухлагт хамаарахгүй байж болно.

5.3.3 Ажиллагсдын ахуй хангамж, ариун цэврийн өрөөтэй байна.

5.3.4 Үйлчлүүлэгчдэд зориулсан ариун цэврийн өрөө, гар угаах хэрэгсэлтэй байх бөгөөд хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тохижилттой байна.

ТАЙЛБАР: Мухлагт хамаарахгүй байж болно.

5.3.5 Худалдааны газрын бүдүүвч зураг, мэдээллийн самбартай байна.

5.4 Хүнсний худалдааны тоног төхөөрөмжид тавих шаардлага

5.4.1 Барааг зориулалтын сагс болон ачааны түрдэг тэргэнцэр, ачих буулгах, зөөвөрлөх, худалдаанд бэлтгэх, жижиглэн савлах, хадгалах, зориулалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, температурын тохируулга бүхий хөргөх хөлдөөх төхөөрөмжтэй байна

5.4.2 Бараа байрлуулах тавиурын өндрийн хэмжээ 180 см-ээс ихгүй, шалнаас 20 см-аас багагүй өндөрт байна.

5.4.3 Лангууны өндөр 75-85 см, өргөн 50 см-аас доошгүй байна.

5.4.4 MNS 5005:2015, Татварын нэгдсэн системд холбогдон ажиллах төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага стандартын шаардлага хангасан төлбөрийн баримтыг хэвлэх төхөөрөмжтэй байна.

5.4.5 Агуулах болон худалдааны танхимд орчны чийг, температур хэмжигч байрлуулан бүртгэл хөтөлнө.

5.4.6 Барааны нэр төрөлд тохирсон төрөл бүрийн лангуу, тавиур, өлгүүртэй байна.

5.4.7 Хэмжих хэрэгсэл нь баталгаажуулалт хийгдсэн байна.

5.5 Худалдааны газрын технологи ажилбарт тавих шаардлага

5.5.1 Хүнсний бараа худалдах технологи ажиллагаанд эрүүл ахуйн зохистой дадлыг мөрдөнө.

5.5.2 Худалдааны талбайд тасгуудыг төрөлжүүлэн оновчтой төлөвлөж байршуулсан байна.

5.5.3 Худалдан авагч хайж байгаа зүйлээ хялбар олж авахад зориулан бүтээгдэхүүнийг бүлэг, дэд бүлгээр ангилан, технологийн дагуу, хөрш барааны зарчим баримтлан өрж байршуулсан байна.

5.5.4 Бараа бүтээгдэхүүний нэгжийн үнийг тод гаргацтай бичсэн үнийн хаягийг бүтээгдэхүүн бүрт байршуулсан байна.

5.5.5 Аюултай болон ахуйн химийн барааг хүнсний барааны чанарт нөлөөлөхгүйгээр тусгай тасгаар худалдаална.

5.5.6 Шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээний дүгнэлтийн баримтыг ил байршуулсан байна.

5.5.7 Гарал үүсэл, чанар, аюулгүй байдлын гэрчилгээтэй стандартын шаардлага хангасан барааг хүлээн авна.

5.5.8 Барааны код, зураасан кодны стандарт хангасан хаяг шошго, сав баглаа боодлын зөрчилгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн худалдаална.

5.5.9 Бүтээгдэхүүний эрүүл мэндийн хор нөлөөний тухай анхааруулга, сэрэмжлүүлэг, аюулгүй ажиллагааны заавар, хүнсний нэмэлтийн тайлбар, бараа бүтээгдэхүүний олон улсын таних тэмдэг, арчилгааны таних тэмдэг, чанарын тохирлын тэмдэг, цахилгаан барааны ЕС тэмдэг зэрэг мэдээллийг үнэн зөв, ил тод мэдээлнэ.

5.5.10 Бараа бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх горим нөхцөл, шаардлагыг хангасан байна.

5.5.11 Дотоод хяналтын журмыг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж батлан мөрдөж ажиллана.



5.6 Худалдан авагчдад үйлчлэх технологи ажилбарт тавих шаардлага

5.6.1 Бараа бүтээгдэхүүний хэрэглээ, зориулалт, ашиглалт, хадгалалтын нөхцлийн талаар худалдан авагчдад зөвлөгөө, үнэн зөв мэдээлэл өгнө.

5.6.2 Худалдан авсан бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоог үнэн зөв гүйцэтгэн, төлбөрийн баримт, НӨАТ-ын баримт олгон, барааг савлаж, гардуулж үйлчилнэ.

5.6.3 Худалдан авсан бараанд бүтээгдэхүүний онцлог, нэр төрлөөс хамааран чанарын баталгаа гаргаж үйлчлэнэ.

5.6.4 Хэрэглэгчийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх ажилтантай байна.

5.6.5 Бараа буцаах, санал гомдол хүлээн авах хэрэглэгчийн үйлчилгээний төвийг ажиллуулах болон холбогдох дүрэм журмыг ил тод мэдээлнэ.

5.6.6 Орох хаалганы гадна хэсэгт үйлчилгээний цагийн хуваарийг үйлчлүүлэгчдэд харагдахуйцаар байршуулсан байна.

5.7 Ажлын байрны эрүүл ахуйд тавих шаардлага

5.7.1 Худалдаа үйлчилгээг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, үйлчлүүлэгчдийн амь нас, эрүүл мэндэд харшлахгүй, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангасан барилга байгууламжид зохион байгуулсан байна.

5.7.2 Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөнө.

5.7.3 Ажлын байрны гэрэлтүүлэг дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.8.3.1 худалдааны танхим - 540 лк

5.8.3.2 агуулах, савлагааны өрөө - 220 лк*

5.8.3.3 корридор, хонгилынхэсэг - 110 лк

ТАЙЛБАР: *Агуулахгүй мухлагт хамаарахгүй.

5.7.4 Худалдааны барилга байгууламж нь байгалийн, механик болон автомат агааржуулалтын системтэй байна.

5.8 Галын аюулгүй байдалд тавих шаардлага

5.8.1 Барилга байгууламжийн галын аюулгүйн дүрэмд тавих шаардлагыг хангасан, хамгаалалтын систем дохиололтой, гал унтраах хэрэглэлтэй, гал тэсвэршилтийн I-IV зэрэглэлтэй байна.

5.8.2 MNS 5390:2004, Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлагастандартын дагуу барилга байгууламж нь онцгой байдлын үед аврах шат, аваарын хаалга, гарц, онцгой байдлын үед авах арга хэмжээний зааврууд, хэрэглэгчдийг чөлөөтэй чиглүүлэх мэдээлэл бүхий тэмдэглэгээг хэрэглэгчдэд харагдахуйц байдлаар байрлуулсан байна.

5.8.3 Техник, тоног төхөөрөмж, цахилгааны монтажийг галын аюулгүйн болон техник ашиглалтын дүрмийн дагуу угсарсан байна.

5.9 Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага

5.9.1 Хүнсний түүхий эд, бэлэн бүтээгдэхүүнийг тохируулга бүхий зориулалтын хөргөх, хөлдөөх тоног төхөөрөмжид тус тусад нь ангилж хадгална.

5.9.2 Худалдааны багаж хэрэгслүүд /хутга, хайч, хавчаар, хутгуур, жин, түрдэг тэрэг, сагс г.м/-ийг зааврын дагуу тогтмол угааж, халдваргүйжүүлж, цэвэр орчин нөхцөлд хадгална.

5.9.3 Худалдааны тоног төхөөрөмж, сав суулгыг тусдаа цэгт угааж халдваргүйжүүлэн дахин бохирдохгүй нөхцөлд хадгална.

5.9.4 Худалдааны газрын барилга байгууламж, талбай, тоног төхөөрөмжийн ариутгал, халдваргүйтгэл, хортон шавьж, мэрэгч устгалыг тогтоосон хугацаанд мэргэжлийн байгууллагаар хийлгэж бүртгэл хөтөлнө.

5.9.5 Түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах хөргөгч, хөргүүрийн температурыг өдөр бүр хэмжиж, тэмдэглэл хөтөлнө.

5.9.6 Техник, тоног төхөөрөмж бүр ашиглалтын гэрчилгээтэй, засвар үйлчилгээ хийсэн бүртгэл хөтөлнө.

5.10 Худалдааны ажилтны ур чадвар, мэдлэг, боловсролд тавих шаардлага

5.10.1 Худалдааны зөвлөх, худалдагч, борлуулагч нь мэргэжлийн үнэмлэхтэй, шаардлагатай бол гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байна.

5.10.2 Жолооч, түгээгч, агуулахын ажилтан, бараа ачигч, буулгагч нь мэргэшүүлэх түр сургалтад хамрагдсан байна.

5.10.3 Худалдааны газрын гэрээт ажилтан буюу цагийн ажилтан нь мэргэшүүлэх түр сургалтад хамрагдсан байна.

5.10.4 Худалдаа, үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг судалж, мөрдөж ажиллана.

5.11 Ажиллагсдын эрүүл ахуй, аюулгүй байдалд тавих шаардлага

5.11.1 Хүнсний сүлжээнд ажиллагсад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд тогтоосон хугацаанд хамрагдсан байна.

5.11.2 Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх, худалдах, түүгээр үйлчилгээ үзүүлэх, хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байна.

5.11.3 Худалдааны газрын лого тэмдэгтэй хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, халат, малгайг өмсөж хэвшсэн байна.

5.12 Бараа, бүтээгдэхүүн худалдаалахад тавих шаардлага

5.12.1 Тухайн дэлгүүрийн төрөлжилттэй нийцсэн барааны нэр төрлийн бүрдэлттэй байна.

5.13 Бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангахад тавих шаардлага

5.13.1 Хүнсний худалдаа эрхлэгч нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөнө.

5.13.2 Бараа бүтээгдэхүүн эрүүл ахуйн шаардлага, аюулгүйн үзүүлэлтийг хангасан эсэхэд хяналт тавьж хаяг шошгоны зөрчил, хуурамч бүтээгдэхүүнийг бүртгэж холбогдох байгууллагад тухай бүр мэдээллэнэ.

5.13.3 Барааг хэрэглэх аюулгүй ажиллагааны талаар зөвлөгөө өгч, хүлээлгэж өгөхдөө техникийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, аюулгүй ажиллагааны санамж, баталгаат хугацааны хуудсыг дагалдуулж олгоно.

5.14 Барааны хадгалалт, тээвэрлэлтэд тавих шаардлага

5.14.1 Барааг бүлэг, дэд бүлгээр ангилан, технологи, хадгалалтын горимын дагуу өрж байршуулан хадгална.

5.14.2 Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд MNS 5346:2017, Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээний стандартыг мөрдөнө.

5.14.3 Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд MNS 5343:2011 стандартыг мөрдөнө.

5.14.4 Ачаа тээвэрлэлтийн нөхцлийн дагуу барааны сав, баглаа боодлыг гэмтээхгүйгээр бэхэлгээ, битүүмжлэл, лац ломбо бүхий зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.



6. Жижиглэн худалдааны газарт тавих нэмэлт шаардлага

6.1 Жижиглэн худалдааны газрын онцлогт тохирсон нэмэлт шаардлага 2 дугаар хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

2-р хүснэгт - Жижиглэн худалдааны газарт тавих нэмэлт шаардлага

	Худалдааны газрын ангилал	хайпермаркет	супермаркет	минимаркет	Ая тухтай дэлгүүр	хүнсний дэлгүүр	ШТС-ын дэргэдэх дэлгүүр	Төрөлжсөн барааны дэлгүүр, аутлет, бугик	Мухлаг
1	Барилга байгууламж, гадна орчны төлөвлөлтөд тавих шаардлага								
1.1	Барилга байгууламжид тавих шаардлага								
1.1.1	Нийтийн орон сууцанд батлагдсан зураг төслөөр худалдаа, үйлчилгээний зориулалтаар баригдсан байх, гадна хаалга нь орчны хаалганаас тусдаа, дотогшоо нэвтрэх хаалгагүй байх	+	+	+	+	+	+	+	-
1.1.2	Худалдан авагчийн хаалга ачаа зөөвөрлөх хаалганаас тусдаа орох, гарах урсгалтай байх	+	+	+	+	+	+	+	-
1.1.3	2 ба түүнээс дээш давхар бол урсгал болон цахилгаан шаттай байх	+	+	±	±	±	±	+	-
1.2	Гадна орчны төлөвлөлтөд тавигдах шаардлага								
1.2.1	Ашигласан, эзэмшсэн, өмчилсөн газраас гадна орчны нийтийн эзэмшлийн зам талбайд тохижилт, ногоон байгууламж хийж, явган хүний замын хог, цас мөсийг тогтмол цэвэрлэж, хальтиргаа гулгаа үүсгэхгүй, орчныг бохирдолгүй байлгах	50 метр			20 метр				
1.2.2	Харуул хамгаалалтын албатай гэрээ байгуулсан байх	+	+	+	+	±	±	±	±
2	Худалдааны газрын дотоод орчны төлөвлөлт								
2.1	Худалдааны талбайн төлөвлөлт								

2.1.1	Барааг уламжлалт лангуугаар худалдах хэлбэрээр худалдааны танхимыг төлөвлөх	-	-	-	-	±	±	-	-
2.1.4	Монгол улсын барилга орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, ерөнхий шаардлага MNS 6423:2013 стандартад нийцсэн телекамерын системээр тоноглогдсон, камерын бичлэгийг хадгалах хугацаа	30 хоног							
2.1.5	Нэг худалдагчийн эзлэх нэгж талбайн доод хэмжээ, м ²	50	50	50	50	40	40	50	20
2.1.6	Лангуу хоорондын зайн доод хэмжээ	1,5 м			1 м				
2.1.7	Тээш хадгалах хэсэгтэй байх	+	+	+	±	±	±	±	±
2.2	Худалдааны бус талбайн төлөвлөлт								
2.2.1	Ажиллагсдын амрах өрөөтэй байх	+	+	+	+	+	+	+	-
2.2.2	Албан ажлын тасалгаатай байх	+	+	+	+	±	±	±	-
2.2.3	Сандал бүхий түр амрах талбайтай байх	+	+	-	-	-	-	+	-
2.3	Хүнсний худалдааны тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл								
2.3.1	Хана хэлбэрээр зохион байгуулсан дээд хэсэгтээ тольгой, гэрэлтүүлэгтэй жимс, ногооны лангуутай байх	+	+	+	+	±	±	±	±
2.3.2	Шалган өнгөрүүлэх, савлах, боох хэсэг	+	+	+	+	±	±	±	-
2.4	Хүнсний бус барааны худалдааны тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл								
2.4.1	Бүтээгдэхүүний үзүүлэнгийн тохижилт	+	±	±	±	±	±	+	-
2.4.2	Бэлэн хувцасны тасгийн бүрэн тохижилт /хувцас солих бүхээг, толь, зөөлөн тавилга/	±	-	-	-	-	-	+	±
2.4.3	Гутлын тасгийн бүрэн тохижилт /хөлийн хэмжээ авагч, гутал өмсгөгч, зөөлөн тавилга/	±	-	-	-	-	-	+	±
2.4.4	Номын дэлгүүрийн бүрэн тохижилт /зөөлөн тавилга, ширээ сандал/	±	-	-	-	-	-	+	±
2.4.5	Тавилгын дэлгүүрийн бүрэн тохижилт	±	-	-	-	-	-	+	±

2.4.6	Цахилгаан барааны дэлгүүрийн бүрэн тохижилт /бүтээгдэхүүн шалгаж хүлээж авах хэсэг/	±	±	±	-	-	-	+	±
3	Худалдааны газрын техник технологи								
3.1	Төлбөрийн системийн тоног төхөөрөмж								
3.1.1	Худалдааны талбайн хүчин чадлаас хамааран кассын машин, төлбөр тооцооны цэг байршуулсан байх /метр/	100	100	100	60	40	40	40	20
3.1.2	Бүтээгдэхүүний дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан QR код уншигч төхөөрөмжтэй байх	+	±	±	±	±	±	±	±
4	Хүний нөөцөд тавигдах шаардлага								
4.1	50 ба түүнээс дээш ажилтантай тохиолдолд эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтныг ажиллуулах, 50-иас доош ажилтантай тохиолдолд гэрээгээр ажиллуулах	+	+	+	+	±	±	±	±
5	Бүтээгдэхүүний нэр төрөл бүрдүүлэлт								
5.1	Органик, эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүний болон хүүхдэд зориулсан тусгай тасаг ажиллуулах	+	+	+	+	±	±	±	±

3.3. Үйлчилээний газрын стандарт

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 03.080.30



Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага	MNS 4946 : 2019
Requirements on foodservice establishments	MNS 4946:2005-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн С/34 дүгээр тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь ресторан, кафе, баар, цайны газар, түргэн хоолны газар, хагас болон бэлэн боловсруулсан бүтээгдэхүүн худалдах дэлгүүр /кулинару/, буфет зэрэг хоолны газарт тавих ерөнхий шаардлагад хамаарна.

2. Норматив эшлэл

Энэ стандартад эш татаж хэрэглэсэн дараах баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас эш татаж хэрэглэнэ.

MNS CAC RCP 1:2003, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчмын дадлын олон улсын зөвлөмжийн дүрэм;

MNS CAC RCP 39:2011, Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл эрүүл ахуйн дадал

MNS CAC RCP 43:2011, Гадна талбайд хоол хүнс бэлтгэх, борлуулах эрүүл ахуйн дадлын дүрэм

MNS 4244:94, Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;

MNS 5078:2001, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага;

MNS 4969:2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм;

MNS 4996:2000, Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага;

MNS 5390:2004, Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;

MNS 6423:2013, Барилга орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, ерөнхий шаардлага;

MNS 5005:2015, Төлбөрийн баримт хэвлэх төхөөрөмж;

MNS 6529:2015, Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримт;

MNS 5343:2011, Хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэх;

MNS 5346:2017, Автогээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ.

MNS 0900:2018, Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын стандарт

3. Хоолны газрын ангилал

3.1 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар /цаашид хоолны газар гэж нэрлэх/-ыг үйлдвэрлэн, худалдаалж буй хоол, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, үйлчлүүлэгчийн онцлог, байршлаас хамааруулан 1-р хүснэгтэд заасны дагуу ангилна.

3.2 Хоолны газар нь үйлдвэрлэн, худалдаалж буй хоол, хүнсний бүтээгдэхүүний нэр төрлөөс хамаарч төрөлжсөн болон төрөлжсөн бус байж болно.

1-р хүснэгт - Хоолны газрын ангилал

Ресторан	Кафе	Баар	Цайны газар	Түргэн хоолны газар	Буфет	Хагас болон бэлэн боловсруулсан бүтээгдэхүүн худалдах дэлгүүр
Үйлдвэрлэн худалдаж буй бүтээгдэхүүний нэр төрлөөр:						
Төрөлжсөн: - Цагаан хоолны; - Далайн бүтээгдэхүүний; Төрөлжсөн бус: - Улс үндэстний;	Төрөлжсөн: - Кофе-шоф; - Амтлаг бүтээгдэхүүн, нарийн боовны; Төрөлжсөн бус:	Төрөлжсөн: - Пиво баар (pub); - Коктейл баар; - Гриль баар; - Суши баар; Төрөлжсөн бус:	Төрөлжсөн: - Бууз, баншны; Цагаан хоолны; Төрөлжсөн бус:	Төрөлжсөн: - Пиццаны; - Бургерийн; - Баншны; Төрөлжсөн бус:	-	-
Үйлчлүүлэгчийн онцлог, байршлаар:						
- Клубын дэргэдэх ресторан; - Зочид буудлын дэргэдэх ресторан, - Аялал жуулчлал, уул уурхайн баазын гэх мэт; - Вагон-ресторан;	- Хүүхдийн кафе; - Кафе-клуб;	- Видео-баар; - Караоке-баар; - Вареете баар; - Билльярд баар; - Диско-баар; - Спортын гэх мэт;	- Нийтийн үйлчилгээний; - Үйлдвэр, албан байгууллага, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх газар, цэргийн анги, эмнэлэг зэрэг нийгмийн салбарын ажилчдад зориулсан - Замын дагуух; - Уул уурхайн, баазын;		- Ху-дал-дааны төв - Ал-бан байгууллагын;	- Хоолны газрын дэргэдэх; - Бие даасан барилга байгууламж бүхий; - Худалдааны төв;

4. Хоолны газарт тавих нийтлэг шаардлага

4.1. Хоолны газар нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын барилга байгууламжтай, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцлийг хангасан байна.

4.2. Хоолны газрыг улсын чанартай автозамаас 50 м-ээс доошгүй зайд байрлаж байхаар төлөвлөнө.

5. Хоолны газрын үйлчилгээ

5.1. Хоолны газрын үйлчилгээ нь дараах хэлбэртэй байна. Үүнд: зөөгчөөр, өөрөө өөртөө, холимог, лангууны араас, тогоочоор, туузан дамжуургаар гэх мэт.

5.2. Хоолны газрын үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн сонирхолд нийцсэн, үйлчилгээний чанар, зэрэглэлийн түвшинг хангасан байна.

5.3. Зориулалтын гал тогоо бүхий хоолны газар нь өөрийн ангилал, зэрэглэлээс хамаарч нэмэлт үйлчилгээг явуулж болно.

5.4. Хүргэлтийн хоол үйлчилгээнд стандартын дагуу хоол, ундааны хадгалалтын нөхцөл, хугацаа, хоолны температурыг мөрдөн тусгай тээвэрлэлтийн, зориулалтын сав баглаа боодол (зориулалтын дулаан баригч, халуун сав, хөргүүр гэх мэт)-ыг ашиглана.

5.5. Гадна талбайн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хоол, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүйн шаардлагыг хангах зорилгоор зориулалтын тоног төхөөрөмж бүхий зөөврийн байгууламжуудыг ашиглана.

5.6. Хүлээн авалтын үйлчилгээ үзүүлж буй хоолны газрууд /ресторан/ нь зочдод зориулсан хүлээлгийн өрөө, хувцас солих өрөө, уран бүтээлчдэд зориулсан өрөөг тусгайлан төлөвлөсөн байна.

5.7. Хоолны газрын үйлчилгээний ажилтнууд нь мэргэжлийн ур чадвартай, харилцааны ёс зүй, хувь хүний эрүүл ахуйн зөв дадлыг эзэмшсэн байна.

5.8 Улс үндэсний хоолны газрын тохижилт, үйлчилгээний ажилтны дүрэмт хувцас нь тухайн үндэстний онцлогийг тусгасан байж болно.

6. Хоолны газрын барилга, байгууламжид тавих шаардлага

6.1. Хоолны газрын барилга байгууламж нь эрх бүхий байгууллагаас баталсан зураг төслийн дагуу баригдсан байна.

6.2. Хоолны газрын барилга байгууламж, инженерийн болон технологийн тоног төхөөрөмжийн хийц, материал нь Монгол улс болон олон улсад мөрдөж буй стандартын шаардлагыг хангасан байна.

6.3. Хоолны газрын барилгын төлөвлөлт нь эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хэрэгжүүлэх нөхцлийг хангасан байна.

6.4. Технологи ажиллагааны дарааллыг баримтлан байрлуулсан тоног төхөөрөмж, ажлын ширээ хоорондын зай нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, цэвэрлэгээ, угаалга, ариутгал, халдваргүйтгэл

хийх боломжтой байна.

6.5. Хоолны газрын барилга, байгууламжийн дуу чимээний хамгаалалт 35 дБ буюу түүнээс доош байна.

6.6. Хоолны газрын үйлдвэрлэлийн үндсэн өрөөнүүдийн өндөр 3,3 м-ээс доошгүй байх ба өөрийн хүчин чадлаас хамаарч мах, ногооны хөргөлттэй агуулах, хуурай бүтээгдэхүүний агуулахтай байж болно.

6.7. Цехийн зохион байгуулалтгүй хоолны газарт түүхий эдийг хүлээж авах, хадгалах, анхан шатны ажиллагаа хийх, сав хэрэгслийн угаалгын ажлын байрыг технологи урсгалыг баримтлахаас гадна гал тогооноос 1,5 м-ээс доошгүй өндөртэй хаалт хамгаалалтаар тусгаарлана.

6.8 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан орох, гарах хаалгын хэсэгт налуу шаттай, зориулалтын тоноглогсон ариун цэврийн өрөөтэй байна.

7. Хоолны газрын орчны тохижилтод тавих шаардлага

7.1. Хогийн сав, хог асгах талбайг цонх, хаалганаас 10-20 метрээс багагүй зайд байршуулж, хуурай, нойтон, дахин ашиглах хог хаягдлаар нь ангилан, битүүмжлэл сайтай саванд хийж, хуваарийн дагуу гэрээт байгууллагаар зайлуулан, халдваргүйжүүлнэ.

7.2. Үйлчлүүлэгчдэд зориулсан амрах цардсан зам талбайтай байж болох ба хүрээлэн буй орчин, ус, агаар, хөрсийг бохирдуулахгүй байх нөхцлийг хангана.

7.3. Хоолны газрын орчны эдэлбэр газрын 10 м-ээс доошгүй талбайд зуны улиралд мод, бут, сөөг тарьж зүлэгжүүлж, хөрсийг нь чийгшүүлсэн, ногоон байгууламжийг бий болгон, орчны цэвэрлэгээг өдөр бүр тогтмол хийдэг байна.

8. Хоолны газрын инженерийн байгууламж, техникийн байдалд тавих шаардлага

8.1. Бүх төрлийн цахилгаан, дулаан, усны шугам хоолойн холболт, сантехник, гэрэлтүүлэг, агааржуулалтын системийн хүчин чадлыг инженерийн зураг төслийн дагуу хийж гүйцэтгэнэ.

8.2. Цэвэр усны хангамж, бохир ус зайлуулах төвлөрсөн шугамд холбогдоогүй хоолны газар нь байгаль орчинд ээлтэй, үйлчлүүлэгчдийн ая тухтай байдал, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай байна. Мөн саарал усыг ашиглах ариун цэврийн инженерийн байгууламжийг нэвтрүүлсэн байж болно.

8.3 Хэсгийн усан хангамжтай байх тохиолдолд ус нөөцлөх зориулалтын савтай, өдөрт хэрэглэх ундны болон аяга, таваг болон гар угаах усны хэмжээг тооцоолсон нөөцтэй байх ба ус нөөцлөх савны эрүүл ахуйн шаадлагыг хангаж ажиллана.

8.4 Хэсгийн усан хангамжтай хоолны газар нь аяга таваг, сав суулга угаах, гар угаах хэсэгт халуун усаар хангах ус халаах бойлерийг өөрийн хүчин чадалд тохируулан суурилуулж, хэвийн ажиллагааг хангасан байна. Эсвэл аяга таваг угаагч машинтай байна.

8.5 Хоолны газар нь аяга таваг, халбага, сэрээ, савх зэргийг ариутгагч төхөөрөмжтэй, ашиглалтын бүртгэл хөтлөлттэй байна.

8.6 Үйлчилгээний хэсгийн өрөө, тасалгааны температур 21-23 °С, 60-65 %-ийн чийглэгтэй байна.

8.7 Үйлчилгээний танхим, үйлчлүүлэгчдийн орох хэсэг, үйлдвэрлэлийн болон сав угаалгын өрөөнүүд агаарын хэвийн солилцоог хангах, ялангуяа хийн зуух ашигладаг бол агаарын солилцоог сайжруулахад чиглэгдсэн ердийн болон механик агааржуулалт, салхивчтай байна.

8.8 Үйлдвэрлэлийн өрөө, үйлчилгээний танхим нь байгалийн болон зохиомол, аваарын гэрэлтүүлэг, утаа мэдрэгч дохиолол, харуул хамгаалалтын камерын системтэй байна.

8.9 Гурваас дээш давхарт байрласан хоолны газарт үйлчлүүлэгчдийн болон үйлдвэрлэлийн зориулалттай цахилгаан шатыг тус тусад нь төлөвлөнө.

8.10 Тоног төхөөрөмжийн угсралтыг цахилгаан техникийн тооцоонд тулгуурлан хөдөлмөрийн болон техникийн аюулгүй байдлын ханган суурилуулж, газардуулга хийсэн байна.

8.11 Агааржуулалтын систем нь хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй харшил үүсгэгч хурц үнэр гаргахгүй, утаа, хиншүү, тоос шорооны бохирдлыг бууруулах, хортон шавж, мэрэгчид үржихгүй байх нөхцлийг хангасан, хүчин чадалдаа тохирсон байна.

8.12 Нийтийн эзэмшлийн орон сууцны зориулалтыг өөрчлөн хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг төлөвлөхгүй.

8.13 Техник, тоног төхөөрөмж бүр ашиглалтын гэрчилгээтэй, засвар үйлчилгээ хийсэн бүртгэл хөтөлнө.

9. Хоолны газрын галын аюулгүй байдалд тавих шаардлага

9.1. Барилга байгууламжийн галын аюулгүйн дүрэмд тавих шаардлагыг хангасан, хамгаалалтын систем дохиололтой, гал унтраах хэрэглэлтэй, гал тэсвэршилтийн I-IV зэрэглэлтэй байна.

9.2. “MNS 5390:2004, Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” стандартын дагуу барилга байгууламж нь онцгой байдлын үед аврах шат, онцгой байдлын үед авах арга хэмжээний зааврууд, хэрэглэгчдийг чөлөөтэй чиглүүлэх мэдээлэл бүхий тэмдэглэгээг хэрэглэгчдэд харагдахуйц байдлаар байрлуулсан байна.

9.3. Аваарын хаалга нь гадагш чиглэсэн байна.

9.4. Хоолны газрын хонгил, шатны эргэх хэсэг, үйлдвэрлэлийн өрөөнд галд тэсвэргүй материалаар хийсэн хулдаас, хивсэнцэр дэвсэхийг

хориглоно.

9.5. Техник, тоног төхөөрөмж, цахилгааны монтажийг галын аюулгүйн болон техник ашиглалтын дүрмийн дагуу угсарсан байна.

9.6. Хийн зуухтай газар нь эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагаар дүгнэлт, үнэлгээ хийлгэн баталгаажуулж, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах галын аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

10. Хоолны газарт тавих эрүүл ахуйн шаардлага

10.1. Хоолны газрын орчин нь цардмал зам талбайтай байна.

10.2. Эрүүл ахуйн зохистой дадлын зөвлөмж, дүрэм, заавар, хөдөлмөрийн аюулгүй байдлын зохих норм дүрэм, зааврыг мөрдөж ажиллана.

10.3. Халуун боловсруулалтын технологийн шат дамжлагын хэсэг, бэлтгэх цех, өрөөний гэрэлтүүлэг нь 220 люксээс багагүй байна.

10.4 Цахилгаан тасарсан үед цахилгаанаар хангах эх үүсгүүртэй байна.

10.5 Ажилчдын ажлын хувцасны өрөө, шүүгээг гадуур хувцасны шүүгээнээс тусдаа байхаар зохион байгуулсан байна.

10.6 Хоолны газрын ажилтан нь тогтоосон хугацаанд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдсан байна.

11. Хоолны газрын технологи ажиллагаанд тавих шаардлага

11.1. Халуун, хүйтэн хоол, ундааны нэр төрөл бүрт технологийн заавар, жор, орцийг тусгасан картыг боловсруулан баталж, мөрдөж ажиллана.

11.2. Хоолны цэсэн дээр хоолны шим тэжээл, давсны болон сахарын агууламжийг тодорхойлж бичсэн байна. Хоолны шим тэжээлийн, илчлэг, давсны агууламжийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж, баталгаажуулсан байна.

ТАЙЛБАР: Дотоод хяналтын хүрээнд тооцооны аргаар нягталж бүртгэл хөтлөнө.

11.3. Хоолны газар нь үйлчлүүлэгчийн хүсэлтээр хоолны хачир, сүүмс, амтлагч, давсны хэмжээг сонгуулж үйлчилж болно.

11.4. Шөлтэй хоолыг +75 °C-аас доошгүй, хоёрдугаар хоолыг +65 °C-аас доошгүй, хүйтэн хоол, зууш, салатыг +14 °C температурт 2 цагаас дээшгүй хугацаагаар хадгалж, үйлчлүүлэгчдэд олгоно. Хоол олгох үеийн температурыг хэмжиж, бүртгэл хөтөлнө.

12. Хоолны газрын хүний нөөцөд тавих шаардлага

12.1. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар нь дор дурдсан хүний нөөцийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- удирдлага-зохион байгуулалтын /менежер, технологич эсвэл хоол үйлдвэрлэлийн асуудал хариуцсан ажилтан, нярав, нягтлан бодогч/

- үйлчилгээний /танхимын зохион байгуулагч, үйлчилгээний менежер, зөөгч, бармен, бартендер, бариста, дарсны мэргэжилтэн, кассчин, буфетийн худалдагч, зочин угтагч/
- үйлдвэрлэлийн /ерөнхий тогооч, ахлах тогооч, шөлний тогооч, тогооч, эмчилгээний хоолны тогооч, талх, нарийн боовны тогооч, туслах тогооч/
- туслах ажилтан /угаагч, цэвэрлэгч, хаалгач, өлгүүрийн ажилтан, нярав, ачигч/

12.2 Хоолны газрын удирдлага-зохион байгуулалтын ажилтан нь мэргэжлийн боловсон хүчин байна.

12.3 Үйлдвэрлэл, үйлчилгээний үндсэн ажлыг зөвхөн тухайн мэргэжлийн зэрэг /түвшин/-тэй эсвэл мэргэшсэн ажилтан гүйцэтгэнэ.

12.4 Хоёроос дээш салбартай сүлжээ хоолны газар эсвэл 35 хүртэлх ажилтантай хоолны газар нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны ажилтан, хоол зүйч, эрүүл ахуйчийг ажиллуулна.

12.5 Хоолны газрын ажилтан нь өөрийн ажлын байрын тодорхойлолтод заасны дагуу хөдөлмөр хамгаалал, техник аюулгүйн ажиллагааны болон эмнэлгийн анхны тусламжийн мэдлэгтэй байна.

12.6 Ажилтан, ажилчдыг сургах сургалтын төлөвлөгөөтэй, сургалтын хөтөлбөр нь хоол үйлдвэрлэлийн салбарт гарч буй дэвшилтэт технологи, хөдөлмөр хамгаалал, хүний эрүүл мэнд, хоол болон үйлчилгээний чанар, аюулгүй байдал, ариун цэвэр, эрүүл ахуйн зохистой дадал, үйлдвэрлэлийн зохистой дадал, аюулын дүн шинжилгээ, эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцооны талаарх агуулгыг багтаасан байна.

12.7 Сургалтыг ажлын цагийн 10-аас дээшгүй хувьд нь сургалт явуулсан, үр дүнг нь тооцсон бүртгэл, тэмдэглэл хөтөлсөн байна.

12.8 Ажилтнуудын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх зорилготой мэдээллийн самбарыг ажлын байранд байршуулан, мэдээллийг цаг тухай бүр шинэчилдэг байна.

13. Техникийн шаардлага

13.1 Хоолны газар нь “А” хавсралтад заасан шаардлагыг хангасан байна.

А Хавсралт
(норматив шаардлага)

ХООЛНЫ ГАЗАРТ ТАВИХ ШААРДЛАГА

№	Шаардлага		Нийтийн үйлчилгээний			Зочид буудлын дэргэдэх	Буфет	Түргэн хоолны газар	Цайны газар			Хагас болон боловс-руулсан бүтээгдэхүүн худалдах дэлгүүр
			ресторан	Кафе	Баар				Нийтийн үйлчилгээний	Сумын болон замын дагуух*	Албан газрын дэргэдэх	
1.	Гадаад орчин											
1.1	Барилга байгуу-ламж	Зориулалтын дагуу зураг төслөөр төлөвлөгдөн баригдсан	+	+	+	+	±	+	+	+	+	+
		Зориулалтын болгон өртөгтгөж завсарласан	±	-	-	±	-	±	±	-	"	
1.2	Хаяг	Хаяг, гэрлэн чимэглэлтэй	+	+	+	+	-	+	+	+	-	+
		Ил байрласан ажиллах цагийн хуваарьтай	+	+	+	-	+	+	+	±	+	
1.3	Үүдний хэсэг	Зам талбай нь цардмал хучилттай, зүлэгжүүлэлт, тохижилт хийсэн,	+	+	+	+	-	+	+	+	+	+
		Шат довжоо нь хальгирч гулгахааргүй, хажуу хашлага, бариултай байх	+	+	+	-	+	+	+	±	+	
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам, бариул	+	+	+	-	+	+	+	+	+	
1.4.	Бу-сад	Үйлчлүүлэгч, ажилтны орох хаалга тусдаа	+	+	+	+	-	+	+	+	±	+

2	Дотоод зохион байгуулалт											
2.1	Үйлчилгээний танхим дахь чийглэг, температурын автомат тохируулга бүхий агааржуулалт, халаалтын систем, төхөөрөмж		+	+	+	+	+	+	+	-	±	-
2.2	Орох хэсэг	Үүдний өрөө	+	+	+	+	+	-	±	-	-	-
		Хаалганы халаагуур, агааржуулагч сэнс	+	+	+	-	+	+	+	-	-	-
		Хувцасны өлгүүр /суудлын тоотой тэнцүү буюу 10%-иар илүү, үүний 30% нь мөр өлгүүр байна/, үйлчилгээний танхимд байрлуулахгүй байна.	+	+	+	+	+	+	+	+	-	-
		Хэрэглэгчийн эд зүйлс, тээш /үүнд үнэт зүйл хамаарахгүй/ хадгалах шүүтээ	+	±	-	+	-	-	-	±	-	-
2.3	Ариун цэврийн өрөө	Ариун цэврийн өрөө /30 хүртэл суудал тутамд эр, эм тус бүр нэгээс дээш суултуур/	+	+	+	+	+	+	+	+	±	-
		Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан суултуур	+	+	+	+	-	+	+	+	-	+
		Хүүхэд хуурайлах ширээ	+	+	-	+	-	+	±	+	-	-
		Угаалтуур	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Гар хатаагч	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Цаасан салфетка	+	+	+	+	+	+	+	+	-	+
		Шингэн саван	+	+	+	+	+	+	+	+	+	+
2.4	Төвлөрсөн буюу хэсгийн халаалт /цахилгаанаар/		+	+	+	+	+	+	+	±	+	+
2.5.	Галын аюулгүй ажиллагаа	Утаа мэдрэх дохиоллын систем	+	+	+	+	+	+	+	±	+	+
		Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Гал унтраах автомат төхөөрөмж	+	+	+	+	+	+	+	+	+	+
2.6.	Камерийн систем		Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер. Ерөнхий шаардлага MNS 6423 :2013 стандарт шаардлагыг хангана.									

3. Үйлчилгээний танхим												
3.1.	Зохион байгуулалт	Нэг суудалд ногдох үйлчилгээний танхимын талбай / м ² -аас доошгүй/	2.0-2.6	1.8	2.0	2.6	1.8	1.8	1.5	1.5	1.5	1.0
		Тусгай зориулалтын үйлчилгээний өрөө(VIP)	+	±	±	+	-	±	-	-	-	-
		Бармений тоног төхөөрөмж	+	-	+	+	-	-	-	-	-	-
		Баристагийн тоног төхөөрөмж	+	+	-	+	+	-	-	-	-	-
		Баарны лангуу	+	+	+	+	+	-	-	-	-	-
3.2	Тохижилт	Үйлчилгээний онцлогийг тусгасан чимэглэл, тохижилттой	+	+	+	+	+	+	+	+	+	±
		Бүжгийн талбай, хөгжмийн тайз	±	-	+	+	-	-	-	-	-	-
		Хүүхдэд зориулсан өрөө эсвэл тохижуулсан хэсэг	±	±	-	+	+	+	±	-	-	-
		Хөгжмийн хэрэгсэл	+	+	+	+	-	-	-	-	-	-
3.3.	Ширээ	Үйлчилгээний төрөл, ангилалд тохирсон ширээ	+	+	+	+	+	+	+	+	-	+
		Хүүхдийн ширээ	±	+	-	+	+	±	+	-	-	-
3.4.	Сандал	Зөөлөн	+	+	+	+	+	±	±	-	-	-
		Хагас зөөлөн	±	+	+	-	-	±	±	-	-	-
		Хүүхдийн сандал	+	+	-	+	+	+	+	+	-	-
3.5.	Бусад тоног төхөөрөмж, тавилга	Зөөгчийн туслах ширээ	+	-	+	+	+	+	+	-	-	-
		Кассын машин, компьютер	+	+	+	+	+	+	+	+	-	-
		Төлбөрийн баримт, НӨАТ-ын баримт олгох машин	+	+	+	+	+	+	+	+	+	+
		Өрөөний үйлчилгээний тэргэнцэр, сав хэрэгслийн иж бүрдэл	±	-	-	+	+	+	-	-	-	-
		Өглөөний хоолны үйлчилгээ хийх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн иж бүрдэл	±	-	-	+	±	±	-	-	-	-
4.	Хоол үйлдвэрлэлийн байранд тавих шаардлага											

4.1	Үйлчилгээний заалны нэг суудалд ноогдох технологийн дагуу зохион байгуулсан үйлдвэрлэлийн талбай/ гал тогоо /м ² -аас доошгүй/	1,27	0,87			1,27	0,87				
4.2	Технологи ажиллагааны шугам нь нэг чигийн урсгалтай	+	+	+	+	+	+	+	+	+	+
4.3	Тоног төхөөрөмж	Дулааны болон хөргөлтийн иж бүрдэл тоног төхөөрөмж	+	+	+	+	+	+	+	±	+
4.4		Дээжийн хөргөгч, хоолны дээжийн бүртгэлийн дэвтэртэй	+	+	+	+	+	+	+	+	+
		Аяга таваг угаагч төхөөрөмж	±	+	+	+	+	+	+	+	+
		Аяга таваг ариутгах төхөөрөмж	+	+	+	+	+	+	+	+	+
4.5	Үйлдвэрлэлийн зориулалттай багаж, хэрэгсэл	Зориулалтын ажлын ширээ	+	+	+	+	+	+	+	+	+
		Тогоочийн багаж хэрэгсэл	+	+	+	+	+	+	+	+	+
		Зориулалтын ган, никелийн харьцаа нь 18/10 бүхий сав суулга	+	+	+	+	+	+	+	+	+
		Давс хэмжигч халбага	+	+	+	+	±	±	+	±	±
		Термометр / электрон/	+	+	+	+	+	+	+	+	+
		Жин /түүхий эд хүлээн авах болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах нарийвчилалтай/	+	+	+	+	+	+	+	+	+
		Түүхий болон бэлэн бүтээгдэхүүний тусдаа өнгөөр ялгасан гампанз, хутга	+	+	+	+	+	+	+	+	+
4.6	Зориулалтын тавиур, хоол халуун байлгах төхөөрөмж	+	+	+	+	+	+	+	±	-	+
4.7	Үйлчилгээний аяга, таваг, багаж хэрэгсэл /нэг суудалд ноогдох эргэлтийн тоо/	2 дахин их нөөцтэй									

4.8	Цэвэр ус нөөцлөх таглаатай зориулалтын сав, ус халаах бойлер	-	-	-	-	+	-	+	+	-	-
4.9	Агаар сэлгэх хоолой бүхий агааржуулалтын систем	“Үйлдвэрлэлийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага”MNS 5078:2001									
5.	Туслах байр										
5.1	Хөргөлттэй агуулах / температур хэмжигч бүхий/	±	±	±	+	+	+	+	±	+	-
5.2	Хөргөх, хөлдөөх төхөөрөмж	+	+	+	+	+	+	+	+	+	+
5.3	Хуурай хүнсний агуулах, /температур, чийглэг хэмжигчтэй/	+	+	+	+	+	+	+	±	+	-
5.4	Ногооны агуулах / температур, чийглэг хэмжигчтэй/	+	+	+	+	+	+	+	+	+	-
5.5	Үйлчилгээний зориулалтын хэрэглэлийн өрөө, шүүгээ /ширээний бүтээлэг, төрөл бүрийн салфетка г.м/	+	+	+	+	+	±	+	±	+	-
5.6	Сав, багаж хэрэгслийн агуулах шүүгээ	+	+	+	+	+	+	+	+	-	-
5.7	Ажилчдын ариун цэврийн өрөө	+	+	+	+	+	+	+	+	+	+
5.8	Ажилчдад зориулсан шүршүүр	+	±	±	+	+	+	±	±	±	±
5.9	Ажилчдын амрах өрөө	+	+	+	+	+	+	+	+	+	+
6.	Үйлдвэрлэл										
6.1	Түүхийэд, бүтээгдэхүүний гарал үүсэл баталгаажуулалтын дагалдах бичиг, ул мөрийн бүртгэлийн дэвтэр	+	+	+	+	+	+	+	+	+	+
6.2	Нарийн технологитой олон нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	+	±	+	+	+	-	-	-	-	-
6.3	Нэршсэн болон захиалгат хоолны үйлдвэрлэл	+	±	±	+	+	-	-	-	-	-
6.4	Талх, нарийн боовны үйлдвэрлэл	+	±	±	+	+	+	±	±	±	±
6.5	Баглагдсан хоол үйлдвэрлэлийн технологийн карт, цэс	+	+	+	+	+	+	+	+	+	+
6.6	Хоолны температур хэмжсэн бүртгэл хөтлөлт	+	+	+	+	+	+	+	+	+	+
7.	Үйлчилгээ										

7.1	Ширээ засалт, үйлчилгээний бэлэн байдал		+	+	+	+	+	+	+	+	+	-
7.2	Барменаар үйлчлэх		+	+	+	+	+	+	-	-	-	-
7.3	Зөөгчөөр үйлчлэх		+	+	+	+	+	±	±	±	-	-
7.4	Бартендрээр үйлчлэх		±	+	+	+	±	±	+	+	±	+
7.5	Баристагаар үйлчлэх		±	+	+	+	±	+	+	-	±	-
7.6	Өглөөний хоолны үйлчилгээ		+	+	+	+	+	-	-	-	-	+
7.7	Хоолны цэс:											
	Үйлчилгээний онцлогийг тусгасан эмблем бүхий хавтас		+	+	+	+	+	-	-	-	-	-
	Монгол, англи хэл дээр дарааллын дагуу бичсэн, хоол, ундааны хэвлэмэл цэс /орц, хачир, сүмсний тайлбар/		+	+	+	+	+	+	+	+	±	+
	Хоолны шим тэжээлийн найрлага, давс, сахарын хэмжээг тодорхойлж, тусгасан		+	+	+	+	+	+	+	+	+	+
	Хүүхдийн хоолны цэс		+	+	-	+	+	+	+	+	±	±
7.8	Цэнгүүн	Хөгжимчин, төрөл бүрийн хөгжмийн зэмсэг	±	-	+	+	-	-	-	-	-	-
		Цэнгүүнд зориулсан хөтөлбөртэй тоглолт	±	-	+	+	-	-	-	-	-	-
8.	Үйлчилгээний сав, багаж хэрэгсэл, даавуун эдлэл											
8.1	Болор нэг загварын шилэн эдлэлийн иж бүрдэл		±	+	+	±	±	±	-	-	-	-
8.2	Нэг загварын шаазан эдлэл /зориулалт тус бүрээр/		±	+	+	+	+	+	+	+	±	±
8.3	Ган эдлэл /ган, никелийн харьцаа 18/10/, багаж хэрэгсэл		+	+	+	+	+	+	+	+	+	+
8.4	Нэг удаагийн /зөөврийн/ хүнсний зориулалтын аяга таваг, багаж хэрэгсэл /эрүүл ахуйн шинжилгээнд шинжлүүлсэн, баталгаажуулсан байна/		+	+	+	+	+	+	+	+	±	+
8.5	Ширээний зөөлөвч, бүтээлэг, тавагны суурь		+	+	+	+	+	-	±	±	±	+
8.6	Зориулалтын даавуун болон цаасан амны алчуур		+	+	+	+	+	+	+	+	+	+
8.7	Ариутгасан, чийгтэй халуун алчуур		+	+	+	±	+	+	±	+	±	-
9.	Хүний нөөцөд тавих шаардлага											

